



ХСУХАТАУЗЗ



Шинжлэх Ухааны  
Академи



Дорноговь аймгийн  
ЗДТГ

unicef   
НҮБ-ын Хүүхдийн Сан

# ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨВ БОЛОН СУМ, СУУРИН ГАЗРЫН УНДНЫ УСНЫ ЧАНАРЫН СУДАЛГАА

/Албан хэрэгцээнд/

Улаанбаатар хот  
2022 он

## Судалгааны ажлыг гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн

Гүйцэтгэгч:	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл ШУА-ийн, Хими, химийн технологийн хүрээлэн
Төслийн удирдагч:	Ж.Батсуурь /ХСУХАТАҮЗЗ-ийн дарга, доктор/
Төслийн зохицуулагч:	Б.Амарсанаа /Шинжлэх Ухааны Паркийн гүйцэтгэх захирал, доктор/ Д.Оюунцэцэг /ХХТХ, Экологийн химийн лабораторийн эрхлэгч, ЭШАА, доктор/
Төслийн зөвлөх:	Б.Доржбат /ХСУХАТАҮЗЗ-ийн Захиргаа, удирдлагын газрын дарга/ М.Бүрнээ /АШУҮИС-ийн Биоанагаахын сургуулийн ахлах багш, доктор/
Төслийн ахлах ажилтан:	Л.Баттөмөр /ХСУХАТАҮЗЗ-ийн Захиргаа, удирдлагын газрын ахлах мэргэжилтэн/ Д.Сэлэнгэ /ХСУХАТАҮЗЗ-ийн Захиргаа, удирдлагын газрын ахлах мэргэжилтэн/ Б.Мөнхзаяа /ХСУХАТАҮЗЗ-ийн Захиргаа, удирдлагын мэргэжилтэн/
Төслийн ажилтнууд:	Б.Баясгалан /ХСУХАТАҮЗЗ-ийн Жолооч/ Т.Түвшинжаргал /“Засгийн газрын автобааз” УТҮГ-ын Жолооч/
Шинжлэх ухааны академи, Хими, химийн технологийн хүрээлэнгийн Экологийн химийн лаборатори:	О.Хүрэлдаваа /Хими-технологич, ЭШДэА, доктор/ Г.Одонтүяа /Хими-байгаль шинжлэл, ЭШДэА, магистр/ А.Цийрэгзэн /Экологич-химич, ЭШДэА, магистр/ Б.Дариймаа /Биоимформатикч, ЭШДаА, магистр/ Г.Дуламсүрэн /Биологич, биотехнологич, ЭША/ А.Ичинноров /Химийн инженер, ЭША/ З.Буюнжаргал /Хэрэглээний хими, ЭША/

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ШУА	Шинжлэх ухааны академи
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ОНӨ	Орон нутгийн өмчит
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗДТГ	Засаг Даргын Тамгын газар
ОХУ	Оросын холбооны улс
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө засах орон
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл Мэндийн Төв
“УБТЗ” ХНН	“Улаанбаатар төмөр зам” Хувь Нийлүүлсэн Нийгэмлэг
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭШАА	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
ЭШДэА	Эрдэм шинжилгээний дэд ажилтан
ЭШДаА	Эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан
ПИЧ	Перманганат исэлдэх чанар
д.т.д	Далайн түвшнээс дээш
MNS	Монгол Улсын стандарт
ЗДА	Зөвшөөрөгдөх дээд агууламж
pH	Усны орчин pH /power of hydrogen/
ЦДЧ	Цахилгаан дамжуулах чанар
ГБННТ	Гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо
ННТ	Нийт нянгийн тоо
ХТГБН	Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян
E.Coli	Escherichia coli
ЕС	EIEC $\mu$ S/cmtrical conductivity
ICP	Inductively Coupled Plasma
NTU	Нефлометрийн булингаршлын нэгж
SGS	General Society of Surveillance
TDS	Total dissolved solids

## АГУУЛГА

<b>1. ЕРӨНХИЙ ХЭСЭГ</b>	5
1.1. Дорноговь аймгийн ус хангамжийн өнөөгийн байдал	6
1.2. Усны чанар аюулгүй байдал	7
1.3. Төслийн зорилго, зорилт	7
1.4. Усны химийн найрлага, шинж чанар	8
<b>2. СУДАЛГААНЫ ОБЪЕКТ, АРГА ЗҮЙ</b>	11
2.1. Судалгааны объект	11
2.2. Гидрохимийн судалгааны арга зүй	11
2.3. Бичил амь судлалын судалгааны арга зүй	14
<b>3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН</b>	18
3.1. Сайншанд сум	18
3.2. Айраг сум	58
3.3. Алтанширээ сум	69
3.4. Даланжаргалан сум	76
3.5. Дэлгэрэх сум	88
3.6. Замын-Үүд сум	95
3.7. Иххэт сум	112
3.8. Мандах сум	122
3.9. Өргөн сум	129
3.10. Сайхандулаан сум	136
3.11. Улаанбадрах сум	143
3.12. Хатанбулаг сум	151
3.13. Хөвсгөл сум	173
3.14. Эрдэнэ сум	177
<b>4. ДҮГНЭЛТ</b>	185
<b>5. СУДАЛГААНЫ ҮР ДҮНД ТУЛГУУРЛАН ТООЦСОН АЮУЛГҮЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ УСААР ХАНГАГДАЖ БАЙГАА ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ</b>	192
<b>6. ЗӨВЛӨМЖ</b>	195
<b>7. АШИГЛАСАН МАТЕРИАЛ</b>	205
<b>8. ХАВСРАЛТ</b>	207

## 1. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

Аливаа улс орнуудын хөгжил дэвшилд нөлөөлөх үндсэн хүчин зүйлсийн нэг нь цэвэр, цэнгэг ус байдаг. Ус бол стратегийн чухал түүхий эд төдийгүй хүнсний гол бүтээгдэхүүн юм. Цэвэр цэнгэг усны нөөцийг нэмэгдүүлэх, бохирдож хомсдохоос хамгаалах, түүнийг зохистой ашиглах, усан орчны экосистемийг алдагдуулахгүй байх нь дэлхий нийтийн анхаарлын төвд байдаг чухал асуудал юм.

НҮБ-ын 2015 оны дээд чуулганаар хүн төрөлхтний өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр Тогтвортой Хөгжлийн 17 зорилтууд батлагдсаны 6-д “Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах” зорилт тавигдсан. Монгол Улс 2020 онд “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого батлан гаргасан бөгөөд бодлогын Ногоон хөгжлийн зорилтын хүрээнд шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг 2025 онд 85, 2030 онд 87, 2050 онд 90 хувьд тус тус хүргэх зорилт тавин ажиллаж байна. Ийнхүү хүн амаа баталгаат ундны усаар хүртээмжтэй хангах нь Монгол Улсын Засгийн газрын нэн тэргүүний зорилгын нэг болоод байна.

Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө хүн амын унд, ахуйн усны чанарын асуудлыг бодлогын түвшинд авч үзэн, эхний ээлжинд Монгол Улсын аймаг, сумын төв, суурин газруудын байгалийн усны химийн найрлагыг бүс нутгийн хэмжээгээр судлах, хүн амын унд, ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэх усны найрлагыг шинжлэн, чанарын шаардлага хангахгүй эрдэсжилт, хатуулаг ихтэй усыг цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх замаар байгалийн усыг зүй зохистой ашиглах технологийг боловсруулан, амьдралд нэвтрүүлснээр цэнгэг, зөөлөн ус хэрэглэдэг хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх нь улс орны эдийн засаг нийгмийн харилцаа улам гүнзгийрч байгаа өнөө үед төрөөс явуулж байгаа эдийн засгийн бодлоготой эн чацуу тавигдаж байна.

Үүнтэй холбогдуулан Дорноговь аймгийн төв, суурин газрын ундны усны чанарын судалгаа, мэдээллийн сан үүсгэх, түүнд тулгуурлан ундны усны чанарыг сайжруулах техник технологийн шийдэл боловсруулах зүй ёсны шаардлагад нийцүүлэн энэхүү дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Манай улсын томоохон хот, суурины гадаргын болон гүний ус, хөрс, агаарын бохирдол стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс давах тохиолдол байнга ажиглагдаж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх боллоо. Байгаль орчны энэхүү тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гол арга зам нь төлөвлөлт, удирдлагын арга хэлбэрийг боловсронгуй болгох, байгаль орчны төлөв байдал, даацыг тодорхойлох, болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан тогтоох, хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэх тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.

Иймд Дорноговь аймгийн хүн амын ундны усны чанарын судалгаа хийж, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл, Шинжлэх Ухааны Академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын баг тус аймгийн “Чандмань-Илч” ХХК-тай хамтран энэхүү суурь судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.

Судалгааны багийн ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлж ажилласан “Чандмань-Илч” ХХК, Дорноговь аймгийн болон нийт сумдын Засаг даргын Тамгын газрын хамт олонд талархлаа илэрхийлье.



Зураг. Ундны усны чанарын судалгааны ажлаар явсан баг

### 1.1. Дорноговь аймгийн ус хангамжийн өнөөгийн байдал

Дорноговь аймаг нь 1931 онд байгуулагдсан бөгөөд Монгол орны зүүн өмнөд хязгаарт Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай мөн БНХАУ-тай хил залган оршдог. Тус аймаг 109,472.30 км<sup>2</sup> газар нутагтай, засаг захиргааны нэгжийн хувьд 14 сум, 63 багтай, 2021 оны жилийн эцсийн статистикийн мэдээгээр 20,494 өрхийн 71 мянган хүн амтай байна. Аймгийн төв Сайншанд хот нь Улаанбаатар хотоос 450 км зайтай, хойд, урд хоёр гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг.

Тус аймгийн нутаг дэвсгэр бүхэлдээ говийн бүсэд багтдаг боловч өмнөд хэсэг нь говь, хойд хэсэг нь говь, тал хээр хосолсон байдаг. Дорноговь аймгийн нутагт том гол мөрөн, нуур байхгүй хэдий ч Халзан уул, Бүсийн Чулуун, Толь булаг зэрэг рашаан устай. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, зуны улиралд +41<sup>0</sup>С, өвлийн улиралд -40<sup>0</sup>С, жилийн салхины дундаж хурд 4.2-4.6 м/сек, зарим үед 35 м/сек хүрдэг байна. Аймгийн эдийн засгийн суурь салбар нь уул уурхай, зам тээвэр, аж үйлдвэр голлодог. Мөн тус аймгийн Замын-Үүд сум нь Монголоос Хятад руу гарах хилийн том боомт юм. 2002 оноос Ханги боомт (Хатанбулаг сум) байнгын үйл ажиллагаа явуулж байна. Дорноговь аймаг нь өнөөгийн соёлт хүн төрөлхтний мөнхийн бүтээл болох ноён хутагт Данзанравжаагийн шашин, түүх, бичиг, соёлын өв дурсгалыг хадгалж үлдсэн өлгий нутаг юм.

Дорноговь аймаг нь ус зүйн сүлжээгээр Галба-Өөш-Долоодын говийн сав газарт хамаарагддаг. Тус аймаг гадаргын ус багатай 2017 оны усны тооллогоор гол горхи 1, булаг шанд 289, рашаан 6, нуур тойром 111 бүртгэгджээ. Гадаргын усны эх үүсвэрийг хэдийгээр мал болон хүн амын унд, ахуйд хэрэглэж байгаа боловч, ашиглах боломжит нөөц байхгүй гэж үздэг. Тус аймагт одоогийн байдлаар газар доорх усны нийт 14 орд судлагдсан байна. Дорноговь аймаг нь гидрогеологийн мужлалаар говь хээрийн бүсэд хамаарах ба ус агуулагч чулуулгийн бүтэц, геологийн тогтцоос хамаарч дараах уст үе, цогцолборуудад хуваагдана. Үүнд:

- ❖ Дөрөвдөгчийн уст үе: Ус агуулагч чулуулаг нь янз бүрийн ширхэгтэй элс, хайрга, хайрганцар, бул чулуу зэргээс бүрэлдэн заримдаа шавар, шаваранцартай үелэн байрласнаас түрлэгтэй ус агуулна.

- ❖ Палеоген-неогены хурдас, чулуулгийн уст үе: Нутгийн нилээд хэсэгт тархсан ба элсэн чулуу, хөрзөн, зануужин, шавар үетэй хайрга, бул чулуу, хайрганцар дайрга, ац цавтай занар зэрэг чулуулгаас тогтоно.

Дорноговь аймгийн Сайншанд хотын ус хангамжийн эх үүсвэр нийлбэрээр 300 м<sup>3</sup>/хон ундаргатай 517 ба 518-р цооногийг ОХУ-ын Буровод байгууллагаас ерөмдөж гаргасан бөгөөд 1983-1985 онд хотын төвлөрсөн ус хангамжид зориулан Ч.Борчулуун, С.Ганхуяг нар гидрогеологийн эрэл хайгуул хийж Хөтөл нуур, Хар цавын орчимд Зээгийн хөтлийн ордыг Сайншандаас урагш 20 орчим километр зайд илрүүлж, усны нөөцийг А зэргээр 4968 м<sup>3</sup>/хон гэж тогтоожээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын албан байгууллага, аж ахуй нэгж, иргэд хэрэглэгчид, орон сууцанд оршин суугчдын усан хангамж, ариутгах татуурга, дулаан хангамж, хот тохижилтын ажил үйлчилгээг “Чандмань-Илч” ХХК хариуцаж ажиллаж байна. Тус компани нь цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах, дулаан хангамж, шугам хоолойн ашиглалт, засвар үйлчилгээ үзүүлэх гэсэн төвийн 2 хэлтэс, 5 алба, сумдын 7 салбартай, нийт 300 гаруй ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын эх үүсвэрийн худгуудад Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т заасны дагуу энгийн болон эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоолгон, хамгаалалтын бүсийн хашаа барьсан байна.

### 1.2. Усны чанар аюулгүй байдал

Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.1-д заасан “Ус хангагч байгууллагад Усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх” 2.1.2-д “Жижиг суурин газарт усны аюулгүй байдлын төлөвлөгөөг тухайн орон нутгийн онцлог хүн амын тоо, ус хангамжийг харгалзан зааврын дагуу боловсруулж хэрэгжүүлнэ” 2.2.9-д “Ундны ус хангамжийн зориулалттай гүний худгуудын усны чанарын мониторингийн судалгааг тогтмол хийж, онлайн мэдээллийн систем байгуулж, ундны усны чанарыг сайжруулах зорилгоор тохирох шүүлтүүр суурилуулах арга хэмжээ авах” гэсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд энэхүү судалгааны үйл ажиллагаа чиглэгдэж байна.

Усны аюулгүй байдлын төлөвлөгөө нь ус олборлох эх үүсвэрээс эцсийн хэрэглэгч хүртэлх ус хангамжийн тогтолцоог бүхэлд нь хамарсан эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагын арга хэмжээ юм. Эрүүл мэндийн сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2017 оны А/149, 178 тоот тушаалаар “Хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах заавар”-ыг баталснаар Засгийн газрын зорилтыг хэрэгжүүлэх, тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчин бүрдсэн байна.

### 1.3. Төслийн зорилго, зорилт

Энэхүү төсөл нь Дорноговь аймгийн төв, суурин газрын нийтэд түгээж буй гүний болон эх үүсвэрийн худгийн усанд нарийвчилсан судалгаа явуулж, усны чанарыг үнэлэн зөвлөмж гаргах, мэдээллийн сан үүсгэх зорилготой. Зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьсан болно. Үүнд:

1. Газар дээр нь хэмжилт судалгаа хийж, материал цуглуулах
2. Хувирамтгай нэгдлүүд болон физик-химийн үзүүлэлтүүдийг газар дээр нь тодорхойлох
3. Лабораторийн шинжилгээний сорьц цуглуулах
4. Ерөнхий химийн шинжилгээг нийт 24 үзүүлэлтээр тодорхойлох
5. Бичил элементийн шинжилгээг нийт 52 үзүүлэлтээр тодорхойлох
6. Бичил амь судлалын нийт 6 үзүүлэлтээр тодорхойлох

7. Цацрагийн аюулгүйн 5 үзүүлэлтийг тодорхойлох
8. Судалгааны үр дүнг боловсруулж дүгнэлт өгөх
9. Лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн зөвлөмж боловсруулах
10. Нэгдсэн тайлан бичих
11. Шинжилгээний үр дүнгээр мэдээллийн сан үүсгэх.

#### 1.4. Усны химийн найрлага, шинж чанар

Байгалийн усны химийн бүрэлдэхүүн, чанар нь тухайн нутаг дэвсгэрийн газарзүйн нөхцөл, онцлог, хөрс, ургамал, чулуулаг, амьтан болон хүний үйл ажиллагаа зэрэг олон хүчин зүйлээс хамаарч хувиран өөрчлөгдөж байдаг нарийн нийлмэл систем юм. Байгалийн усыг найрлагаар нь 5 бүлэгт хуваана (*Д.Дорж, 2005*).

1. Гол ионууд ( $\text{Cl}^-$ ,  $\text{SO}_4^{2-}$ ,  $\text{HCO}_3^-$ ,  $\text{CO}_3^{2-}$ ,  $\text{Na}^+$ ,  $\text{K}^+$ ,  $\text{Ca}^{2+}$ ,  $\text{Mg}^{2+}$ )
2. Ууссан хий ( $\text{O}_2$ ,  $\text{N}_2$ ,  $\text{CO}_2$ ,  $\text{H}_2\text{S}$ )
3. Биоген элементүүд (азот, фосфор, төмөр, цахиурын нэгдэл)
4. Микро элементүүд (дээрхээс бусад үлдсэн химийн бүх элементүүд)
5. Органик бодисууд

*Усны гол ионууд:* Эдгээр нь усны химийн төрөл, химийн гол шинжийг тодорхойлно. Гидрокарбонат, карбонат, кальцийн ионууд цэнгэг усанд, хлор, натрийн ионууд шорвог усанд, сульфат, магни ионууд завсрын шинжтэй усанд зонхилж байдаг.

*Хлорын ион:* Чулуулаг бүрхүүлд харьцангуй бага хэмжээтэйгээр хлоридууд тархдаг. Хлорын ион усанд орох гол эх үүсвэр галт уулын хий бөгөөд газрын гүний усанд өндөр агуулгатай байдаг. Газар доорх усанд хуримтлагдах эх үүсвэр нь эртний далайн сав газар, ууссан чулуун давс, агаар мандлын хий, амьд организмын үйл ажиллагаа зэрэг болно. Хлорын ион нь ион солилцоо, адсорбци, биологийн хүчин зүйлд бараг өртдөггүй учраас усанд тогтвортой байдаг.

*Сульфат ион:* Газар доорх усанд, ялангуяа цэнгэг усанд тархсан байдаг. Кальци ионтой нэгдэж усанд муу уусдаг кальцийн сульфат үүсгэдэг. Сульфатын ион нь гипс, ангидритын усанд ууссанаас, пирит зэрэг хүхэр агуулсан нэгдэл, сульфитын эрдсийн исэлдэлтээс усанд хуримтлагдана.

*Гидрокарбонат, карбонатын ион:* Газар доорх цэнгэг усанд түгээмэл тархалттай гидрокарбонат, карбонат ион нь нүүрсний хүчлээс үүсэлтэй бөгөөд өөр хоорондоо тодорхой харьцаагаар шилждэг. Хүчиллэг орчинд  $\text{pH} < 5$  үед/ карбонатын ион илэрдэггүй, хүчтэй шүлтлэг усанд давамгайлна. Хүчиллэгээс бусад бүх усанд гидрокарбонат ион илэрдэг. Цэнгэг усанд ихэвчлэн гидрокарбонат ион давамгайлна.

*Кальцийн ион:* Янз бүрийн эрдэсжилттэй усанд тохиолдоно. Гол эх үүсвэр нь шохой, доломит, гипс, ангидридын шүлтгүйрэлийн явцаар усанд үүснэ. Цэнгэг давстай усанд кальци ион нь гидрокарбонат, сульфат ионуудтай нэгдсэн нэгдлийг үүсгэж байхад рассол усанд хлортой нэгдсэн нэгдлийг үүсгэнэ.

*Натрийн ион:* Газрын гүний усанд хамгийн өргөн тархсан катион юм. Натри ион нь кальци, магни ионыг бодвол илүү уусамтгай. Натрийн ион ихэнх нь хлорын ионтой тогтвортой нэгдлийг үүсгэдэг ба багавтар хэсэг нь сульфаттай бүр бага хэсэг нь гидрокарбонат ионтой нэгддэг. Натри нь дэлхийн гадаргын 2.5%-ийг бүрдүүлдэг бөгөөд ихэнхдээ янз бүрийн силикатын найрлагад ордог. Усан дахь натрийн ионы гол эх үүсвэр нь магмын чулуулаг ба алюмосиликатын өгөршлөөс үүсдэг.

*Магнийн ион:* Харьцангуй бага хэмжээгээр газар доорх усанд тааралдана. Магни ион давамгайлан тархсан газар доорх ус ховор ба усанд тэнгисийн уснаас, агаар мандлаас, доломитын шүлтгүйрэлтийн үйл явцаас, магни агуулагч эрдсийн задралаас усанд орно.



**Калийн ион:** Калийн давсууд усанд сайн уусдаг боловч газар доорх усанд калийн ион нь натрийг бодвол бага хэмжээгээр тааралдана. Учир нь усанд үл уусагч хоёрдогч эрдэст оролцдог, ургамлаар шимэгддэг, шаварлаг хурдсаар адсорбцлогддог зэргээс шалтгаалан газар доорх усанд төдийлөн их агуулгатай байж чаддаггүй. Газар доорх усанд калийн давсны уусалт, кали агуулагч эрдсийн өгөршлийн үйл явцаар орж ирнэ (*Батсүх, 2012*).

**Байгалийн усны химийн ангилал /О.А.Алекин/**

Газар доорх усны химийн ба хийн бүтээгдэхүүн нь ураныг уулын чулуулгаас усанд шилжихэд ихээхэн нөлөөлдөг ба түүний миграцид ч бас нөлөөтэй байдаг. Байгалийн усны химийн найрлага янз бүр учир түүнийг системтэйгээр боловсруулан дүгнэлт гаргах шаардлагатай болдог. Практик хэрэглээ, ач холбогдлоос нь хамааран янз бүрийн зарчим дээр үндэслэж байгалийн усыг химийн найрлагаар нь ангилсан олон ангилал байдаг. О.А.Алекины ангилал нь усны зонхилох ион тэдгээрийн харьцаагаар усны анги төрлийг илэрхийлдэг (*Г.Туваанжав, Мөнхзул, Л.Долгоржав, 2016*).

Шинжилгээгээр тогтоосон гол ионуудыг сонгон авч зонхилох анионоор нь бүх усыг гидрокарбонат (карбонат), сульфат, хлоридын гэж 3 ангилдаг. Гидрокарбонатын ангийн усанд бага эрдэсжилттэй голын ус, цэнгэг нуур, ихэнх газрын доорх ус хамаардаг. Хлоридын ангийн усанд эрдэсжилттэй нуур, эх газрын нуур цөөрөм, цөл хагас цөлийн болон марз хужиртай нутаг орны газрын доорх ус хамаарагддаг байхад эрдэсжилт болон тархалтаар сульфатын ангийн ус гидрокарбонат, хлорид ангийн усны хоорондох байрыг эзэлдэг.

Анги тус бүрийг кальци, магни, натри+кали зэрэг катионуудын зонхилох хэмжээгээр 3 бүлэгт хувааж бүлэг тус бүрийн хоорондох харьцаагаар нь цаашид 3 төрөлд хуваадаг байна.

1. Нэгдүгээр төрлийн усанд зонхилох нэгдлүүд  $\text{HCO}_3^- > \text{Ca}^{2+} + \text{Mg}^{2+}$  гэсэн харьцаатай байна. Энэ төрлийн усанд гидрокарбонат ионы агууламж газрын шүлтийн металлуудын ионы нийлбэр агууламжаас их байна. Тиймээс энэ төрөлд кальци, магни, натригаар түрэгдсэн солигдох урвалын дүнд үүссэн, сэвсгэр чулуулгуудын уусалтаас үүссэн найрлага бүхий бага эрдэсжилттэй ус хамрагдана.
2. Хоёрдугаар төрлийн ус нь  $\text{HCO}_3^- < \text{Ca}^{2+} + \text{Mg}^{2+} < \text{HCO}_3^- + \text{SO}_4^{2-}$  гэсэн харьцаатай ба ихэнх голын ус бага эрдэсжилттэй нуур болон газрын доорх ус орно.
3. Гуравдугаар төрөлд зонхилох ионууд нь  $\text{HCO}_3^- + \text{SO}_4^{2-} < \text{Ca}^{2+} + \text{Mg}^{2+}$  ба ийм төрлийн ус нь холимог, хувирмал, их эрдэсжилттэй байна. Энэ төрөлд тэнгис нуур, үеийн гаралтай уст цэгүүдийн ус хамрагддаг.

**Усны эрдэсжилт**

Байгалийн усны эрдэсжилт хэдэн арван миллиграммаас хэдэн зуун грамм хүртэл хэлбэлзэн өөрчлөгддөг. Ундны усны эрдэсжилтийн хэмжээ нэмэгдэхэд хүний биеийн ус, давсны тэнцвэр алдагддаг нь тогтоогджээ. Ус, давсны солилцоо алдагдахад төрөл бүрийн өвчин үүсэх нөхцөл бүрддэг. Усны нийт эрдэсжилтийн интеграл үзүүлэлт нь хуурай үлдэгдэл бөгөөд ундны усны хуурай үлдэгдлийн физиологийн хамгийн их байх дээд түвшин нь 1.0 г/л гэж тооцдог. Их эрдэсжилттэй усыг ууж дасаагүй хүн гэнэт цочир хэрэглэхэд биеийн ерөнхий тав тух алдагдах, ам цангах, биеийн хүчил шүлтийн тэнцвэр өөрчлөгдөх, зүрхний ажиллагаа сулрах, ходоод гэдэсний архаг зарим өвчин хурцдах зэрэг шинж тэмдгүүд илэрдгийг мэргэжилтнүүд тогтоожээ. Мөн эмч нарын үзэж байгаагаар цусны эргэлтийн тогтолцооны өвчнүүд /ЦЭТӨ/ тухайлбал цусны даралт ихсэх, зүрхний шигдээс, атеросклероз /судас хатуурах/, хоол боловсруулах эрхтний өвчнүүд /ХБЭӨ/ тухайлбал ходоод, нарийн бүдүүн гэдэсний үрэвсэлт өвчнүүд, элэг цөсний архаг өвчин мөн бөөр шээсний замын чулуужих өвчин /БШЗЧӨ/ зэрэг нь эрдэсжилтээс шалтгаалах өвчин эмгэгт хамаардгийг эрдэмтэд тогтоосон байдаг.

Эрдэсжилт хэт багатай буюу 100 мг/л-ээс бага эрдэсжилттэй бороо, цас, өндөр уулын бүсийн зарим голын ус болон нэрсэн ус зэрэг нь хүний бие организмд сөрөг нөлөө үзүүлж, хүн амын дунд жин буурч хатингарших, бамбай булчирхай нь томрох, зүрх судасны өвчнөөр өвчлөх, кальцийн дутагдалд орж яс хэврэгших зэрэг өвчлөл үүсэх шалтгаан болдгийг мэргэжилтнүүд мөн тогтоожээ. Судалгаанаас үзэхэд усанд байх нийт эрдэсжилтийн хэмжээ 150-350 мг/л орчим байх нь хамгийн тохиромжтой гэж тооцдог. Иймд нэн цэнгэг устай өндөр уулын бүсийн Монголчууд цайндаа давс, хужир нэмж хэрэглэдэг нь усны эрдсийг нэмэгдүүлж байгаа уламжлалт арга билээ. Гэвч эрдэсжилт багатай ус нь ихтэйгээсээ сөрөг нөлөөлөл харьцангуй багатай гэж үзэж болно.

### **Усны хатуулаг**

Ундны усны чанарын бас нэг чухал шалгуур нь усны хатуулаг юм. Энэ нь усан дахь кальци, магнийн агуулагдсан хэмжээгээр илэрхийлэгдэнэ. Усны хатуулгийг дотор нь ерөнхий буюу кальци, магнийн нийлбэр, арилгаж болох буюу карбонатын, тогтмол буюу карбонатын бус гэж ангилдаг. Карбонатын хатуулаг гэдгийг карбонат болон гидрокарбонат ионуудтай холбогдсон кальци, магнийн ионуудын тоо хэмжээ гэж ойлгоно. Иймд карбонатын хатуулгийн тоон утга нь карбонат ба гидрокарбонат ионуудын мг-экв/л-ээр илэрхийлэгдсэн концентрациудын нийлбэртэй тэнцүү байна. Хэрвээ энэхүү тоон утга нь ерөнхий хатуулгаас их утгатай байгаа бол карбонат, гидрокарбонат ионууд нь бусад катионуудтай холбогдсон гэсэн үг бөгөөд карбонатын хатуулгийн утгыг усны нийт хатуулагтай тэнцүү гэж авдаг. Карбонатын биш хатуулаг нь ерөнхий ба карбонатын хатуулгийн зөрүү байдлаар тодорхойлогдоно. Түр зуурын хатуулаг гэдэг нь усыг буцалгах үед арилдаг, карбонатын хатуулгийг хэлнэ. Түр зуурын хатуулгийг туршилтын аргаар тодорхойлно.

Зохих норм хэмжээнээс хэтэрсэн хатуулагтай усыг унданд байнга хэрэглэхэд ходоодны шүүс ялгаралтыг ихэсгэх ба ялгах эрхтний болон элэг цэсний чулуужих өвчний үүсэлд түлхэц болдог байна. Түүнчлэн усны хатуулгийг илэрхийлэгч кальци, магнийн ионууд нь хүний булчингийн агшилт суналтын сэдээгчийн үүрэг гүйцэтгэдэг ажээ. Кальци нь хүний бие махбодыг бүрдүүлдэг үндсэн элементүүдийн нэг бөгөөд хүний бие дэх нийт кальцийн 99 % нь яс, шүдэнд, 1 % нь цус, зөөлөн эдэд агуулагддаг. Кальци нь булчингийн агшилт, цус бүлэгнэлт, эсийн задрал, мэдрэлийн систем болон үржлийн систем, зүрхний булчингийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж түүнийг зохицуулдаг байна.

### **Биологийн бохирдолт**

Микро организм, ургамал болон амьтдын ялгадас болон бусад бактериар ус бохирдохыг хэлнэ. Гэдэсний халдвар үүсгэгч нянгууд туршилтын ба ердийн нөхцөлд усанд удаан хугацаагаар амьдарч өвчин үүсгэгч чадвараа хадгалдаг байна. Гэдэсний балнад, урвах тахал /холер/, цусан суулга, вирус гепатит, сүрьеэ болон бусад олон өвчнүүд ундны усаар дамжин халдварладаг.


Техникийн бохирдолтын дээрх үзүүлэлтүүд нь усны чанар, найрлагад нөлөөлөхөөс гадна ахуйн бохирдолт усанд маш их хэмжээгээр нөлөөлдөг. Усны халдвар тархалтын нэг онцлог нь нэг эх булгаас ус авдаг хүмүүс олноор зэрэг өвчилдөгт оршино. Өнгөн хөрсний болон цас, борооны бохирдолттой ус доош нэвчих замаар газрын гүний ус бохирддог. Үйлдвэрлэл хөгжихийн хирээр хөрс бохирдох, давтагдан нягтших, бүтэц нь алдагдах, давсжих, эвдрэх зэрэг сөрөг үр дагавар дагалддаг байна.

## 2. СУДАЛГААНЫ ОБЪЕКТ, АРГА ЗҮЙ

### 2.1. Судалгааны объект

Энэ удаагийн судалгаанд Дорноговь аймгийн 14 сумын төвийн нутаг дэвсгэрт орших гүний худгийн нийт 63 сорьц цуглуулан физик-хими, бичил элемент, бичил амь судлал, цацрагийн аюулгүйн үзүүлэлтүүдийг тодорхойлж сум тус бүрээр нь нэгтгэн дүгнэж, зөвлөмж боловсрууллаа. Үүнд:

- Сумдын унд, ахуйн зориулалттай гүний худаг
- Аймгийн ус хангамжийн эх үүсвэрийн гүний худаг



Зураг 1. Дорноговь аймгийн 14 сумын байршил, сорьц авсан цэгүүд

### 2.2. Гидрохимийн судалгааны арга зүй

Дорноговь аймгийн 14 сумын төвийн ундны усны зориулалтаар ашиглаж буй гүний худгийн усны гидрохимийн шинжилгээг хээрийн болон лабораторийн гэсэн үндсэн 2 зарчмаар хийж гүйцэтгэсэн болно.

**Хээрийн судалгаа:** Бид Дорноговь аймгийн 14 сумын төв, “Чандмань-Илч” ХХК-ийн хариуцан ажиллуулдаг ус хангамжийн эх үүсвэрийн гүний худгуудад 2022 оны 04-р сарын 04-ны өдрөөс 04-р сарын 10-ны хооронд судалгаа явуулж лабораторит хийх химийн шинжилгээний сорьц цуглуулав. Мөн хээрийн судалгаагаар гүний худгуудын байршил тодорхойлж, газар дээр нь усны орчин (pH), цахилгаан дамжуулалт (EC), исэлдэн ангижрах потенциал (ORP), нийт ууссан давс (TDS) зэрэг хувирамтгай үзүүлэлтүүдийг HM-30P, SM-31P болон RM-30P маркийн Япон улсын дижитал термометрээр хэмжилтийг хийсэн (Зураг 2,3).



Зураг 2. Байршил тодорхойлогч (GPS), нийт ууссан давс (TDS) хэмжигч, pH метр



Зураг 3. pH метр, цахилгаан дамжуулалт (EC), исэлдэн ангижрах потенциал (ORP)

Лабораторит тодорхойлох физик, химийн шинжилгээнд зориулж, усны сорьцыг 1.5 л багтаамжтай саванд, цацраг идэвхийн судалгаанд 1 л багтаамжтай саванд, бичил элементийн шинжилгээнд зориулж 0.1 л багтаамжтай хуванцар саванд агаар оруулалгүйгээр тус тус дүүргэн авсан. Мөн бичил амь судлалын шинжилгээнд зориулж урьдчилан лабораторид ариутгасан шилэн саванд дээж авах нөхцөлийг ханган тусгай аргаар авсан болно (Зураг 4).



Зураг 4. Усны сорьц авсан сав

**Лабораторийн шинжилгээ:** Ундны усанд агуулагдах физик-химийн үндсэн үзүүлэлтүүдийг Хими, химийн технологийн хүрээлэнгийн Экологийн химийн лабораторит хүснэгт 1-т заасан стандарт арга зүйгээр хийж гүйцэтгэв. Үүнд:

- ПИЧ,  $\text{Ca}^{2+}$ ,  $\text{Mg}^{2+}$ ,  $\text{CO}_3^{2-}$ ,  $\text{HCO}_3^-$ ,  $\text{Cl}^-$  -титрийн буюу эзлэхүүний аргаар
- $\text{SO}_4^{2-}$ -ийн ионыг жингийн аргаар
- $\text{Na}^+$ ,  $\text{K}^+$ - ионуудыг дөлийн фотометрийн аргаар
- $\text{NH}_4^+$ ,  $\text{Fe}^{3+}$ ,  $\text{Fe}^{2+}$ ,  $\text{NO}_3^-$ ,  $\text{NO}_2^-$ ,  $\text{F}^-$ ,  $\text{PO}_4^{3-}$ -ийг S2100UV маркийн спектрофотометрээр тус тус тодорхойлов [1, 2] (Зураг 5,6).



Зураг 5. Дөлийн фотометр



Зураг 6. Спектрофотометр

Харин бичил элементийн шинжилгээг SGS лабораторийн ICP-MS багажаар, цацрагийн аюулгүйн үзүүлэлтүүдийг МУИС-ын Цөмийн физикийн судалгааны төвд тус тус хийж гүйцэтгэв.

*Хүснэгт 1. Усны шинжилгээ хийх стандарт аргууд*

№	Физик-химийн үндсэн үзүүлэлтүүд	Стандарт
1	Уртраг, өргөрөг, өндөр	Багажаар тодорхойлно
2	Усны температур (Т°С)	
3	Усны орчин рН)	
4	Исэлдэн ангижрах потенциал (ORP)	
5	Цахилгаан дамжуулалт (EC)	
6	Нийт ууссан давс (TDS)	
7	Булингар (NTU)	
8	Перманганатын ПИЧ ( $\text{mgO}_2/\text{л}$ )	MNS ISO 4818:1999
9	Нийт хатуулаг ( $\text{mg-экв/л}$ )	MNS ISO 6059-2005
10	Натри ( $\text{Na}^+$ )	Дөлийн фотометрийн арга
11	Кали ( $\text{K}^+$ )	
12	Кальци ( $\text{Ca}^{2+}$ )	
13	Магни ( $\text{Mg}^{2+}$ )	MNS 6778:2019
14	Аммони ( $\text{NH}_4^+$ )	MNS ISO 7150-1:2006
15	Төмөр ( $\text{Fe}_{\text{нийт}}$ )	MNS 4430:2005
16	Карбонат ( $\text{CO}_3^{2-}$ )	MNS 3652.19-78
17	Гидрокарбонат ион ( $\text{HCO}_3^-$ )	MNS 3652.19-78
18	Хлор ( $\text{Cl}^-$ )	MNS ISO 9297:2005
19	Сульфат ( $\text{SO}_4^{2-}$ )	MNS ISO 9280:2001
20	Нитрит ( $\text{NO}_2^-$ )	MNS 6779:2019
21	Нитрат ( $\text{NO}_3^-$ )	MNS ISO 7890-3:2001
22	Фтор ( $\text{F}^-$ )	MNS 6272:2011
23	Фосфат ( $\text{PO}_4^{3-}$ )	MNS ISO 6878:2001

Бичил элемент (нийт 52 үзүүлэлт)		Индукцийн холбоост плазмын масс спектрометр (нийт 53 үзүүлэлт)
Al, Ba, Cr, Cu, Fe, Mn, P, Sr, Ti, V, Zn, Be, Sc, Co, Ni, Ga, Mo, As, Se, Rb, Y, Zr, Nb, Ag, Cd, In, Sn, Sb, Te, Cs, La, Ce, Pr, Nd, Sm, Eu, Gd, Tb, Dy, Ho, Er, Tm, Yb, Lu, Hf, Ta, W, Hg, Tl, Pb, Bi, Th, U		
Цацрагийн аюулгүйн үзүүлэлт		
1	Радон ( <sup>222</sup> Rn)	MNS 5632:2006
2	Ради ( <sup>226</sup> Ra)	
3	Уран ( <sup>238</sup> U)	
4	Хар тугалга ( <sup>214</sup> Pb)	
5	Висмут ( <sup>214</sup> Bi)	

### 2.3. Бичил амь судлалын судалгааны арга зүй

Усны чанарын биологийн аюулгүй байдлыг шалгах үндсэн арга нь бактериологийн буюу бичил амь судлалын үзүүлэлтийн хяналт байдаг. Унд, ахуйн усны хэрэгцээний нэгж эзлэхүүн усанд агуулагдах нийт нян, гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян зэрэг нь хүний биед халдвар дамжих аюулгүйн нөхцөлийг илэрхийлэгч үзүүлэлт болдог. Ундны усны аюулгүй байдлын гол илтгэгч үзүүлэлт нь *E.coli* бөгөөд энэ үзүүлэлт ундны усанд илэрвэл уг ус ялгадсаар бохирдсоны нотолгоо юм.

Энэ удаагийн судалгааны ажлын хүрээнд Дорноговь аймгийн гүний худгуудын усанд дараах стандарт арга зүйг ашиглан хүснэгт 2-т заагдсан 6 үзүүлэлтээр бичил амь судлалын шинжилгээг хийж гүйцэтгэв. Үүнд:

- MNS ISO 9308-1:1998 - Усны чанар. Гэдэсний бүлгийн бичил биетэн, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн бичил биетэн болон, таамаглаж буй *E.coli* –г илрүүлэх ба тоолох, 1-р хэсэг: ялтаст шүүлтүүрээр шүүх арга
- MNS ISO 6222:1998 – Усны чанар. Амьдрах чадвартай бичил биетний тоог тогтоох - тэжээлт орчин дотор буюу гадаргад нь ургасан нянгийн бөөгнөрлийг тоолох
- MNS ISO 19250:2017- Усны чанар. Усан дахь салмонеллын төрлийн нянг илрүүлэх

Хүснэгт 2. Бичил амь судлалын үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS 0900:2018 (ЗДА)
1	Гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо	тоо/100 мл	0
2	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян	<i>Salmonella</i>	тоо/25 мл
3		<i>Shigella</i>	тоо/25 мл
4	Нийт нянгийн тоо	тоо/1 мл	<100
5	<i>E.coli</i>	тоо/100 мл	0
6	Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян	тоо/100 мл	0

### Сорьц авах

Бичил амь судлалын шинжилгээний сорьцыг авахдаа нийт хийгдэх шинжилгээнд шаардагдах дээжний хэмжээг тооцон үзэж 500-550 мл авна. Сорьцын саван дээр хаяг, шошго, дугаар тавьж, GPS солбицлын цэгийг тэмдэглэнэ. Сорьц авахдаа дараах заавруудын мөрдөж авна.

- ИСО 3696:1987, шинжилгээний лабораторид ус-тодорхойлолт ба сорилын арга
- ИСО 5667-1: 1980, Усны чанар-Сорьц авах-1, сорьц төлөвлөх заавар
- ИСО 5667-2: 1982, Усны чанар-Сорьц авах-2
- ИСО 5667-3:1985, Усны чанар сорьц авах-3, сорьцыг зөөвөрлөх ба хадгалах заавар

### Багаж, тоног төхөөрөмж

Усанд бичил амь судлалын шинжилгээ хийхэд дараах багажуудыг ашиглана. Үүнд:

- Хуурай халуунаар ариутгах хатаагч
- Автоклав

- Халуун тогтоогуур (37<sup>0</sup>С болон 42<sup>0</sup>С)
- рН метр
- Аналитик жин
- Ялтаст шүүрийн багажууд
- Ялтаст шүүр, ялтаст шүүрийн диаметр нь 47 мм буюу 50 мм нүхний голч 0.45 μm
- Ариутгасан хямсаа
- Ариутгасан гогцоо зүү
- Спиртэн дэн
- Петрийн аяга
- Хэмжээст колбонууд
- Хуруу шил
- Тавиур шил




Зураг 7. 1, 3- 37<sup>0</sup>С-ийн халуун тогтоогуур, 2- 42-43<sup>0</sup>С-ийн халуун тогтоогуур, 4- Автоклав, 5- Аналитик жин

Судалгааны арга зүйг дараах дарааллаар хийж гүйцэтгэв. Үүнд:

***Петрийн аяга болон бусад туслах материал бэлтгэх***

Шинжилгээнд хэрэглэгдэх петрийн аягыг сайтар угаах, урсгал ус болон нэрмэл усаар зайлах гэсэн дамжлагаар цэвэрлэнэ. Цэвэр петрийн аягыг хатааж пергамитэн цаасанд багц болгон боож 180<sup>0</sup>С-н хатаах шүүгээнд 2 цаг ариутгана. Бусад хуруу шил, колбо, ялтаст шүүлтүүрийг адил дамжлагаар бэлтгэнэ (Зураг 8).



Зураг 8. 1- Шил сав угаах хэсэг, 2- Угааж бэлтгэсэн шил сав хатаах, ариутгах, 3- Ариутгасан шил сав хадгалах хэсэг

### **Тэжээлт орчин бэлтгэх**

**Plate Count Agar:** Нийт амьдрах чадвартай бактерийг тоолох стандарт тэжээлт орчин бэлтгэхдээ 1000 мл нэрмэл усанд 23.5 г орчинг нэмж уусган pH=7.0 болгож тохируулна. Бэлэн болсон тэжээлийг бага зэргийн буцалгах хүртэл давтамжтайгаар хөдөлгөн халаана. Дараа нь тохирох агууламж бүхий колбо эсвэл хуруу шилэнд тэжээлт орчинг савлана. Автоклавт 121°C температурт 15 минут ариутгана.

**Endo Agar:** Гэдэсний бүлгийн нян болон *Escherichia coli*-тодорхойлох сонгодог орчин бэлтгэхдээ 1000 мл нэрмэл усанд 42 г тэжээл нэмж уусгаж 5 мл Endo Basic fuchsin Solution (EEND20500) Emulsion нэмж pH=7.0 болгож тохируулна. Бэлэн болсон тэжээлийг бага зэргийн буцалгах хүртэл давтамжтайгаар хөдөлгөн халаана. Дараа нь тохирох агууламж бүхий колбо эсвэл хуруу шилэнд орчинг савлана. Автоклавт 121°C температурт 15 минут ариутгана.


**SS agar:** Грамм сөрөг бактери болон *Sallmonella*, *Shigella* тодорхойлох сонгомол тэжээлт орчин бэлтгэхдээ 1000 мл нэрмэл усанд 66 г тэжээлт орчинг нэмж уусган pH=7±0.2 болгож тохируулна. Бэлэн болсон тэжээлийг бага зэргийн буцалгах хүртэл давтамжтайгаар хөдөлгөн халаана. Автоклавт ариутгаж болохгүй!

**Lactose Peptone Broth: Escherichia coli,** лактоз задлах чадвартай бактери тодорхойлох баяжуулах орчин бэлтгэхдээ 1000 мл нэрмэл усанд 35 г тэжээлт орчинг нэмж уусган pH=7.2 болгож тохируулна. Дараа нь автоклавт 121°C температурт 15 минут ариутгана. Лактозтой орчныг 5°C температурт хадгална.

**Peptone Water Buffered: Sallmonella, Shigella** тодорхойлох баяжуулах орчин бэлтгэхдээ 1000 мл нэрмэл усанд 16 г тэжээлт орчинг нэмж уусган pH=7.0 болгож тохируулна. Шинжилгээнд шаардагдах хэмжээтэй тохирох агууламж бүхий колбо, хуруу шилэнд тэжээлт орчинг хуваарилна. Дараа нь автоклавт 121°C температурт 15 минут ариутгана. Буферын орчныг 5°C температурт хадгална.

### **Агар бүхий Петрийн аягыг бэлтгэх**

Тэжээлт орчинг 47-50°C болгон хөргөн петрийн аяганд 20-25 мл савлан царцаана. Хэрэглэхийн өмнө гадаргуу бүрэн хатах хүртэл агар бүхий петрийн аягыг (агарын гадаргууг доош, тагийг дээш харуулан) тасалгаанд хатаана. Тэжээлт орчин хатаж, хагарахаас сэргийлж 5°C температурт хадгална. Бэлтгэсэн тэжээлт орчин тус бүрт эерэг хяналт тавьж баталгаажуулна (Зураг 9).



Зураг 9. 1- Тэжээлт орчин автоклавд ариутгах хэсэг, 2- Ариутгасан тэжээлт орчин савласан байдал, 3, 4-Тэжээлт орчин хадгалах хөргөгч

### **Шинжилгээ хийх явц**

1. **Нийт нянгийн тоо:** Өвөрмөц тэжээлт орчинд тодорхой нөхцөлд нянгийн бөөгнөрөл үүсгэн ургаж чадах бүх төрлийн агаартан нянг илрүүлэх арга юм. Шинжилгээний сорьцоос 1 мл авч петрийн аяган дахь өвөрмөц тэжээлт орчинтой (Plate Count Agar) жигд болтол нь холих буюу царцаан 37°C температурын дулаан тогтоогуурт 24 цаг өсгөвөрлөнө. Хоёр аягатай тэжээлт орчны дотор болон дээр нь ургасан нянгийн



бөөгнөрлийг колони тоолох багажны тусламжтайгаар тоолон үр дүнг гаргана [MNS ISO 7704:1998].

2. **Гэдэсний бүлгийн бичил биет илрүүлэх, тоолох:** Шинжилгээний сорьцоос 100 мл авч ялтаст шүүрээр шүүсний дараа сонгомол (Endo agar), лактоз агуулсан шингэн орчин дээр 37°C болон 44°C тус бүрт 24 цаг ургуулан өсгөвөрлөнө. Үр дүнг тооцохдоо ялтаст шүүрэн дээр ургасан тодорхой шинж тэмдэгтэй нянгийн бөөгнөрлийг тоолж, шаардлагатай тохиолдолд батлах сорилоор батлана.

2.1 Гэдэсний бүлгийн бичил биетнүүд (coliform organisms): 35°C+0.5°C буюу 37°C+0.5°C-ийн аль нэгэнд сонгомол (Endo agar) ба лактозтой орчинд агаартай нөхцөлд 18+3 цагийн дотор лактозыг хүчил үүсгэн ургах чадвартай бичил биетэн юм.

2.2 Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн бичил биетнүүд (Thermotolerant coliform organisms): 44°C+0.25°C буюу 44.5°C+0.25°C-ийн аль нэгэнд сонгомол (Endo agar) ба лактозтой орчинд агаартай нөхцөлд 18+3 цагийн дотор лактозыг хүчил үүсгэн ургах чадвартай бичил биетэн юм.

2.3 Байж болзошгүй нян *Escherichia coli*: 44°C+0.25°C буюу 44.5°C+0.25°C-ийн аль нэгэнд 24 цагийн дотор триптофанаас индол үүсгэдэг шинж чанартай лактозоос (буюу маннит) хий үүсгэн ургах чадвартай халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн бичил биетэн юм [MNS ISO 9308-1:1998].

3. **Салмонеллын төрлийн нянг илрүүлэх (*Salmonella*):** 36°C±2°C-д 18±2 цаг сонгомол баяжуулах тэжээлт орчинд (Peptone Water Buffered) баяжигдан, 36°C±2°C-д 24±3 цаг сонгомол хатуу тэжээлт орчин (SS agar) дээр хэв шинжит онцлох колони үүсгэн өсгөвөрлөгдсөн, биохими ба ийлдэс судлалын аргаар тодорхойлогдсон бичил биетэн юм. Үр дүнг тооцохдоо биохимийн болон ийлдэс судлалын шинжилгээний баталгаажилтын үр дүнгээр *Salmonella* гэж таамаглаж байгаа эсэхийг харуулна [MNS ISO 19250:2017].

4. **Шигелл төрлийн нянг илрүүлэх (*Shigella*):** 36°C±2°C-д 18±2 цаг сонгомол баяжуулах тэжээлт орчинд (Peptone Water Buffered) баяжигдан, 36°C±2°C-д 24±3 цаг сонгомол хатуу тэжээлт орчин (SS agar) дээр хэв шинжит онцлох колони үүсгэн өсгөвөрлөгдсөн, биохими ба ийлдэс судлалын аргаар тодорхойлогдсон бичил биетэн юм. Үр дүнг тооцохдоо биохимийн болон ийлдэс судлалын шинжилгээний баталгаажилтын үр дүнгээр *Shigella* гэж таамаглаж байгаа эсэхийг харуулна [MNS ISO 19250:2017].



Зураг 10. 1- Шинжилгээнд авсан дээж болон туслах материал 2- Шинжилгээ хийгдсэн үндсэн хэсэг, 3- Ялтаст шүүлтүүрийн багаж, 4- Ялтаст шүүр

### 3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

#### 3.1. Сайншанд сум

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1961 онд 136 дугаар зарлигаар Сайншанд хот болгон баталсан байна. Улаанбаатар хотоос 463 км зайд, олон улсын зам харилцааны нээлттэй боомт Замын-Үүд сумаас 245 км зайтай байрладаг. Засаг захиргааны нэгжийн хувьд 8 багийн 27,405 хүн амтай.

Сайншанд сумын “Усан хангамжийн систем” нь тус хотын I, II, III, YI багийн нутаг дэвсгэрт орших нийтийн орон сууц, аж ахуйн нэгж, байгууллагын ундны болон ахуйн хэрэгцээний цэвэр усыг төвлөрсөн сүлжээгээр ханган нийлүүлдэг. Сайншанд сумын I, II, III, IV, YII багийн зарим хэсгийн, YI багийн гэр хорооллын хүн амыг төвлөрсөн сүлжээнд холбогдсон ус түгээх байраар дамжуулан усаар хангадаг бөгөөд зөврөөр зөвхөн ахуйн хэрэгцээний усыг түгээдэг.

Сайншанд сумын усан хангамжийн эх үүсвэр сумын төвөөс 18-27 км зайд байрлах Өехий, Зээгийн хөтөл хэмээх газраас гүний 3 худгаас ус олборлож, өргөлтийн 3 насос станцаар дамжуулан Даралтын санд төвлөрүүлэн тэндээсээ өөрийн урсгалаар нь хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагын унд, ахуйн усны хэрэгцээний хоногийн хэрэглээ болох 1500–1800 м<sup>3</sup> усыг хэрэглэгчдэд нийлүүлдэг.

Ус хангамжийн системийн үйл ажиллагааг Дорноговь аймгийн Сайншанд сум дахь “Чандмань - Илч” ХХК хариуцан явуулдаг. Цэвэр усны төвлөрсөн системээр нийт 306 аж ахуйн нэгж, байгууллага, 69 төсөвт байгууллага, 3222 амины болон нийтийн орон сууцны өрх айл, гэр хорооллын айл, өрхөд төвлөрсөн сүлжээнд холбогдсон 25 ус түгээх байраар дамжуулан ус түгээхээс гадна, дулааны станцын зуухыг технологийн усаар хангадаг.

Усны эх үүсвэрийн байгууламж, тоноглолуудыг Удирдлага, хяналтын төвөөс зайнаас удирдан автомат системтэйгээр ажиллуулж ус олборлолт, дамжуулалтын ажлыг гүйцэтгэдэг. Сайншанд сумын 1, 2, 3, 4, 6, 8-р багийн гэр хорооллын оршин суугчдын хэрэглэгчдийн унд, ахуйн хэрэгцээний цэвэр усыг нийт 25 ухаалаг системтэй ус түгээх байраар дамжуулан 24 цагийн туршид хангадаг. Мөн 7-р багийн 280 өрх айлын орон сууцны хэрэглэгчдийг унд, ахуйн хэрэгцээний цэвэр усаар хангадаг.

Хоорондоо 0,7-6,2 км зайтай гүний худгуудаас ус олборлож 160 мм–ийн голчтой хуванцар PE /полиэтилен/ хоолойгоор “Зээг” өргөлтийн насос станцын 100 м<sup>3</sup> эзлэхүүнтэй нөөцийн сан руу, өргөлтийн “Зээг” насос станцаас NK80/250 маркийн насосоор 9,2 км урт 225 мм–ийн голчтой хуванцар PE /полиэтилен/ хоолойгоор “Говь” өргөлтийн насос станцын 100 м<sup>3</sup> эзлэхүүнтэй нөөцийн сан руу, Говь насос станцаас NK80/250 маркын насосоор 4,6 км урт дээрхитэй адил хийц, 225 мм –ийн голчтой хуванцар PE хоолойгоор Дэнж насос станцын нөөцийн сан руу шахдаг. 2 км урттай 250 мм –ийн голчтой полиэтилен хоолойгоор 1000м<sup>3</sup> эзлэхүүнтэй даралтат хоёр сан руу шахдаг. Даралтат сангаасаа усанд ариутгал хийж цэвэр усны төвлөрсөн сүлжээ рүү өөрийнх нь урсгалаар Сайншанд сумын хэрэглэгчдэд түгээдэг.

Мөн Сайншанд сумын зүүн урд байрлах гүний 4-р худгаас усыг олборлож 174-р дамжуулах насос станцаар дамжуулан дулааны станцын ахуйн ба технологийн усны хэрэгцээг хангадаг.

Энэ удаагийн судалгаанд эх үүсвэрийн болон Засаг даргын Тамгын газар, Төмөр замын эзэмшлийн нийт 17 уст цэг хамрагдсан болно.

### 3.1.1. Эх үүсвэрийн худгууд



Ундны усны чанарын судалгаанд хамрагдсан эх үүсвэрийн 4 худаг нь “Чандмань-Илч” ХХК-ийн харьяалалд байдаг, ус ашиглах зөвшөөрөл дүгнэлттэй, худгийн паспорттай, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн шаардлага хангасан байна. Одоогийн байдлаар эх үүсвэрийн 3 гүний худгаас 23 ус түгээх байр, Сайншанд сумын албан байгууллага, аж ахуй нэгж, иргэд, хэрэглэгчдийг цэвэр усаар хангадаг байна.




Зураг 11. Эх үүсвэрийн гүний худгуудын байршил

Эх үүсвэрийн гүний худгуудын байршил, усны физик-химийн үзүүлэлтүүдийг хүснэгт 3-т үзүүлэв. Шинжилгээний үр дүнгээс харахад уг худгуудын ус өнгө, үнэргүй, pH 7.75-8.02 буюу сул шүлтлэг орчинтой, булингар 0.28-0.30 NTU, исэлдэн ангижрах потенциал болох (ORP) 155-170 mV, цахилгаан дамжуулах чанар (EC) 93-176.5 mS/m, нийт ууссан давс (TDS) 364-515 ppm тус тус агуулагдаж байна. Үүнээс үзэхэд 1, 2-р худгийн ус цахилгаан дамжуулах чанараараа “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 3. Эх үүсвэрийн гүний худгуудын байршил, усны физик-химийн үзүүлэлт

Худгийн нэр, гүн	Солбицол	Фото зураг	Хэмжсэн үзүүлэлтүүд
<b>Эх үүсвэрийн худаг 1</b> Цооногийн гүн: 90 м, 1,5 л/сек ундрагатай, 1992 онд ашиглалтанд орсон.	N44°44'20.8" E110°07'42.1"		T <sup>0</sup> C=5.0°C Булингар= 0.31 NTU pH=8.02 <b>EC=143.4 mS/m</b> TDS=515 ppm ORP=155 mV
<b>Эх үүсвэрийн худаг 2</b> Цооногийн гүн: 75 м, 10,5 л/сек ундрагатай, 1992 онд ашиглалтанд орсон..	N44°45'42.7" E110°11'46.6"		T <sup>0</sup> C=5°C Булингар= 0.28 NTU pH=7.75 <b>EC=176.5 mS/m</b> TDS=480 ppm ORP=170 mV

Худгийн нэр, гүн	Солбицол	Фото зураг	Хэмжсэн үзүүлэлтүүд
<b>Эх үүсвэрийн худаг 3</b> Цооногийн гүн: 92 м, 15 л/сек ундрагатай, 1992 онд ашиглалтанд орсон.	N44°46'15.7" E110°07'42.2"		T°C=4.5°C Булингар= 0.30 NTU pH=7.9 EC=93.0 mS/m TDS=364 ppm ORP=162 mV

Гүний худгуудын усанд химийн шинжилгээ хийж үр дүнг хүснэгт 4, 5-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад эх үүсвэрийн 3 худгийн усны нийт хатуулаг 2.2-5.4 мг-экв/л буюу зөөлнөөс хатуувтар, нийт эрдэсжилт 682-1210.3 мг/л буюу цэнгэгдүүгээс давсархаг усны ангилалд хамаарагдаж байна. Үндсэн катионуудаас натрийн ион давамгайлж ( $\text{Na}^+$ ) 140.5-294.2 мг/л, кальци ( $\text{Ca}^{2+}$ ) 28-60.1 мг/л, магни ( $\text{Mg}^{2+}$ ) 9.7-29.2 мг/л, анионуудаас гидрокарбонатын ион давамгайлж ( $\text{HCO}_3^-$ ) 195.2-305 мг/л, сульфат ( $\text{SO}_4^{2-}$ ) 127.6-303.7 мг/л, хлор ( $\text{Cl}^-$ ) 97.3-278 мг/л, нитрат ( $\text{NO}_3^-$ ) 0.58-47.7 мг/л, фтор ( $\text{F}^-$ ) 1.32-1.59 мг/л тус тус агуулагдаж байна. Үүнээс үзэхэд 1, 2-р худгийн ус натри, фтор, нийт эрдэсжилтийн агуулгаараа “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 4. Эх үүсвэрийн гүний худгуудын усны катионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	ПИЧ	Нийт хатуулаг, мг-экв/л	$\text{Na}^+$	$\text{K}^+$	$\text{Ca}^{2+}$	$\text{Mg}^{2+}$	$\text{NH}_4^+$	$\text{Fe}_{\text{нийт}}$
Худаг №1	0.41	2.2	294.2	2.7	28.0	9.7	-	-
Худаг №2	1.11	5.4	292.0	2.8	60.1	29.2	-	-
Худаг №3	3.46	3.6	140.5	2.2	40.0	19.5	-	-
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	<b>10</b>	<b>7.0</b>	<b>200</b>		<b>100</b>	<b>30</b>	<b>1.5</b>	<b>0.3</b>

Хүснэгт 5. Эх үүсвэрийн гүний худгуудын усны анионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	$\text{CO}_3^{2-}$	$\text{HCO}_3^-$	$\text{Cl}^-$	$\text{SO}_4^{2-}$	$\text{NO}_2^-$	$\text{NO}_3^-$	$\text{PO}_4^{3-}$	$\text{F}^-$	Нийт эрдэсжилт
Худаг №1	12	305	146.0	263.4	-	4.08	0.002	1.56	1065.0
Худаг №2	-	244	278.0	303.7	0.02	0.58	0.002	1.59	1210.3
Худаг №3	12	195.2	97.3	127.6	-	47.7	0.02	1.32	682.0
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>			<b>350</b>	<b>500</b>	<b>1.0</b>	<b>50</b>	<b>3.5</b>	<b>0.7-1.5</b>	<b>1000</b>

Судалгаанд хамрагдсан эх үүсвэрийн гүний худгуудын усанд бичил элементүүдийн шинжилгээг 52 үзүүлэлтээр тодорхойлсон дүнг хүснэгт 6-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад эх үүсвэрийн 3 худгийн усанд уран (U) 39.9-120 мкг/л, 1, 3-р худгийн усанд хүнцэл (As) 14.8-18.7 мкг/л агуулагдаж байгаа нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 6. Эх үүсвэрийн гүний худгуудын усны бичил элементүүдийн агууламж, мкг/л

№	Үзүүлэлтүүд	MNS 0900:2018 (ЗДА)	Худаг №1	Худаг №2	Худаг №3
1	Ag (Мөнгө)	100	<0.2	<0.2	<0.2
2	Al (Хөнгөнцагаан)	500	<10	<10	<10
3	As (Хүнцэл)	10	14.8	3.53	18.7
4	Ba (Бари)	700	<10	<10	<10
5	Be (Биндэр)	0.2	<0.1	<0.1	<0.1
6	Bi (Висмут)		<0.01	<0.01	<0.01
7	Cd (Зөөлөнцагаан)	3	0.05	0.04	0.03

№	Үзүүлэлтүүд	MNS 0900:2018 (ЗДА)	Худаг №1	Худаг №2	Худаг №3
8	Ce (Цери)		<0.05	<0.05	<0.05
9	Co (Албин)		0.1	0.15	0.08
10	Cr (Хром)-нийт	50	<10	<10	<10
11	Cs (Цези)		0.029	<0.001	0.002
12	Cu (Зэс)	2000	<5	<5	<5
13	Dy (Диспрози)		<0.001	<0.001	<0.001
14	Er (Эрби)		<0.001	<0.001	<0.001
15	Eu (Европи)		<0.001	<0.001	0.001
16	Ga (Галли)		<0.02	<0.02	<0.02
17	Gd (Гадолини)		<0.003	<0.003	<0.003
18	Hf (Гафни)		<0.004	<0.004	<0.004
19	Hg (Мөнгөн Ус)	1	<0.5	<0.5	<0.5
20	Ho (Гольми)		<0.001	<0.001	<0.001
21	In (Инди)		<0.001	<0.001	<0.001
22	La (Лантан)		0.06	0.05	0.04
23	Lu (Лютеци)		<0.002	<0.002	<0.002
24	Mn (Манган)	100	<5	17	<5
25	Mo (Анзан)	70	15.1	11.2	10.8
26	Nb (Ниоби)		<0.005	<0.005	<0.005
27	Nd (Неодим)		<0.01	<0.01	<0.01
28	Ni (Никель)	20	<0.3	0.7	2.1
29	P (фосфор)	1142	<50	<50	<50
30	Pb (Хар тугалга)	10	<0.5	<0.5	<0.5
31	Pr (Празеодим)		<0.006	<0.006	<0.006
32	Rb (Рубиди)		2.28	0.72	1.23
33	Sb (Хэврэг цагаан)	20	0.4	<0.2	<0.2
34	Sc (Сканди)		<1	1	1
35	Se (Селен)	40	6.7	23.9	25.2
36	Sm (Самари)		<0.002	<0.002	<0.002
37	Sn (Цагаантугалга)		<0.1	<0.1	<0.1
38	Sr (Стронци)	2000	420	1031	822
39	Ta (Тантал)		0.031	<0.001	<0.001
40	Tb (Терби)		<0.002	<0.002	<0.002
41	Te (Теллур)		<0.1	<0.1	<0.1
42	Th (Тори)		<0.002	<0.002	<0.002
43	Ti (Титан)		<10	<10	<10
44	Tl (Талли)		<0.007	<0.007	<0.007
45	Tm (Тули)		<0.001	<0.001	<0.001
46	U (Уран)	30	39.9	120	52.7
47	V (Ванади)		<10	<10	<10
48	W (Вольфрам)		1.51	0.92	0.98
49	Y (Иттри)		0.068	0.059	0.044
50	Yb (Иттерби)		<0.001	<0.001	<0.001
51	Zn (Цайр)	5000	<5	<5	<5
52	Zr (Циркони)		<0.05	<0.05	<0.05

Мөн эх үүсвэрийн 3 худгийн усанд бичил амь судлалын шинжилгээг 6 үзүүлэлтээр тодорхойлсон үр дүнг хүснэгт 7-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад 1,3-р худгийн усны нийт нянгийн тоо стандартаас хэтрээгүй, бусад үзүүлэлтүүд илрээгүй байна. Харин 2-р худгийн усанд гэдэсний бүлгийн нян илэрсэн байгаа нь “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартын шаардлага хангахгүй байна.

Хүснэгт 7. Эх үүсвэрийн гүний худгуудын усны бичил амь судлалын үзүүлэлт

Сорьц авсан газрын нэр	1 мл сорьцонд	100 мл сорьцонд			25 мл сорьцонд
	Нийт нянгийн тоо	Гэдэсний бүлгийн нян	<i>E.coli</i>	Халуунд тэсвэртэй <i>E.coli</i>	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян ( <i>Salmonella/ Shigella</i> )
Худаг №1	7	0	-	-	-/-
Худаг №2	0	1	-	-	-/-
Худаг №3	0	0	-	-	-/-
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	<b>&lt;100</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

(- илрээгүй)

Тус гүний худгуудын усанд  $^{222}\text{Rn}$  болон түүний задралын бүтээгдэхүүн болох  $^{226}\text{Ra}$ ,  $^{238}\text{U}$ ,  $^{214}\text{Pb}$ ,  $^{214}\text{Bi}$  гэсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон дүнг хүснэгт 8-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад эх үүсвэрийн гүний худгууд нь цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлага хангаж байна.

Хүснэгт 8. Эх үүсвэрийн гүний худгуудын усны цацрагийн аюулгүйн үзүүлэлт, Бк/л

Сорьц авсан газрын нэр	Изотопын эзлэхүүний идэвх, Бк/л				
	$^{214}\text{Pb}$	$^{214}\text{Bi}$	$^{222}\text{Rn}$	$^{226}\text{Ra}$	$^{238}\text{U}$
Худаг №1	77	83	80	<0.4	<0.4
Худаг №2	35	25	30	<0.4	<0.4
Худаг №3	26	58	42	<0.4	<0.4
Илрүүлэх доод хязгаар (1л эзэлхүүнтэй, 1 цаг хэмжих үед)	0.3	0.5	0.4	0.4	0.4
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	-	-	<b>100</b>	<b>0.5</b>	<b>0.37 (0.03мг/л)</b>

**Дүгнэлт:** Судалгаанд хамрагдсан эх үүсвэрийн 3 худгийн ус нь сул шүлтлэг орчинтой, гидрокарбонат-натри, кальцийн төрлийн зөөлнөөс хатуувтар, цэнгэгдүүгээс давсархаг усны ангилалд хамаарагдаж байгаа бөгөөд цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангаж байна. Харин ерөнхий химийн найрлагаараа 1, 2-р худгийн ус, бичил элементийн агуулгаараа 1, 2, 3-р худгийн ус, бичил амь судлалын үзүүлэлтээрээ 2-р худгийн ус ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлагыг хангахгүй байна.

**Зөвлөмж:** Судалгаагаар 2-р худгийн усанд гэдэсний бүлгийн нян илэрсэн нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандартад тохирохгүй байна. Эрүүл ахуйн талаас авч үзвэл, тухайн хэрэглэгчид бохирдсон ундны усаар дамжих суулгалт өвчний халдварт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Тус халдварын үед ихэвчлэн бөөлжих, халуурах, шингэн алдах, электролитын тэнцвэр алдагдах зэрэг шинжүүд илрэх бөгөөд бусад хам шинжүүд хавсран тохиолдох нь түгээмэл байдаг. Тиймээс унданд шууд хэрэглэхэд тохиромжгүй бөгөөд буцалгаж хэрэглэх шаардлагатай. Мөн тус худагт ариутгал, халдваргүйжүүлэлт хийсний дараа дахин бичил амь судлалын шинжилгээнд хамруулж унданд хэрэглэхийг зөвлөж байна.

1, 2-р худгийн усны цахилгаан дамжуулах чанар, натри ( $\text{Na}^+$ ), нийт эрдэсжилтээрээ Монгол Улсад мөрдөгдөж буй ундны усны стандарт шаардлагыг хангахгүй байна. Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллөөрөө, натри нь усны үндсэн катионуудын нэг бөгөөд хүний мэдрэлийн үйл ажиллагаа, булчингийн, зүрх судасны тогтолцоо болон эсийн дотор ба гаднах орчны осмос даралт, рН-ийг тогтмол байлгахад зохих ёсоор нөлөөлж байдаг. Ийм усыг унд, ахуйд хэрэглэхэд тохиромжгүй учир анион, катионитон шүүлтүүр бүхий ус зөөлрүүлэх төхөөрөмж тавьж усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлж ашиглахыг зөвлөж байна.

1, 2-р худгийн усны фторын ионы агуулга MNS стандарт шаардлага хангахгүй байгааг анхаарах. Учир нь фторын ионы агуулга ихтэй усыг унданд удаан хэрэглэснээр хүний шүд, ясанд нөлөөлнө. Яснаас урьтаж шүдэнд нөлөө үзүүлж эхэлнэ. Урт хугацаанд фтор ихтэй ус хэрэглэснээр хөших, үений өвдөлт байдлаар шинж тэмдэг илэрнэ. Иймд фторыг уснаас цэвэрлэх тохиромжтой аргыг сонгон хэрэглэх нь зүйтэй. Фторын агуулгыг бууруулахад идэвхжүүлсэн хөнгөнцагааны оксид бүхий шүүх материалыг ашиглан бууруулах арга хамгийн өргөн хэрэглэгддэг байна.

1, 3-р худгийн усны хүнцэл (As)-ийн агуулга Монгол Улсад мөрдөгдөж буй ундны усны стандартаас давсан байна. Хүний бие махбод ундны усанд агуулагдах хүнцэлд удаан хугацаагаар өртөх нь эрүүл мэндэд сөрөг (давсаг, уушгины хорт хавдар, арьсны гэмтэл үүсгэх) нөлөөтэй. Тиймээс хүнцэл бууруулах шингээх, тунадасжуулан шүүх, ион солилцоо, мембран шүүлтүүр гэсэн аргуудаас тохиромжтойг нь сонгож ашиглан дахин бичил элементийн шинжилгээнд хамруулж унданд хэрэглэхийг зөвлөж байна.

Мөн эх үүсвэрийн 3 худгийн усны ураны агуулга стандарт хэмжээнээс хэтэрсэн байна. Уран агуулсан усыг удаан хугацаанд тогтмол хэрэглэх тохиолдолд хүний элэг, бөөрийг гэмтээх, мэдрэлийн тогтолцоонд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул унданд шууд хэрэглэхэд тохиромжгүй. Тиймээс усан дахь ураныг бууруулахдаа идэвхжүүлсэн хөнгөн цагааны исэл, анион солилцоо, нэрэх процесс, урвуу осмос зэрэг аргуудаар бууруулж болно. Уснаас ураныг цэвэрлэх нь ховор тохиолддог бөгөөд ион солилцоо, урвуу осмосын аргууд тохиромжтой юм. Ион солилцооны давирхай нь ураныг цэвэрлэх үр дүнтэй системийг бий болгодог.

### 3.1.2. Эх үүсвэрийн худаг №4

Тус худаг нь Сайншанд сумын 3-р багийн нутаг дэвсгэрт байрладаг, “Чандмань Илч” ХХК-ийн харьяалалд байдаг. 1992 онд ашиглалтад орсон, 90 м гүнтэй, 8.5 л/сек ундаргатай, худгийн паспорттай, ус ашиглах зөвшөөрөл дүгнэлттэй, эрүүл ахуйн хамгаалалтын бүстэй байна.



Зураг 12. Эх үүсвэрийн 4-р худаг, байршил

Худгийн усанд нийт нянгийн тоо стандарт хэмжээнээс давсан байгаа нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандартад тохирохгүй байна. Үүнээс үүдэж хэрэглэгчид бохирдсон ундны усаар дамжих суулгалт өвчний халдварт өртөхөөс сэргийлэх хэрэгтэй. Тиймээс унданд шууд хэрэглэхэд тохиромжгүй бөгөөд буцалгаж хэрэглэх шаардлагатай. Мөн тус худагт эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, ариутгал, халдваргүйжүүлэлт хийсний дараа дахин бичил амь судлалын шинжилгээнд хамруулж унданд хэрэглэхийг зөвлөж байна.

Мөн тус худгийн усны ураны агуулга стандарт хэмжээнээс хэтэрсэн байгааг анхаарах. Уран агуулсан усыг удаан хугацаанд тогтмол хэрэглэх тохиолдолд хүний элэг, бөөрийг гэмтээх, мэдрэлийн тогтолцоонд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул унданд шууд хэрэглэхэд тохиромжгүй. Тиймээс усан дахь ураныг бууруулахдаа идэвхжүүлсэн хөнгөн цагааны исэл, анион солилцоо, нэрэх процесс, урвуу осмос зэрэг аргуудаар бууруулж болно. Уснаас ураныг цэвэрлэх нь ховор тохиолддог бөгөөд ион солилцоо, урвуу осмосын аргууд тохиромжтой юм. Ион солилцооны давирхай нь ураныг цэвэрлэх үр дүнтэй системийг бий болгодог.

Худгийн усны радоны (Rn) агуулга Монгол Улсад мөрдөж буй ундны усны стандартын шаардлагыг хангахгүй байна. Ундны усанд ууссан радон нь хүний бие махбодод хорт хавдар үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй учраас түүнийг уснаас цэвэрлэх тохиромжтой аргыг сонгох хэрэгтэй.

Иймд радоныг уснаас цэвэрлэх тохиромжтой аргыг сонгон хэрэглэх нь зүйтэй. Радон ( $^{222}\text{Rn}$ ) нь 3.82 хоногийн хагас задралын хугацаатай байдаг тул түүний агуулгыг бууруулахын тулд ус хураах санд хадгалж бууруулах боломжтой юм. Мөн идэвхжүүлсэн нүүрсний нунтгийг ашиглан радоныг 95% бууруулах боломжтой. Түүнчлэн хүчилтөрөгчжүүлэх нь радоныг зайлуулах хамгийн тохиромжтой цэвэрлэгээний арга бөгөөд радоныг гадны агаарт хялбархан нэвтрүүлэх боломжийг олгодог бөгөөд ингэснээр цацрагийн түвшин нэмэгдэхгүйгээс гадна хог хаягдал гардаггүй байна.

### 3.2.3. Ус түгээх байр

Дорноговь аймгийн Айраг сумын нутагт байрлах ус түгээх байр 1 км зайд байрлах худгаас усаа татдаг бөгөөд “УБТЗ” ХНН-ийн Эрчим хүч, ус хангамжийн 2-р ангид харьяалагддаг. Цэвэр ус татдаг цооног нь 4 л/с ундаргатай, ус ашиглах зөвшөөрөл дүгнэлттэй байна.



Зураг 24. Ус түгээх байр, байршил

Ус түгээх байрны байршил, усны физик-химийн шинжилгээний дүнгээс харахад өнгө, үнэргүй, pH 8.5 буюу шүлтлэг орчинтой, булингар 0.2 NTU, цахилгаан дамжуулах чанар (EC) 119.2 mS/m, исэлдэн ангижрах потенциал болох (ORP) 135 mV, нийт ууссан давс буюу (TDS) 503 ppm агуулагдаж байна (Хүснэгт 79). Үүнээс үзэхэд уг түгээх байрны ус цахилгаан дамжуулах чанараараа Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлага хангахгүй байна.

Хүснэгт 79. Ус түгээх байрны байршил, усны физик-химийн үзүүлэлт

Гүний худгийн мэдээлэл		Солбицлын цэг		Шинжилгээний үзүүлэлт	
Ашиглалтанд орсон он	2000	N	45°48'04.0"	Т°С	5.0°С
				Булингар	0.2 NTU
				pH	8.5
Цооногийн гүн	70 м	E	109°18'42.1"	EC	119.2 mS/m
				ORP	135 mV
				TDS	503 ppm

Тус ус түгээх байрны усанд химийн шинжилгээ хийж үр дүнг хүснэгт 80, 81-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад усны нийт хатуулаг 6.1 мг-экв/л буюу хатуувтар, нийт эрдэжилт 863.85 мг/л буюу цэнгэгдүү усны ангилалд хамаарагдаж байна. Үндсэн катионуудаас натрийн ион давамгайлж ( $\text{Na}^+$ ) 141.5 мг/л, кальци ( $\text{Ca}^{2+}$ ) 50.1 мг/л, магни ( $\text{Mg}^{2+}$ ) 43.8 мг/л анионуудаас гидрокарбонатын ион давамгайлж ( $\text{HCO}_3^-$ ) 353.8 мг/л, хлор ( $\text{Cl}^-$ ) 96.5 мг/л, сульфат ( $\text{SO}_4^{2-}$ ) 138.3 мг/л, нитрат ( $\text{NO}_3^-$ ) 11.2 мг/л, фтор ( $\text{F}^-$ ) 3.59 мг/л тус тус агуулагдаж байна. Тиймээс тус ус түгээх байрны ус магни, фторын ионы агуулгаараа Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 80. Ус түгээх байрны усны катионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	ПИЧ	Нийт хатуулаг, мг-экв/л	$\text{Na}^+$	$\text{K}^+$	$\text{Ca}^{2+}$	$\text{Mg}^{2+}$	$\text{NH}_4^+$	$\text{Fe}_{\text{нийт}}$
Айраг УТБ	1.2	6.1	141.5	4.8	50.1	43.8	-	-
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	<b>10</b>	<b>7.0</b>	<b>200</b>		<b>100</b>	<b>30</b>	<b>1.5</b>	<b>0.3</b>

Хүснэгт 81. Ус түгээх байрны усны анионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	CO <sub>3</sub> <sup>2-</sup>	HCO <sub>3</sub> <sup>-</sup>	Cl <sup>-</sup>	SO <sub>4</sub> <sup>2-</sup>	NO <sub>2</sub> <sup>-</sup>	NO <sub>3</sub> <sup>-</sup>	PO <sub>4</sub> <sup>3-</sup>	F <sup>-</sup>	Нийт эрдэсжилт
Айраг УТБ	24	353.8	96.5	138.3	0.004	11.2	-	3.59	863.85
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	-		<b>350</b>	<b>500</b>	<b>1.0</b>	<b>50</b>	<b>3.5</b>	<b>0.7-1.5</b>	<b>1000</b>

Тус ус түгээх байрны усанд бичил элементүүдийн шинжилгээг 53 үзүүлэлтээр тодорхойлсон дүнг хүснэгт 82-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад худгийн усанд уран (U) 35.1 мкг/л агуулагдаж байгаа нь “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 82. Ус түгээх байрны усны бичил элементүүдийн агууламж, мкг/л

№	Үзүүлэлтүүд	MNS 0900:2018 (ЗДА)	Айраг УТБ
1	Ag (Мөнгө)	100	<0.2
2	Al (Хөнгөнцагаан)	500	<10
3	As (Хүнцэл)	10	1.85
4	Ba (Бари)	700	12
5	Be (Биндэр)	0.2	<0.1
6	Bi (Висмут)		<0.01
7	Cd (Зөөлөнцагаан)	3	0.01
8	Ce (Цери)		<0.05
9	Co (Албин)		0.13
10	Cr (Хром)-нийт	50	<10
11	Cs (Цези)		0.895
12	Cu (Зэс)	2000	<5
13	Dy (Диспрози)		0.002
14	Er (Эрби)		0.001
15	Eu (Европи)		0.002
16	Ga (Галли)		<0.02
17	Gd (Гадолини)		<0.003
18	Hf (Гафни)		<0.004
19	Hg (Мөнгөн Ус)	1	<0.5
20	Ho (Гольми)		<0.001
21	In (Инди)		<0.001
22	La (Лантан)		<0.01
23	Lu (Лютеци)		<0.002
24	Mn (Манган)	100	<5
25	Mo (Анзан)	70	7.1
26	Nb (Ниоби)		0.006
27	Nd (Неодим)		<0.01
28	Ni (Никель)	20	1.6
29	P (фосфор)	1142	<50
30	Pb (Хар тугалга)	10	<0.5
31	Pr (Празеодим)		<0.006
32	Rb (Рубиди)		18.8
33	Sb (Хэврэг цагаан)	20	<0.2
34	Sc (Сканди)		3
35	Se (Селен)	40	<0.2
36	Sm (Самари)		<0.002

№	Үзүүлэлтүүд	MNS 0900:2018 (ЗДА)	Айраг УТБ
37	Sn (Цагаантугалга)		<0.1
38	Sr (Стронци)	2000	1026
39	Ta (Тантал)		0.005
40	Tb (Терби)		<0.002
41	Te (Теллур)		<0.1
42	Th (Тори)		<0.002
43	Ti (Титан)		<10
44	Tl (Талли)		0.023
45	Tm (Тули)		<0.001
46	U (Уран)	30	35.1
47	V (Ванади)		<10
48	W (Вольфрам)		0.05
49	Y (Иттри)		0.018
50	Yb (Иттерби)		<0.001
51	Zn (Цайр)	5000	11
52	Zr (Циркони)		0.09

Ус түгээх байрны усанд бичил амь судлалын шинжилгээг 6 үзүүлэлтээр тодорхойлсон дүнг хүснэгт 83-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад усны нийт нянгийн тоо стандартаас хэтрээгүй, бусад үзүүлэлтүүд илрээгүй байга нь ундны усны стандарт MNS 0900:2018 –н шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 83. Ус түгээх байрны усны бичил амь судлалын үзүүлэлт

Сорьц авсан газрын нэр	1 мл сорьцонд	100 мл сорьцонд			25 мл сорьцонд
	Нийт нянгийн тоо	Гэдэсний бүлгийн нян	<i>E.coli</i>	Халуунд тэсвэртэй <i>E.coli</i>	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян ( <i>Salmonella/Shigella</i> )
Айраг УТБ	7	0	-	-	-/-
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	<b>&lt;100</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

(- илрээгүй)

Мөн түгээх байрны усанд <sup>222</sup>Rn болон түүний задралын бүтээгдэхүүн тодорхойлсон дүнгээс харахад цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангаж байна (Хүснэгт 84).

Хүснэгт 84. Ус түгээх байрны усны цацрагийн аюулгүйн үзүүлэлт, Бк/л

Сорьц авсан газрын нэр	Изотопын эзлэхүүний идэвх, Бк/л				
	<sup>214</sup> Pb	<sup>214</sup> Bi	<sup>222</sup> Rn	<sup>226</sup> Ra	<sup>238</sup> U
Айраг УТБ	61	98	80	<0.4	<0.4
Илрүүлэх доод хязгаар (1л эзэлхүүнтэй, 1 цаг хэмжих үед)	0.3	0.5	0.4	0.4	0.4
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	-	-	<b>100</b>	<b>0.5</b>	<b>0.37 (0.03мг/л)</b>

**Дүгнэлт:** Судалгаанд хамрагдсан ус түгээх байрны ус шүлтлэг орчинтой, гидрокарбонат-натрийн төрлийн хатуувтар, цэнгэгдүү усны ангилалд хамаарагдаж байгаа бөгөөд бичил амь судлал, цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангаж байна. Харин цахилгаан дамжуулах чанар, магни, фторын ион болон ураны агуулгаараа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлага хангахгүй байна.

**Зөвлөмж:** Судалгаагаар ус түгээх байрны усны цахилгаан дамжуулах чанар, магни, фторын ионы агуулга Монгол Улсад мөрдөгдөж буй ундны усны стандарт шаардлагыг хангахгүй байна. Ундны усан дахь магнийн ионы агуулга хэвийн байх нь хүний зүрх судасны үйл ажиллагаа, судасны уян хатан чанар, электролитийн тэнцвэрт байдал болон бөөрний архаг ба цочмог дутагдал, эксикоз, атеросклеоз зэрэг олон эмгэг үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй. Харин ундны усанд фторын ионы агууламж ихэссэнээр хүний шүд, ясанд нөлөөлнө. Тиймээс уг түгээх байрны усанд катионитон шүүлтүүр бүхий ус зөөлрүүлэх төхөөрөмж тавьж усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлж ашиглахыг зөвлөж байна.

Ус түгээх байрны усны фторын ионы агуулга MNS стандарт шаардлага хангахгүй байгаа тул фторыг уснаас цэвэрлэх тохиромжтой аргыг сонгон хэрэглэх нь зүйтэй. Фторын агуулгыг бууруулахад идэвхжүүлсэн хөнгөнцагааны оксид бүхий шүүх материалыг ашиглан бууруулах арга хамгийн өргөн хэрэглэгддэг байна. Усан дахь фторын агуулгыг бууруулах төхөөрөмж нь цэвэршүүлэх усны хэмжээ, фторын агуулга зэргээс ихээхэн хамаардгийг анхаарах нь зүйтэй.

Мөн ус түгээх байрны усны ураны агуулга стандарт хэмжээнээс хэтэрсэн байгаа тул унданд шууд хэрэглэхэд тохиромжгүй. Тиймээс усан дахь ураныг бууруулахдаа идэвхжүүлсэн хөнгөн цагааны исэл, анион солилцоо, нэрэх процесс, урвуу осмос зэрэг аргуудаар бууруулж болно. Уснаас ураныг цэвэрлэх нь ховор тохиолддог бөгөөд ион солилцоо, урвуу осмосын аргууд тохиромжтой юм. Ион солилцооны давирхай нь ураныг цэвэрлэх үр дүнтэй системийг бий болгодог.

### 3.3. Алтанширээ сум

1934 онд нутгийн ардын төлөөлөгчдийн хурлаар “Зүрх чандмань” сумыг “Алтанширээ” сум болгон нэрлэсэн байна. Уг сум нь Дорноговь аймгийн зүүн хойд хэсэгт Улаанбаатар хотоос 456 км, аймгийн төвөөс 90 км зайд байрладаг. Засаг захиргааны нэгжийн хувьд Тойг, Зараа, Хаяа, Чулуунгишгэр гэсэн 4 багт, 398 өрхийн 1533 хүн амтай. Физик газарзүйн хувьд говийн их мужид багтдаг. Байгалийн эрс тэс уур амьсгалтай, хур тунадасны нийлбэр 100-120 мм хүрдэг байна. Сумын төвийн иргэд “Чандмань-Илч” ХХК-ийн гүний худгаас унд, ахуйн хэрэгцээний усаар хангагддаг, ундны усаа сумын төвөөс 30 гаруй км зайтай байрлах Цагаан дэлийн худаг болон сумын төвөөс 9 км-ын зайтай орших Цагаан тээгийн худгаас зөөвөрлөж хэрэглэдэг байна. Энэ удаагийн ундны усны чанарын судалгаанд тус 2 гүний худгийг шинжилгээнд хамруулсан болно.

#### 3.3.1. Цагаан худаг

Тус худаг нь Алтанширээ сумын ЗДТГ-ын эзэмшилд байснаа 2022 онд “Чандмань-Илч” ХХК-ийн харьяалалд ирсэн байна. Уг худаг нь 1500 м<sup>3</sup> багтаамжтай усан сантай, 1 ус түгээх байр руу цэвэр ус шахдаг, 1998 онд ашиглалтанд орсон, 73.5 м гүнтэй. Худгийн паспорттай, ус ашиглах зөвшөөрөл дүгнэлттэй, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн шаардлага хангасан байна.



Зураг 25. Цагаан худаг, байршил

Цагаан худгийн байршил, усны физик-химийн үзүүлэлтүүдийг хүснэгт 85-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад өнгө, үнэргүй, рН 7.93 буюу сул шүлтлэг орчинтой, булингар 0.27 NTU, цахилгаан дамжуулах чанар (EC) 217 mS/m, исэлдэн ангижрах потенциал болох (ORP) 159 mV, нийт ууссан давс буюу (TDS) 878 ppm тус тус агуулагдаж байна. Үүнээс үзэхэд худгийн ус цахилгаан дамжуулах чанараараа Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлага хангахгүй байна.

Хүснэгт 85. Цагаан худгийн байршил, физик-химийн үзүүлэлт

Ашиглалтанд орсон он	Гүний худгийн мэдээлэл		Солбицлын цэг		Шинжилгээний үзүүлэлт	
	1998	Цооногийн гүн	73.5 м	N	45°32'18.9"	Т°С
Булингар						0.27 NTU
рН						7.93
Хангагдаж буй хүн ам		99 айл, 6 ААНБ	E	110°28'27.0"	EC	217 mS/m
					ORP	159 mV
					TDS	878 ppm

Худгийн усанд химийн шинжилгээ хийж үр дүнг хүснэгт 86, 87-т үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад худгийн усны нийт хатуулаг 7.0 мг-экв/л буюу хатуувтар, нийт эрдэсжилт 1589.68 мг/л буюу давсархаг усны ангилалд хамаарагдаж байна. Үндсэн катионуудаас натрийн ион давамгайлж ( $\text{Na}^+$ ) 377.98 мг/л, кальци ( $\text{Ca}^{2+}$ ) 77.07 мг/л, магни ( $\text{Mg}^{2+}$ ) 41.34 мг/л, анионуудаас сульфатын ион давамгайлж ( $\text{SO}_4^{2-}$ ) 482.77 мг/л, гидрокарбонат ( $\text{HCO}_3^-$ ) 280.6 мг/л, хлор ( $\text{Cl}^-$ ) 250.21 мг/л, нитрат ( $\text{NO}_3^-$ ) 59.6 мг/л, карбонат ( $\text{CO}_3^{2-}$ ) 24 мг/л, фтор ( $\text{F}^-$ ) 3.29 мг/л тус тус агуулагдаж байна. Тиймээс тус худгийн ус натри, магни, нитрат, фтор, нийт эрдэсжилтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 86. Цагаан худгийн усны катионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	ПИЧ	Нийт хатуулаг, мг-экв/л	$\text{Na}^+$	$\text{K}^+$	$\text{Ca}^{2+}$	$\text{Mg}^{2+}$	$\text{NH}_4^+$	$\text{Fe}_{\text{нийт}}$
Цагаан худаг	2.88	7.0	377.98	1.1	72.07	41.34	-	-
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	<b>10</b>	<b>7.0</b>	<b>200</b>		<b>100</b>	<b>30</b>	<b>1.5</b>	<b>0.3</b>

Хүснэгт 87. Цагаан худгийн усны анионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	$\text{CO}_3^{2-}$	$\text{HCO}_3^-$	$\text{Cl}^-$	$\text{SO}_4^{2-}$	$\text{NO}_2^-$	$\text{NO}_3^-$	$\text{PO}_4^{3-}$	$\text{F}^-$	Нийт эрдэсжилт
Цагаан худаг	24	280.6	250.21	482.77	-	59.6	0.015	3.29	1589.68
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>			<b>350</b>	<b>500</b>	<b>1.0</b>	<b>50</b>	<b>3.5</b>	<b>0.7-1.5</b>	<b>1000</b>

Судалгаанд хамрагдсан худгийн усанд бичил элементүүдийн шинжилгээг 52 үзүүлэлтээр тодорхойлсон дүнгээс харахад анзан (Mo) 70.7 мкг/л, стронци (Sr) 4230 мкг/л, уран (U) 54 мкг/л агуулагдаж байна (Хүснэгт 88). Тиймээс тус худгийн ус бичил элементийн агуулгаараа “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 88. Цагаан худгийн усны бичил элементүүдийн агууламж, мкг/л

№	Үзүүлэлтүүд	MNS 0900:2018 (ЗДА)	Цагаан худаг
1	Ag (Мөнгө)	100	<0.2
2	Al (Хөнгөнцагаан)	500	<10
3	As (Хүнцэл)	10	3.74

№	Үзүүлэлтүүд	MNS 0900:2018 (ЗДА)	Цагаан худаг
4	Ba (Бари)	700	<10
5	Be (Биндэр)	0.2	<0.1
6	Bi (Висмут)		<0.01
7	Cd (Зөөлөнцагаан)	3	0.13
8	Ce (Цери)		<0.05
9	Co (Албин)		0.22
10	Cr (Хром)-нийт	50	<10
11	Cs (Цези)		0.17
12	Cu (Зэс)	2000	<5
13	Dy (Диспрози)		<0.001
14	Er (Эрби)		<0.001
15	Eu (Европи)		0.002
16	Ga (Галли)		<0.02
17	Gd (Гадолини)		<0.003
18	Hf (Гафни)		<0.004
19	Hg (Мөнгөн Ус)	1	<0.5
20	Ho (Гольми)		<0.001
21	In (Инди)		<0.001
22	La (Лантан)		0.05
23	Lu (Лютеци)		<0.002
24	Mn (Манган)	100	<5
25	Mo (Анзан)	70	70.7
26	Nb (Ниоби)		<0.005
27	Nd (Неодим)		<0.01
28	Ni (Никель)	20	1.1
29	P (фосфор)	1142	<50
30	Pb (Хар тугалга)	10	<0.5
31	Pr (Празеодим)		<0.006
32	Rb (Рубиди)		1.08
33	Sb (Хэврэг цагаан)	20	<0.2
34	Sc (Сканди)		2
35	Se (Селен)	40	15.6
36	Sm (Самари)		<0.002
37	Sn (Цагаантугалга)		<0.1
38	Sr (Стронци)	2000	4230
39	Ta (Тантал)		0.034
40	Tb (Терби)		<0.002
41	Te (Теллур)		<0.1
42	Th (Тори)		<0.002
43	Ti (Титан)		<10
44	Tl (Талли)		<0.007
45	Tm (Тули)		<0.001
46	U (Уран)	30	171
47	V (Ванади)		<10
48	W (Вольфрам)		0.91
49	Y (Иттри)		0.097
50	Yb (Иттерби)		0.002
51	Zn (Цайр)	5000	<5
52	Zr (Циркони)		<0.05

Мөн тус худгийн усанд бичил амь судлалын шинжилгээг 6 үзүүлэлтээр тодорхойлсон үр дүнг хүснэгт 89-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад нийт нянгийн тоо стандартаас хэтэрсэн, гэдэсний бүлгийн нян илэрсэн байна. Тиймээс уг худгийн ус бичил амь судлалын үзүүлэлтээрээ Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 89. Цагаан худгийн усны бичил амь судлалын үзүүлэлт

Сорьц авсан газрын нэр	1 мл сорьцонд	100 мл сорьцонд			25 мл сорьцонд
	Нийт нянгийн тоо	Гэдэсний бүлгийн нян	<i>E. coli</i>	Халуунд тэсвэртэй <i>E. coli</i>	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян ( <i>Salmonella/ Shigella</i> )
Цагаан худаг	240	17	-	-	-/-
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	<b>&lt;100</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

(- илрээгүй)

Тус худгийн усанд  $^{222}\text{Rn}$  болон түүний задралын бүтээгдэхүүн тодорхойлсон дүнг хүснэгт 90-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад уг худгийн ус цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 90. Цагаан худгийн усны цацрагийн аюулгүйн үзүүлэлт, Бк/л

Сорьц авсан газрын нэр	Изотопын эзлэхүүний идэвх, Бк/л				
	$^{214}\text{Pb}$	$^{214}\text{Bi}$	$^{222}\text{Rn}$	$^{226}\text{Ra}$	$^{238}\text{U}$
Цагаан худаг	34	82	58	<0.4	<0.4
Илрүүлэх доод хязгаар (1л эзэлхүүнтэй, 1 цаг хэмжих үед)	0.3	0.5	0.4	0.4	0.4
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	-	-	<b>100</b>	<b>0.5</b>	<b>0.37 (0.03мг/л)</b>

**Дүгнэлт:** Судалгаанд хамрагдсан Цагаан худгийн ус нь сул шүлтлэг орчинтой, сульфат, хлор-натрийн төрлийн хатуувтар, давсархаг усны ангилалд хамаарагдаж байгаа бөгөөд бичил амь судлал, ерөнхий химийн найрлага, бичил элемент болон цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна.

**Зөвлөмж:** Судалгаагаар уг худгийн усны нийт эрдэсжилт, натри ( $\text{Na}^+$ ), магнийн ( $\text{Mg}^{2+}$ ) ионы агуулга Монгол Улсад мөрдөгдөж буй ундны усны стандарт шаардлагыг хангахгүй байгаа тул унд, ахуйд удаан хугацаанд хэрэглэхэд тохиромжгүй, мөн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэйг анхаарах хэрэгтэй. Иймд катионитон шүүлтүүр бүхий ус зөөлрүүлэх төхөөрөмж тавьж усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлж ашиглахыг зөвлөж байна.

Уг худгийн усны фторын ионы агуулга MNS стандарт шаардлага хангахгүй байна. Фторын агууламж ЗДА-аас хэтэрсэн усыг удаан хугацаагаар хэрэглэх нь хэрэглэгчдийн эрүүл мэндэд (шүд, яс) сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Тиймээс фторыг уснаас цэвэрлэх тохиромжтой аргыг сонгон хэрэглэх нь зүйтэй. Фторын агуулгыг бууруулахад идэвхжүүлсэн хөнгөнцагааны оксид бүхий шүүх материалыг ашиглан бууруулах арга хамгийн өргөн хэрэглэгддэг байна.

Худгийн усанд нийт нянгийн тоо стандарт хэмжээнээс давсан, гэдэсний бүлгийн нян илэрсэн байгаа нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандартад тохирохгүй байна. Иймд хэрэглэгчид бохирдсон ундны усаар дамжих суулгалт өвчний халдварт өртөхөөс сэргийлэх хэрэгтэй. Тиймээс унданд шууд хэрэглэхэд тохиромжгүй бөгөөд



буцалгаж хэрэглэх шаардлагатай. Мөн тус худагт эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хашаа барьж, ариутгал, халдваргүйжүүлэлт хийсний дараа дахин бичил амь судлалын шинжилгээнд хамруулж унданд хэрэглэхийг зөвлөж байна.

Худгийн усны нитрат (NO<sub>3</sub>-)-ын агуулга Монгол Улсад мөрдөгдөж буй ундны усны стандарт шаардлагыг хангахгүй байна. Ундны усанд агуулагдах нитратын хэмжээ ихэсэх нь хүний бие махбодод хүчилтөрөгчийн дутагдал үүсгэх буюу гипоксийн шалтгаан болох метгемоглобинемийн эрсдэлийг үүсгэж болзошгүй. Тиймээс нитратыг уснаас цэвэрлэх тохиромжтой аргыг сонгон хэрэглэх нь зүйтэй. Нитратыг уснаас ион солилцоо, урвуу осмос, электродиализ, мембран, биологийн арга зэргийг ашиглан бууруулж болдог. Эдгээр аргуудаас ион солилцоо болон мембран процесс нь жижиг усан хангамжийн хувьд илүү тохиромжтой байдаг. Ион солилцооны процесст нитрат ионыг хлорид эсвэл бикарбонат болгон солилцдог шүлтлэг анион солилцооны давирхай агуулсан шүүлтүүрээр нэвтрүүлэн усан дахь нитратыг цэвэрлэдэг.

Бичил элементийн шинжилгээгээр уг худгийн усны стронци, анзаны агуулга Монгол Улсад мөрдөгдөж буй ундны усны стандартын шаардлагыг хангахгүй байгаа тул унд, ахуйд хэрэглэхэд тохиромжгүй төдийгүй иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй учраас анхаарвал зохилтой. Цаашид адсорбцлох (манганы исэл) болон урвуу осмос, ион солилцоо, шингээх, коагуляци зэрэг бууруулах аргуудаас сонгон хэрэглэж дахин шинжилгээнд хамруулж унданд хэрэглэхийг зөвлөж байна.

Мөн худгийн усны ураны агуулга стандарт хэмжээнээс хэтэрсэн байгаа тул унданд шууд хэрэглэхэд тохиромжгүй. Уран агуулсан усыг удаан хугацаанд тогтмол хэрэглэх тохиолдолд хүний элэг, бөөрийг гэмтээх, мэдрэлийн тогтолцоонд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Тиймээс усан дахь ураныг бууруулахдаа идэвхжүүлсэн хөнгөн цагааны исэл, анион солилцоо, нэрэх процесс, урвуу осмос зэрэг аргуудаар бууруулж болно. Уснаас ураныг цэвэрлэх нь ховор тохиолддог бөгөөд ион солилцоо, урвуу осмосын аргууд тохиромжтой юм. Ион солилцооны давирхай нь ураныг цэвэрлэх үр дүнтэй системийг бий болгодог.

### 3.3.2. Цагаан тээгийн худаг

Уг худаг нь 3-р багийн нутаг дэвсгэрт сумын төвөөс 9 км зайд байрладаг бөгөөд сумын ЗДТГ-ын эзэмшилд байдаг. Тус худгийг иргэн н.Энхбаатар хариуцан ажиллуулдаг, худгийн паспортгүй, ус ашиглах зөвшөөрөл дүгнэлтгүй, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн шаардлага хангасан хашаагүй, ховоотой худаг юм.



Зураг 26. Цагаан тээгийн худаг, байршил

Цагаан тээгийн худгийн байршил, усны физик-химийн үзүүлэлтүүдийг хүснэгт 91-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад өнгө, үнэргүй, pH 7.66 буюу сул шүлтлэг орчинтой, булингар 0.25 NTU, цахилгаан дамжуулах чанар (EC) 70.3 mS/m, исэлдэн ангижрах потенциал болох (ORP) 173 mV, нийт ууссан давс буюу (TDS) 230 ppm тус тус агуулагдаж

байна. Үүнээс үзэхэд худгийн ус физик-химийн үзүүлэлтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 91. Цагаан тээгийн худгийн байршил, физик-химийн үзүүлэлт

Гүний худгийн мэдээлэл		Солбицлын цэг		Шинжилгээний үзүүлэлт	
Цооногийн гүн	2-3 м	N	45°26'58.9"	T°C	3°C
				Булингар	0.25 NTU
				pH	7.66
Хангагдаж буй хүн ам	-	E	110°28'44.4"	EC	70.3 mS/m
				ORP	173 mV
				TDS	230 ppm

Худгийн усанд химийн шинжилгээ хийж үр дүнг хүснэгт 92, 93-т үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад худгийн усны нийт хатуулаг 4.5 мг-экв/л буюу зөөлөвтөр, нийт эрдэсжилт 586.5 мг/л буюу цэнгэг усны ангилалд хамаарагдаж байна. Үндсэн катионуудаас натрийн ион давамгайлж ( $\text{Na}^+$ ) 75.9 мг/л, кальци ( $\text{Ca}^{2+}$ ) 52.05 мг/л, магни ( $\text{Mg}^{2+}$ ) 23.1 мг/л, анионуудаас гидрокарбонатын ион давамгайлж ( $\text{HCO}_3^-$ ) 292.8 мг/л, сульфат ( $\text{SO}_4^{2-}$ ) 51.85 мг/л, нитрат ( $\text{NO}_3^-$ ) 47.6 мг/л, хлор ( $\text{Cl}^-$ ) 41.7 мг/л, фтор ( $\text{F}^-$ ) 0.04 мг/л тус тус агуулагдаж байна. Үүнээс үзэхэд тус худгийн усны фторын ионы агуулга ундны усны стандартад тусгагдсан доод утгад хүрэхгүй байгаа нь MNS 0900:2018-н шаардлага хангахгүй байна.

Хүснэгт 92. Цагаан тээгийн худгийн усны катионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	ПИЧ	Нийт хатуулаг, мг-экв/л	$\text{Na}^+$	$\text{K}^+$	$\text{Ca}^{2+}$	$\text{Mg}^{2+}$	$\text{NH}_4^+$	$\text{Fe}_{\text{нийт}}$
Цагаан тээгийн худаг	2.55	4.5	75.9	1.1	52.05	23.1	-	-
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	<b>10</b>	<b>7.0</b>	<b>200</b>		<b>100</b>	<b>30</b>	<b>1.5</b>	<b>0.3</b>

Хүснэгт 93. Цагаан тээгийн худгийн усны анионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	$\text{CO}_3^{2-}$	$\text{HCO}_3^-$	$\text{Cl}^-$	$\text{SO}_4^{2-}$	$\text{NO}_2^-$	$\text{NO}_3^-$	$\text{PO}_4^{3-}$	$\text{F}^-$	Нийт эрдэсжилт
Цагаан тээгийн худаг	-	292.8	41.7	51.85	0.29	47.6	0.101	0.04	586.5
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>			<b>350</b>	<b>500</b>	<b>1.0</b>	<b>50</b>	<b>3.5</b>	<b>0.7-1.5</b>	<b>1000</b>

Тус худгийн усанд бичил элементүүдийн шинжилгээг 52 үзүүлэлтээр тодорхойлсон дүнгээс харахад хүнцэл (As) 12.5 мкг/л агуулагдаж байгаа нь “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангахгүй байна (Хүснэгт 94).

Хүснэгт 94. Цагаан тээгийн худгийн усны бичил элементүүдийн агууламж, мкг/л

№	Үзүүлэлтүүд	MNS 0900:2018 (ЗДА)	Цагаан тээгийн худаг
1	Ag (Мөнгө)	100	<0.2
2	Al (Хөнгөнцагаан)	500	<10
3	As (Хүнцэл)	10	12.5
4	Ba (Бари)	700	110
5	Be (Биндэр)	0.2	<0.1
6	Bi (Висмут)		<0.01
7	Cd (Зөөлөнцагаан)	3	0.03

№	Үзүүлэлтүүд	MNS 0900:2018 (ЗДА)	Цагаан тээгийн худаг
8	Ce (Цери)		0.09
9	Co (Албин)		0.19
10	Cr (Хром)-нийт	50	<10
11	Cs (Цези)		0.008
12	Cu (Зэс)	2000	<5
13	Dy (Диспрози)		0.001
14	Er (Эрби)		0.002
15	Eu (Европи)		0.018
16	Ga (Галли)		<0.02
17	Gd (Гадолини)		0.004
18	Hf (Гафни)		<0.004
19	Hg (Мөнгөн Ус)	1	<0.5
20	Ho (Гольми)		<0.001
21	In (Инди)		<0.001
22	La (Лантан)		0.07
23	Lu (Лютеци)		<0.002
24	Mn (Манган)	100	<5
25	Mo (Анзан)	70	8.7
26	Nb (Ниоби)		<0.005
27	Nd (Неодим)		0.03
28	Ni (Никель)	20	0.6
29	P (фосфор)	1142	150
30	Pb (Хар тугалга)	10	<0.5
31	Pr (Празеодим)		0.01
32	Rb (Рубиди)		0.41
33	Sb (Хэврэг цагаан)	20	<0.2
34	Sc (Сканди)		2
35	Se (Селен)	40	2.3
36	Sm (Самари)		0.012
37	Sn (Цагаантугалга)		2.5
38	Sr (Стронци)	2000	670
39	Ta (Тантал)		<0.001
40	Tb (Терби)		<0.002
41	Te (Теллур)		<0.1
42	Th (Тори)		<0.002
43	Ti (Титан)		<10
44	Tl (Талли)		<0.007
45	Tm (Тули)		<0.001
46	U (Уран)	30	14.4
47	V (Ванади)		18
48	W (Вольфрам)		0.63
49	Y (Иттри)		0.063
50	Yb (Иттерби)		<0.001
51	Zn (Цайр)	5000	<5
52	Zr (Циркони)		<0.05

Уг худгийн усанд  $^{222}\text{Rn}$  болон түүний задралын бүтээгдэхүүн тодорхойлсон дүнг хүснэгт 95-д үзүүлэв. Шинжилгээний үр дүнгээс харахад уг худгийн ус цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус.

Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 95. Цагаан тээгийн худгийн усны цацрагийн аюулгүйн үзүүлэлт, Бк/л

Сорьц авсан газрын нэр	Изотопын эзлэхүүний идэвх, Бк/л				
	<sup>214</sup> Pb	<sup>214</sup> Bi	<sup>222</sup> Rn	<sup>226</sup> Ra	<sup>238</sup> U
Цагаан тээгийн худаг	19	57	38	<0.4	<0.4
Илрүүлэх доод хязгаар (1л эзэлхүүнтэй, 1 цаг хэмжих үед)	0.3	0.5	0.4	0.4	0.4
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	-	-	<b>100</b>	<b>0.5</b>	<b>0.37 (0.03мг/л)</b>

**Дүгнэлт:** Судалгаанд хамрагдсан Цагаан тээгийн худгийн ус нь сул шүлтлэг орчинтой, гидрокарбонат-натри, кальцийн төрлийн зөөлөвтөр, цэнгэгдүү усны ангилалд хамаарагдаж байгаа бөгөөд цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангаж байна. Харин фтор, хүнцлийн агуулгаараа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлага хангахгүй байна.

**Зөвлөмж:** Судалгаагаар уг худгийн усны фторын ионы агуулга ундны усны MNS стандартаас бага байна. Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллөөрөө, фтор нь хүний бие махбодод зайлшгүй чухал хэрэгцээтэй бичил элемент. Хүн бие махбодод хэрэгцээт фторынхоо 60-70%-ийг ундны уснаас авдаг. Хүний биед орших нийт фторын 60-70% шүдэнд, 30-40% ясанд нь агуулагдах учир ундны усны фторын ионы агуулга багассанаар хүний шүд, ясанд нөлөөлнө. Тиймээс уг худгийн усыг хэрэглэхдээ аль болох фторжуулсан бүтээгдэхүүн хэрэглэхийг зөвлөж байна.

Бичил элементүүдийн шинжилгээгээр тус худгийн усны хүнцэл (As)-ийн агуулга Монгол Улсад мөрдөгдөж буй ундны усны стандартаас давсан байна. Хүний бие махбод ундны уснаас хүнцэлд удаан хугацаагаар өртөх нь эрүүл мэндэд сөрөг (давсаг, уушгины хорт хавдар, арьсны гэмтэл үүсгэх) нөлөөтэй. Тиймээс хүнцэл бууруулах шингээх, тунадасжуулан шүүх, ион солилцоо, мембран шүүлтүүр гэсэн аргуудаас тохиромжтойг нь сонгож ашиглан дахин бичил элементийн шинжилгээнд хамруулж унданд хэрэглэхийг зөвлөж байна.

Түүнчлэн Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.1-д заасны дагуу гүний худгаас 50 метр зайд эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, бохирдол үүсэхээс хамгаалах хэрэгтэй.

### 3.4. Даланжаргалан сум

1931 онд Дорноговь аймгийг байгуулахад тус аймагт харьяалагдаж байгаад 1959 онд одоогийн төвлөрч байгаа “Цомог” хэмээх газарт суурьшжээ. Засаг захиргааны нэгжийн хувьд Элдэв, Өнгөт, Бичигт, Цомог, Олон-овоо гэсэн 5 багт 963 өрхөд нийт 2983 хүн ам амьдардаг. Улаанбаатар хотоос 308 км, аймгийн төвөөс 156 км зайд байрладаг. Хойд талаараа Говьсүмбэр аймгийн Шивээговь сум, зүүн хойд талаараа Хэнтий аймгийн Дархан, Бор-өндөр, урд талаараа өөрийн аймгийн Айраг, баруун талаараа Дундговь аймгийн Өндөршил, Баянжаргалан сумдтай хиллэдэг байна. Энэ удаагийн ундны усны чанарын судалгаанд 1 гүний худаг, 4 ус түгээх байрны усыг шинжилгээнд хамруулсан бөгөөд үр дүнг нэгтгэн орууллаа.

### 3.4.1. Ус түгээх байрууд

Ундны усны чанарын судалгаанд хамрагдсан 2 ус түгээх байр нь Даланжаргалан сумын Цомог багийн нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд “Чандмань-Илч” ХХК-ийн харьяалалд байдаг. Эдгээр ус түгээх байрууд нь 1 гүний худгийн усаар тэжээгддэг, ус ашиглах зөвшөөрөл дүгнэлттэй, паспорттай, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн шаардлага хангасан байна. Одоогийн байдлаар сумын 440 гаруй айл өрхийг цэвэр усаар хангадаг, ухаалаг системд холбогдсон, 24 цагийн ажиллагаатай худаг байна.



Зураг 27. Ус түгээх байруудын байршил

Ус түгээх байруудын байршил, усны физик-химийн үзүүлэлтүүдийг хүснэгт 96-д үзүүлэв. Шинжилгээний үр дүнгээс харахад түгээх байруудын ус өнгө, үнэргүй, рН 8.00-8.02 буюу сул шүлтлэг орчинтой, булингар 0.17-0.19 NTU, исэлдэн ангижрах потенциал болох (ORP) 153-155 mV, цахилгаан дамжуулах чанар (EC) 102.3-103.5 mS/m, нийт ууссан давс (TDS) 438-442 ppm тус тус агуулагдаж байна. Үүнээс үзэхэд тус ус түгээх байруудын ус цахилгаан дамжуулах чанараараа “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 96. Ус түгээх байруудын байршил, усны физик-химийн үзүүлэлт

Худгийн нэр, гүн	Солбицол	Фото зураг	Хэмжсэн үзүүлэлтүүд
<b>Ус түгээх байр №1</b> 2020 онд ашиглалтанд орсон. 240 өрх унд, ахуйн зориулалтаар ашигладаг.	N45°55'19.9" E109°04'07.1"		T°C=10.0°C Булингар= 0.17 NTU pH=8.02 <b>EC=103.5 mS/m</b> TDS=438 ppm ORP=153 mV
<b>Ус түгээх байр №2</b> 2020 онд ашиглалтанд орсон. 200 гаруй өрх унд, ахуйн зориулалтаар ашигладаг.	N45°55'15.6" E109°03'43.4"		T°C=13.0°C Булингар= 0.19 NTU pH=8.00 <b>EC=102.3 mS/m</b> TDS=442 ppm ORP=155 mV

Ус түгээх байруудын усанд химийн шинжилгээ хийж үр дүнг хүснэгт 97, 98-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад нийт хатуулаг 3.2-3.4 мг-экв/л буюу зөөлөвтөр, нийт эрдэсжилт 763.49-781.94 мг/л буюу цэнгэгдүү усны ангилалд хамаарагдаж байна. Үндсэн катионуудаас натрийн ион давамгайлж ( $\text{Na}^+$ ) 174.72-182.74 мг/л, магни ( $\text{Mg}^{2+}$ ) 25.54-26.75 мг/л, ( $\text{Ca}^{2+}$ ) 22.02-24.02 мг/л, анионуудаас гидрокарбонатын ион давамгайлж ( $\text{HCO}_3^-$ ) 244 мг/л, сульфат ( $\text{SO}_4^{2-}$ ) 125.9-154.4 мг/л, хлор ( $\text{Cl}^-$ ) 104.25-111.2 мг/л, фтор ( $\text{F}^-$ ) 2.95-3.07 мг/л тус тус агуулагдаж байна. Үүнээс үзэхэд тус ус түгээх байруудын ус фторын ионы агуулгаараа “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 97. Ус түгээх байруудын усны катионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	ПИЧ	Нийт хатуулаг, мг-экв/л	$\text{Na}^+$	$\text{K}^+$	$\text{Ca}^{2+}$	$\text{Mg}^{2+}$	$\text{NH}_4^+$	$\text{Fe}_{\text{нийт}}$
Ус түгээх байр №1	0.66	3.2	182.74	2.2	22.02	25.54	-	-
Ус түгээх байр №2	0.82	3.4	174.72	2.1	24.02	26.75	-	-
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	<b>10</b>	<b>7.0</b>	<b>200</b>		<b>100</b>	<b>30</b>	<b>1.5</b>	<b>0.3</b>

Хүснэгт 98. Ус түгээх байруудын анионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	$\text{CO}_3^{2-}$	$\text{HCO}_3^-$	$\text{Cl}^-$	$\text{SO}_4^{2-}$	$\text{NO}_2^-$	$\text{NO}_3^-$	$\text{PO}_4^{3-}$	$\text{F}^-$	Нийт эрдэсжилт
Ус түгээх байр №1	18	244	104.25	154.4	-	31.8	0.007	2.95	781.94
Ус түгээх байр №2	24	244	111.20	125.9	-	30.8	0.007	3.07	763.49
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>			<b>350</b>	<b>500</b>	<b>1.0</b>	<b>50</b>	<b>3.5</b>	<b>0.7-1.5</b>	<b>1000</b>

Судалгаанд хамрагдсан ус түгээх байруудын усанд бичил элементийн шинжилгээг 52 үзүүлэлтээр тодорхойлсон дүнг хүснэгт 99-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад 2 түгээх байрны усанд биндэр (Be) 0.4-1.7 мкг/л агуулагдаж байгаа нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 99. Ус түгээх байруудын усны бичил элементүүдийн агууламж, мкг/л

№	Үзүүлэлтүүд	MNS 0900:2018 (ЗДА)	УТБ №1	УТБ №2
1	Ag (Мөнгө)	100	<0.2	<0.2
2	Al (Хөнгөнцагаан)	500	<10	<10
3	As (Хүнцэл)	10	7.75	5.66
4	Ba (Бари)	700	<10	<10
5	Be (Биндэр)	0.2	1.7	0.4
6	Bi (Висмут)		<0.01	<0.01
7	Cd (Зөөлөнцагаан)	3	0.77	0.33
8	Ce (Цери)		<0.05	<0.05
9	Co (Албин)		1.39	0.54
10	Cr (Хром)-нийт	50	<10	<10
11	Cs (Цези)		0.22	0.215
12	Cu (Зэс)	2000	<5	<5
13	Dy (Диспрози)		<0.001	<0.001
14	Er (Эрби)		<0.001	<0.001

№	Үзүүлэлтүүд	MNS 0900:2018 (ЗДА)	УТБ №1	УТБ №2
15	Eu (Европи)		0.001	<0.001
16	Ga (Галли)		<0.02	<0.02
17	Gd (Гадолини)		<0.003	<0.003
18	Hf (Гафни)		<0.004	<0.004
19	Hg (Мөнгөн Ус)	1	<0.5	<0.5
20	Ho (Гольми)		<0.001	<0.001
21	In (Инди)		<0.001	<0.001
22	La (Лантан)		0.72	0.22
23	Lu (Лютеци)		<0.002	<0.002
24	Mn (Манган)	100	<5	<5
25	Mo (Анзан)	70	18	17.1
26	Nb (Ниоби)		<0.005	<0.005
27	Nd (Неодим)		<0.01	<0.01
28	Ni (Никель)	20	0.5	<0.3
29	P (Фосфор)	1142	<50	<50
30	Pb (Хар тугалга)	10	0.9	<0.5
31	Pr (Празеодим)		<0.006	<0.006
32	Rb (Рубиди)		3.94	4.01
33	Sb (Хэврэг цагаан)	20	2	0.4
34	Sc (Сканди)		6	5
35	Se (Селен)	40	9.4	9
36	Sm (Самари)		<0.002	<0.002
37	Sn (Цагаантугалга)		1.5	0.3
38	Sr (Стронци)	2000	414	383
39	Ta (Гантал)		<0.001	<0.001
40	Tb (Терби)		<0.002	<0.002
41	Te (Теллур)		<0.1	<0.1
42	Th (Тори)		<0.002	<0.002
43	Ti (Титан)		<10	<10
44	Tl (Талли)		<0.007	<0.007
45	Tm (Тули)		<0.001	<0.001
46	U (Уран)	30	19.3	21.2
47	V (Ванади)		10	<10
48	W (Вольфрам)		2.7	1.01
49	Y (Иттри)		0.843	0.268
50	Yb (Иттерби)		<0.001	<0.001
51	Zn (Цайр)	5000	108	957
52	Zr (Циркони)		1.38	0.34

Мөн 2 ус түгээх байрны усанд бичил амь судлалын шинжилгээг 6 үзүүлэлтээр тодорхойлсон үр дүнг хүснэгт 100-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад нийт нянгийн тоо стандартаас хэтрээгүй, бусад үзүүлэлтүүд илрээгүй байна. Тиймээс тус 2 түгээх байрны ус бичил амь судлалын үзүүлэлтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартын шаардлага хангаж байна.

Хүснэгт 100. Ус түгээх байруудын усны бичил амь судлалын үзүүлэлт

Сорьц авсан газрын нэр	1 мл сорьцонд	100 мл сорьцонд			25 мл сорьцонд
	Нийт нянгийн тоо	Гэдэсний бүлгийн нян	<i>E.coli</i>	Халуунд тэсвэртэй <i>E.coli</i>	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян ( <i>Salmonella/ Shigella</i> )
Ус түгээх байр №1	6	0	-	-	-/-
Ус түгээх байр №2	14	0	-	-	-/-
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	<b>&lt;100</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

(- илрээгүй)

Тус ус түгээх байруудын усанд  $^{222}\text{Rn}$  болон түүний задралын бүтээгдэхүүн болох  $^{226}\text{Ra}$ ,  $^{238}\text{U}$ ,  $^{214}\text{Pb}$ ,  $^{214}\text{Bi}$  гэсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон дүнгээс харахад цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлага хангаж байна (Хүснэгт 101).

Хүснэгт 101. Ус түгээх байруудын усны цацрагийн аюулгүйн үзүүлэлт, Бк/л

Сорьц авсан газрын нэр	Изотопын эзлэхүүний идэвх, Бк/л				
	$^{214}\text{Pb}$	$^{214}\text{Bi}$	$^{222}\text{Rn}$	$^{226}\text{Ra}$	$^{238}\text{U}$
Ус түгээх байр №1	12	20	16	<0.4	<0.4
Ус түгээх байр №2	14	19	17	<0.4	<0.4
Илрүүлэх доод хязгаар (1л эзэлхүүнтэй, 1 цаг хэмжих үед)	0.3	0.5	0.4	0.4	0.4
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	-	-	<b>100</b>	<b>0.5</b>	<b>0.37 (0.03мг/л)</b>

**Дүгнэлт:** Судалгаанд хамрагдсан 2 түгээх байрны ус нь сул шүлтлэг орчинтой, гидрокарбонат-натри, магнийн төрлийн зөөлөвтөр, цэнгэгдүү усны ангилалд хамаарагдаж байгаа бөгөөд бичил амь судлал, цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангаж байна. Харин тус ус түгээх байруудын ус цахилгаан дамжуулах чанар, биндэр, фторын ионы агуулгаараа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлагыг хангахгүй байна.

**Зөвлөмж:** Судалгаагаар тус ус түгээх байруудын усны цахилгаан дамжуулах чанар Монгол Улсад мөрдөгдөж буй ундны усны стандарт шаардлагыг хангахгүй байгаа тул унд, ахуйд удаан хугацаанд хэрэглэхэд тохиромжгүй. Иймд анионитон болон катионитон шүүлтүүр бүхий ус зөөлрүүлэх төхөөрөмж тавьж усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлж ашиглахыг зөвлөж байна.

Ус түгээх байруудын ус биндэр (Be)-ийн агуулгаараа Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандартаас давсан тул унданд шууд хэрэглэхэд тохиромжгүй байна. Тиймээс усан дахь биндэрийн агуулгыг бууруулах идэвхжүүлсэн хөнгөн цагааны исэл, тунадасжуулан шүүх, шингээх, ион солилцооны давирхай, нэрэх процесс, мембран шүүлтүүр, урвуу осмос зэрэг аргуудаас сонгон бууруулж, дахин бичил элементийн шинжилгээнд хамруулж унданд хэрэглэхийг зөвлөж байна.

Ус түгээх байрны усны фторын ионы агуулга MNS стандарт шаардлага хангахгүй байна. Ундны усанд фторын агуулга ЗДА-аас хэтэрсэн байх нь тухайн орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд (шүд, яс) сөргөөр нөлөөлж болзошгүй. Иймд фторыг уснаас цэвэрлэх тохиромжтой аргыг сонгон хэрэглэх нь зүйтэй. Фторын агуулгыг бууруулахад идэвхжүүлсэн хөнгөнцагааны оксид бүхий шүүх материалыг ашиглан бууруулах арга хамгийн өргөн хэрэглэгддэг байна. Усан дахь фторын агуулгыг бууруулах төхөөрөмж нь цэвэршүүлэх усны хэмжээ, фторын агуулга зэргээс ихээхэн хамаардгийг анхаарах нь зүйтэй.



### 3.4.2. Олон-Овооны ус түгээх байр



Даланжаргалан суманд байрлах 2 ус түгээх байр Олон-Овооны зөрлөгийн СКВ-1, 2-оос ээлжлэн усаа татдаг. СКВ-1, 2 худаг нь “УБТЗ” ХНН-ийн Эрчим хүч, ус хангамжийн 2-р ангид харьяалагддаг байна. СКВ-1 худаг нь 1986 онд ашиглалтанд орсон, 2.5 л/с ундаргатай, 25.5 м гүнтэй, СКВ-2 худаг нь 2008 онд ашиглалтанд орсон, 2.0 л/с ундаргатай, 30 м гүнтэй байна. Судалгаанд хамрагдсан 2 ус түгээх байраас 175 айл өрх, 6 ААНБ цэвэр усаар хангагддаг.



Зураг 28. Ус түгээх байруудын байршил

Түгээх байруудын байршил, усны физик-химийн үзүүлэлтүүдийг хүснэгт 102-т үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад өнгө, үнэргүй, рН 8.2-8.3 буюу сул шүлтлэг орчинтой, булингар 0.2-0.4 NTU, цахилгаан дамжуулах чанар (EC) 270-272 mS/m, исэлдэн ангижрах потенциал болох (ORP) 143-147 mV, нийт ууссан давс буюу (TDS) 1160-1180 ppm тус тус агуулагдаж байна. Үүнээс үзэхэд түгээх байруудын ус цахилгаан дамжуулах чанараараа “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 102. Олон-Овооны ус түгээх байруудын байршил, усны физик-химийн үзүүлэлт

Сорьц авсан газрын нэр	Солбицлын цэг	Фото зураг	Шинжилгээний үзүүлэлт
<b><u>Олон-Овоо-1 УТБ</u></b> 2021 онд ухаалаг системд шилжсэн	N 47°57'12.0" E 108°57'4.0"		T°C=4°C Булингар=0.4 NTU pH=8.3 <b>EC=272 mS/m</b> ORP=143 mV TDS=1180 ppm
<b><u>Олон-Овоо-2 УТБ</u></b>	N 45°57'18.0" E 108°56'57.0"		T°C=25°C Булингар=0.2 NTU pH=8.2 <b>EC=270 mS/m</b> ORP=147 mV TDS=1160 ppm

Ус түгээх байруудын усны химийн шинжилгээний дүнгээс харахад усны нийт хатуулаг 6.2-6.3 мг-экв/л буюу хатуувтар, нийт эрдэсжилт 1856.56-1882.97 мг/л буюу давсархаг усны ангилалд хамаарагдаж байна. Үндсэн катионуудаас натрийн ион давамгайлж ( $\text{Na}^+$ ) 509.9-514.6 мг/л, кальци ( $\text{Ca}^{2+}$ ) 72.1-78.1 мг/л, магни ( $\text{Mg}^{2+}$ ) 29.2-31.6 мг/л анионуудаас сульфатын ион давамгайлж ( $\text{SO}_4^{2-}$ ) 529.2-530.8 мг/л, хлор ( $\text{Cl}^-$ ) 469.6 мг/л, гидрокарбонат ( $\text{HCO}_3^-$ ) 201.3-213.5 мг/л, нитрат ( $\text{NO}_3^-$ ) 28.9-33.2 мг/л, фтор ( $\text{F}^-$ ) 3.56-3.65 мг/л тус тус агуулагдаж байна (Хүснэгт 103, 104). Үүнээс үзэхэд тус ус түгээх байруудын ус натри, магни, хлор, сульфат, фторын ион болон нийт эрдэсжилтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 103. Түгээх байруудын усны катионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	ПИЧ	Нийт хатуулаг, мг-экв/л	$\text{Na}^+$	$\text{K}^+$	$\text{Ca}^{2+}$	$\text{Mg}^{2+}$	$\text{NH}_4^+$	$\text{Fe}^{2+}$
Олон-Овоо-1 УТБ	1.2	6.3	514.6	1.9	78.1	29.2	-	-
Олон-Овоо-2 УТБ	1.2	6.2	509.9	2.0	72.1	31.6	-	-
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	<b>10</b>	<b>7.0</b>	<b>200</b>		<b>100</b>	<b>30</b>	<b>1.5</b>	<b>0.3</b>

Хүснэгт 104. Түгээх байруудын усны анионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	$\text{CO}_3^{2-}$	$\text{HCO}_3^-$	$\text{Cl}^-$	$\text{SO}_4^{2-}$	$\text{NO}_2^-$	$\text{NO}_3^-$	$\text{PO}_4^{3-}$	$\text{F}^-$	Нийт эрдэсжилт
Олон-Овоо-1 УТБ	12	213.5	469.6	530.8	0.04	33.2	0.01	3.65	1882.97
Олон-Овоо-2 УТБ	12	201.3	469.6	529.2	0.004	28.9	0.004	3.56	1856.56
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>			<b>350</b>	<b>500</b>	<b>1.0</b>	<b>50</b>	<b>3.5</b>	<b>0.7-1.5</b>	<b>1000</b>

Олон-Овооны 1, 2-р ус түгээх байрны усанд бичил элементүүдийн шинжилгээг 52 үзүүлэлтээр тодорхойлсон дүнг хүснэгт 105-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад түгээх байруудын усанд стронци ( $\text{Sr}$ ) 2875-2893 мкг/л агуулагдаж байгаа нь “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 105. Түгээх байруудын усны бичил элементүүдийн агууламж, мкг/л

№	Үзүүлэлтүүд	MNS 0900:2018 (ЗДА)	Олон-Овоо-1 УТБ	Олон-Овоо-2 УТБ
1	Ag (Мөнгө)	100	<0.2	<0.2
2	Al (Хөнгөнцагаан)	500	<10	<10
3	As (Хүнцэл)	10	7.59	7.69
4	Ba (Бари)	700	12	12
5	Be (Биндэр)	0.2	<0.1	<0.1
6	Bi (Висмут)		<0.01	<0.01
7	Cd (Зөөлөнцагаан)	3	<0.01	<0.01
8	Ce (Цери)		<0.05	<0.05
9	Co (Албин)		0.23	0.22
10	Cr (Хром)-нийт	50	<10	<10
11	Cs (Цези)		0.529	0.435
12	Cu (Зэс)	2000	<5	<5
13	Dy (Диспрози)		0.001	0.001
14	Er (Эрби)		0.001	0.001
15	Eu (Европи)		0.003	0.003
16	Ga (Галли)		0.03	0.03
17	Gd (Гадолини)		<0.003	<0.003
18	Hf (Гафни)		<0.004	<0.004
19	Hg (Мөнгөн Ус)	1	<0.5	<0.5

№	Үзүүлэлтүүд	MNS 0900:2018 (ЗДА)	Олон-Овоо-1 УТБ	Олон-Овоо-2 УТБ
20	Ho (Гольми)		<0.001	<0.001
21	In (Инди)		<0.001	<0.001
22	La (Лантан)		<0.01	<0.01
23	Lu (Лютеци)		<0.002	<0.002
24	Mn (Манган)	100	<5	<5
25	Mo (Анзан)	70	14	11
26	Nb (Ниоби)		0.007	0.007
27	Nd (Неодим)		<0.01	<0.01
28	Ni (Никель)	20	2.3	2.1
29	P (фосфор)	1142	<50	<50
30	Pb (Хар тугалга)	10	<0.5	<0.5
31	Pr (Празеодим)		<0.006	<0.006
32	Rb (Рубиди)		3.18	2.45
33	Sb (Хэврэг цагаан)	20	<0.2	<0.2
34	Sc (Сканди)		2	2
35	Se (Селен)	40	<0.2	<0.2
36	Sm (Самари)		<0.002	<0.002
37	Sn (Цагаантугалга)		<0.1	<0.1
38	Sr (Стронци)	2000	2893	2875
39	Ta (Тантал)		<0.001	<0.001
40	Tb (Терби)		<0.002	<0.002
41	Te (Теллур)		<0.1	<0.1
42	Th (Тори)		<0.002	<0.002
43	Ti (Титан)		<10	<10
44	Tl (Талли)		<0.007	<0.007
45	Tm (Тули)		<0.001	<0.001
46	U (Уран)	30	17.4	18.2
47	V (Ванади)		<10	<10
48	W (Вольфрам)		0.49	0.51
49	Y (Иттри)		0.024	0.024
50	Yb (Иттерби)		<0.001	<0.001
51	Zn (Цайр)	5000	<5	<5
52	Zr (Циркони)		0.09	0.10

Мөн түгээх байруудын усанд бичил амь судлалын шинжилгээг 6 үзүүлэлтээр тодорхойлсон дүнг хүснэгт 106-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад 1-р ус түгээх байрны усанд нийт нянгийн тоо стандартаас хэтрээгүй, бусад үзүүлэлтүүд илрээгүй байна. Харин 2-р ус түгээх байрны усны нийт нянгийн тоо стандартаас давсан, гэдэсний бүлгийн нян илэрсэн байна. Үүнээс үзэхэд Олон-Овоо-2 ус түгээх байрны ус нь бичил амь судлалын үзүүлэлтээрээ Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018 –ын шаардлага хангахгүй байна.

Хүснэгт 106. Түгээх байруудын усны бичил амь судлалын үзүүлэлт

Сорьц авсан газрын нэр	1 мл сорьцонд	100 мл сорьцонд			25 мл сорьцонд
	Нийт нянгийн тоо	Гэдэсний бүлгийн нян	<i>E.coli</i>	Халуунд тэсвэртэй <i>E.coli</i>	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян ( <i>Salmonella/ Shigella</i> )
Олон-Овоо-1 УТБ	3	0	-	-	-/-
Олон-Овоо-2 УТБ	580	70	-	-	-/-
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	<b>&lt;100</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

(- илрээгүй)

Судалгаанд хамрагдсан ус түгээх байруудын усанд  $^{222}\text{Rn}$  болон түүний задралын бүтээгдэхүүн тодорхойлсон дүнг хүснэгт 107-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад түгээх байруудын ус цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 107. Түгээх байруудын усны цацрагийн аюулгүйн үзүүлэлт, Бк/л

Сорьц авсан газрын нэр	Изотопын эзлэхүүний идэвх, Бк/л				
	$^{214}\text{Pb}$	$^{214}\text{Bi}$	$^{222}\text{Rn}$	$^{226}\text{Ra}$	$^{238}\text{U}$
Олон-Овоо-1 УТБ	67	74	71	<0.4	<0.4
Олон-Овоо-2 УТБ	65	70	69	<0.4	<0.4
Илрүүлэх доод хязгаар (1л эзэлхүүнтэй, 1 цаг хэмжих үед)	0.3	0.5	0.4	0.4	0.4
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	-	-	<b>100</b>	<b>0.5</b>	<b>0.37 (0.03мг/л)</b>

**Дүгнэлт:** Олон-Овооны №1, 2-р ус түгээх байруудын ус нь сул шүлтлэг орчинтой, хлор, сульфат-натрийн төрлийн хатуувтар, давсархаг усны ангилалд хамаарагдаж байна. Олон-Овоо-1, 2-р ус түгээх байруудын ус цахилгаан дамжуулах чанар, нийт эрдэсжилт, натри, хлор, сульфат, фторын ион болон стронцийн агуулгаараа “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангахгүй байна. Мөн түгээх байр -2-н ус магни, бичил амь судлалын үзүүлэлтээрээ ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлага хангахгүй байна.

**Зөвлөмж:** Судалгаагаар Олон-Овоо-2 УТБ-ны усанд нийт нянгийн тоо стандарт хэмжээнээс давсан, гэдэсний бүлгийн нян илэрсэн нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандартад тохирохгүй байна. Эрүүл ахуйн талаас авч үзвэл, тухайн хэрэглэгчид бохирдсон ундны усаар дамжих суулгалт өвчний халдварт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Тус халдварын үед ихэвчлэн бөөлжих, халуурах, шингэн алдах, электролитын тэнцвэр алдагдах зэрэг шинжүүд илрэх бөгөөд бусад хам шинжүүд хавсран тохиолдох нь түгээмэл байдаг. Тиймээс унданд шууд хэрэглэхэд тохиромжгүй бөгөөд буцалгаж хэрэглэх шаардлагатай. Тус ус түгээх байранд ариутгал, халдваргүйжүүлэлт хийсний дараа дахин бичил амь судлалын шинжилгээнд хамруулж унданд хэрэглэхийг зөвлөж байна.

Ус түгээх байруудыг цэвэр усаар хангадаг гүний худгийн усны цахилгаан дамжуулах чанар, нийт эрдэсжилт, натри, магни, хлор, сульфат, фторын ионы агуулга Монгол Улсад мөрдөгдөж буй ундны усны стандарт шаардлагыг хангахгүй байгаа тул унд, ахуйд шууд хэрэглэхэд тохиромжгүй, мөн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэйг анхаарах хэрэгтэй. Тиймээс тус 2 худагт анион болон катионитон шүүлтүүр бүхий ус зөөлрүүлэх сонгомол төхөөрөмж тавьж усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлж дахин шинжилгээнд хамруулж ашиглахыг зөвлөж байна.

Бичил элементийн шинжилгээгээр уг худгийн усны стронцийн агуулга Монгол Улсад мөрдөгдөж буй ундны усны стандартын шаардлагыг хангахгүй байна. Ундны усаар дамжих стронцийн үйлчлэл нь ялангуяа, бага насны хүүхдэд рахит үүсгэх эрсдэлтэй. Иймд адсорбцлох (манганы исэл) болон урвуу осмосын аргуудыг ашиглан бууруулж, дахин бичил элементийн судалгаанд хамруулж унданд хэрэглэхийг зөвлөж байна.

### 3.4.3. Өлзийт зөрлөг СКВ-1

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт байрлах Өлзийт зөрлөгийн СКВ-1 худгаас сорьц авч шинжилгээнд хамруулсан болно. Тус худга нь “УБТЗ” ХНН-ийн Эрчим хүч, ус хангамжийн 2-р ангид харьяалагддаг. Худгийн паспорттай, 2.0 л/с ундаргатай, ус ашиглах зөвшөөрөл дүгнэлттэй, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн шаардлага хангасан хашаатай байна.



Зураг 29. Өлзийт зөрлөг СКВ-1, байршил

Уг худгийн байршил, усны физик-химийн үзүүлэлтүүдийг хүснэгт 108-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад өнгө, үнэргүй, рН 8.5 буюу шүлтлэг орчинтой, булингар 0.2 NTU, цахилгаан дамжуулах чанар (EC) 68.5 mS/m, исэлдэн ангижрах потенциал болох (ORP) 135 mV, нийт ууссан давс буюу (TDS) 263 ppm агуулагдаж байгаа нь “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 108. Өлзийт зөрлөг СКВ-1 байршил, усны физик-химийн үзүүлэлт

Ашиглалтанд орсон он	Гүний худгийн мэдээлэл		Солбицлын цэг		Шинжилгээний үзүүлэлт	
2008	Цооногийн гүн	65 м	N	46°0'45.56"	Т°С	6°С
					Булингар	0.2 NTU
					рН	8.5
	Хангагдаж буй хүн ам	-	E	108°48'11.26"	EC	68.5 mS/m
					ORP	135 mV
					TDS	263 ppm

Өлзийт зөрлөгийн худгийн усанд химийн шинжилгээ хийж үр дүнг хүснэгт 109, 110-т үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад усны нийт хатуулаг 4.2 мг-экв/л буюу зөөлөвтөр, нийт эрдэжилт 524.4 мг/л буюу цэнгэгдүү усны ангилалд хамаарагдаж байна. Үндсэн катионуудаас натрийн ион давамгайлж ( $\text{Na}^+$ ) 71.7 мг/л, кальци ( $\text{Ca}^{2+}$ ) 46.1 мг/л, магни ( $\text{Mg}^{2+}$ ) 23.1 мг/л анионуудаас гидрокарбонатын ион давамгайлж ( $\text{HCO}_3^-$ ) 225.7 мг/л, сульфат ( $\text{SO}_4^{2-}$ ) 78.2 мг/л, хлор ( $\text{Cl}^-$ ) 36.9 мг/л, нитрат ( $\text{NO}_3^-$ ) 23.6 мг/л, фтор ( $\text{F}^-$ ) 4.05 мг/л тус тус агуулагдаж байна. Тиймээс тус худгийн ус фторын ионы агуулгаараа Монгол Улсад мөрдөгдөж байгаа ундны усны стандарт MNS 0900:2018-ын шаардлагыг хангахгүй байна.

Хүснэгт 109. Өлзийт зөрлөг СКВ-1 усны катионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	ПИЧ	Нийт хатуулаг, мг-экв/л	$\text{Na}^+$	$\text{K}^+$	$\text{Ca}^{2+}$	$\text{Mg}^{2+}$	$\text{NH}_4^+$	$\text{Fe}_{\text{нийт}}$
Өлзийт зөрлөг СКВ-1	0.9	4.2	71.7	1.2	46.1	23.1	-	-
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	<b>10</b>	<b>7.0</b>	<b>200</b>		<b>100</b>	<b>30</b>	<b>1.5</b>	<b>0.3</b>

Хүснэгт 110. Өлзийт зөрлөг СКВ-1 усны анионы найрлага, мг/л

Сорьц авсан газрын нэр	CO <sub>3</sub> <sup>2-</sup>	HCO <sub>3</sub> <sup>-</sup>	Cl <sup>-</sup>	SO <sub>4</sub> <sup>2-</sup>	NO <sub>2</sub> <sup>-</sup>	NO <sub>3</sub> <sup>-</sup>	PO <sub>4</sub> <sup>3-</sup>	F <sup>-</sup>	Нийт эрдэсжилт
Өлзийт зөрлөг СКВ-1	18	225.7	36.9	78.2	0.001	23.6	0.01	4.05	524.4
<b>MNS 0900:2018 (ЗДА)</b>	-		<b>350</b>	<b>500</b>	<b>1.0</b>	<b>50</b>	<b>3.5</b>	<b>0.7-1.5</b>	<b>1000</b>

Мөн тус худгийн усанд бичил элементүүдийн шинжилгээг 52 үзүүлэлтээр тодорхойлсон дүнг хүснэгт 111-д үзүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад худгийн ус “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 111. Өлзийт зөрлөг СКВ-1 усны бичил элементүүдийн агууламж, мкг/л

№	Үзүүлэлтүүд	MNS 0900:2018 (ЗДА)	Өлзийт СКВ-1
1	Ag (Мөнгө)	100	<0.2
20	Алтанширээ сум	Цагаан худаг	Натри ( $\text{Na}^+$ ) 200 мг/л байхаас 377.98 мг/л, магни ( $\text{Mg}^{2+}$ ) 30 мг/л байхаас 41.34 мг/л, нитрат ( $\text{NO}_3^-$ ) 50 мг/л байхаас 59.6 мг/л, фтор ( $\text{F}^-$ ) 0.7-1.5 мг/л байхаас 3.29 мг/л, нийт эрдэжилт 1000 мг/л байхаас 1589.68 мг/л, анзан (Mo) 70 мкг/л байхаас 70.7 мкг/л, стронци (Sr) 2000 мкг/л байхаас 4230 мкг/л, уран (U) 30 мкг/л байхаас 171 мкг/л, нийт нянгийн тоо 100 байхаас 392, гэдэсний бүлгийн нян илэрсэн байгаа нь тус тус стандартын шаардлага хангахгүй байна.
21		Цагаан тээг	Фтор ( $\text{F}^-$ ) 0.7-1.5 мг/л байхаас 0.04 мг/л, хүнцэл (As) 10 мкг/л байхаас 12.5 мкг/л тус тус агуулагдаж байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.
22	Даланжаргалан сум	Ус түгээх байр №1	Цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 103.5 mS/m, фтор ( $\text{F}^-$ ) 0.7-1.5 мг/л байхаас 2.95 мг/л, биндэр (Be) 0.2 мкг/л байхаас 1.7 мкг/л агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
23		Ус түгээх байр №2	Цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 102.3 mS/m, фтор ( $\text{F}^-$ ) 0.7-1.5 мг/л байхаас 3.07 мг/л, биндэр (Be) 0.2 мкг/л байхаас 0.4 мкг/л агуулагдаж байгаа нь стандарт шаардлагыг хангахгүй байна.
24		Олон-Овоо УТБ-1	Цахилгаан дамжуулах чанар (EC) 100 mS/m байхаас 272 mS/m, натри ( $\text{Na}^+$ ) 200 мг/л байхаас 514.6 мг/л, хлор 350 мг/л байхаас 469.6 мг/л, сульфат 500 мг/л байхаас 530.8 мг/л, фторын агуулга 0.7-1.5 мг/л байхаас 3.65 мг/л, стронци (Sr) 2000 мкг/л байхаас 28793 мкг/л агуулагдаж байгаа нь стандарт шаардлага хангахгүй байна.
25		Олон-Овоо УТБ-2	Бичил амь судлалын шинжилгээгээр гэдэсний бүлгийн нян, халуунд тэсвэртэй <i>E.coli</i> илэрсэн, Цахилгаан дамжуулах чанар (EC) 100 mS/m байхаас 270 mS/m, натри ( $\text{Na}^+$ ) 200 мг/л байхаас 509.8 мг/л, магни ( $\text{Mg}^{2+}$ ) ион 30 мг/л байхаас 31.6 мг/л, хлор 350 мг/л байхаас 469.6 мг/л, сульфат 500 мг/л байхаас 529.2 мг/л, фторын агуулга 0.7-1.5 мг/л байхаас 3.56 мг/л, стронци (Sr) 2000 мкг/л байхаас 2875 мкг/л байгаа нь стандарт шаардлага хангахгүй байна.
26		Өлзийт зөрлөг СКВ-1	Фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 4.05 мг/л, байгаа нь стандартад нийцэхгүй байна.
27		Дэлгэрэх сум	“Чандмань-Илч” ОНӨ ХХК-ийн худаг
28	Ус түгээх 1-р байр		Цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 127.5 mS/m, натри ( $\text{Na}^+$ ) 200 мг/л байхаас 248.07 мг/л, фтор ( $\text{F}^-$ ) 0.7-1.5 мг/л байхаас 4.68 мг/л, нийт эрдэжилт 1000 мг/л байхаас 1022.3 мг/л, анзан (Mo) 70 мкг/л байхаас 76.6 мкг/л нийт нянгийн тоо 100 байхаас 316, гэдэсний бүлгийн нян илэрсэн байгаа нь тус тус стандартын шаардлага хангахгүй байна.
29	Замын-Үүд сум	Худаг №6	Цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 406 mS/m, нийт хатуулаг 7 мг-экв/л байхаас 12.2 мг-экв/л, натри ( $\text{Na}^+$ ) 200 мг/л байхаас 681.6 мг/л, кальци ( $\text{Ca}^{2+}$ ) 100 мг/л байхаас 102.1 мг/л, магни ( $\text{Mg}^{2+}$ ) 30 мг/л байхаас 86.3 мг/л, хлор ( $\text{Cl}^-$ ) 350 мг/л байхаас 847.9 мг/л, сульфат ( $\text{SO}_4^{2-}$ ) 500 мг/л байхаас 515.2 мг/л, нийт эрдэжилт 1000 мг/л байхаас 2666.22 мг/л, хүнцэл (As) 10 мкг/л байхаас 16.2 мкг/л, селен (Se) 40 мкг/л байхаас 136 мкг/л, стронци (Sr) 2000 мг/л байхаас 4137 мг/л, уран (U) 30 мкг/л

№	Сумын нэр	Сорьцын нэр	Ундны усны стандарт хангахгүй байгаа үзүүлэлтүүд
			байхаас 71.8 мкг/л тус тус агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
30		Худаг №15	Цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 303 mS/m, нийт хатуулаг 7 мг-экв/л байхаас 7.4 мг-экв/л, натри (Na <sup>+</sup> ) 200 мг/л байхаас 554.4 мг/л, магни (Mg <sup>2+</sup> ) 30 мг/л байхаас 51.1 мг/л, хлор (Cl <sup>-</sup> ) 350 мг/л байхаас 597.7 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 2.04 мг/л, нийт эрдэжилт 1000 мг/л байхаас 2095.55 мг/л, хүнцэл (As) 10 мкг/л байхаас 21.7 мкг/л, селен (Se) 40 мг/л байхаас 95.1 мкг/л, стронци (Sr) 2000 мкг/л байхаас 2305 мкг/л, уран (U) 30 мкг/л байхаас 64.7 мкг/л тус тус агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
31		Худаг №19	Цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 330 mS/m, нийт хатуулаг 7 мг-экв/л байхаас 9.4 мг-экв/л, натри (Na <sup>+</sup> ) 200 мг/л байхаас 571.3 мг/л, магни (Mg <sup>2+</sup> ) 30 мг/л байхаас 79.0 мг/л, хлор (Cl <sup>-</sup> ) 350 мг/л байхаас 611.6 мг/л, нийт эрдэжилт 1000 мг/л байхаас 2238.02 мг/л, хүнцэл (As) 10 мкг/л байхаас 12.9 мкг/л, селен (Se) 40 мг/л байхаас 279 мкг/л, стронци (Sr) 2000 мкг/л байхаас 3079 мкг/л, уран (U) 30 мкг/л байхаас 64.3 мкг/л агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
32		Худаг №20	Цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 332 mS/m, нийт хатуулаг 7 мг-экв/л байхаас 9.4 мг-экв/л, натри (Na <sup>+</sup> ) 200 мг/л байхаас 578.3 мг/л, магни (Mg <sup>2+</sup> ) 30 мг/л байхаас 65.7 мг/л, хлор (Cl <sup>-</sup> ) 350 мг/л байхаас 625.5 мг/л, нийт эрдэжилт 1000 мг/л байхаас 2266.36 мг/л, хүнцэл (As) 10 мкг/л байхаас 14.2 мкг/л, селен (Se) 40 мкг/л байхаас 254 мг/л, стронци (Sr) 2000 мкг/л байхаас 3148 мкг/л, уран (U) 30 мкг/л байхаас 65.8 мкг/л агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
33		Худаг №5	Бичил амь судлалын шинжилгээгээр гэдэсний бүлгийн нян илэрсэн, цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 308 mS/m, нийт хатуулаг 7 мг-экв/л байхаас 7.8 мг-экв/л, натри (Na <sup>+</sup> ) 200 мг/л байхаас 592.8 мг/л, магни (Mg <sup>2+</sup> ) 30 мг/л байхаас 46.2 мг/л, хлор (Cl <sup>-</sup> ) 350 мг/л байхаас 639.4 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 2.59 мг/л, нийт эрдэжилт 1000 мг/л байхаас 2194.18 мг/л, хүнцэл (As) 10 мкг/л байхаас 18.3 мкг/л, селен (Se) 40 мкг/л байхаас 107 мкг/л, стронци (Sr) 2000 мкг/л байхаас 2268 мкг/л, уран (U) 30 мкг/л байхаас 75.5 мкг/л агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
34		Худаг №8	Бичил амь судлалын шинжилгээгээр гэдэсний бүлгийн нян илэрсэн, цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 374 mS/m, нийт хатуулаг 7 мг-экв/л байхаас 9.2 мг-экв/л, натри (Na <sup>+</sup> ) 200 мг/л байхаас 651.5 мг/л, магни (Mg <sup>2+</sup> ) 30 мг/л байхаас 60.8 мг/л, хлор (Cl <sup>-</sup> ) 350 мг/л байхаас 750.6 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 2.56 мг/л, нийт эрдэжилт 1000 мг/л байхаас 2426.03 мг/л, хүнцэл (As) 10 мкг/л байхаас 18.1 мкг/л, селен (Se) 40 мкг/л байхаас 84 мкг/л, стронци (Sr) 2000 мкг/л байхаас 2713 мкг/л, уран (U) 30 мкг/л байхаас 80.6 мкг/л агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
35		Худаг №13	Бичил амь судлалын шинжилгээгээр гэдэсний бүлгийн нян илэрсэн, цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 390 mS/m, нийт хатуулаг 7 мг-экв/л байхаас 9.5 мг-экв/л, натри (Na <sup>+</sup> ) 200 мг/л байхаас 653.4 мг/л, магни (Mg <sup>2+</sup> ) 30 мг/л байхаас 64.5 мг/л, хлор (Cl <sup>-</sup> ) 350 мг/л байхаас 722.8 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 2.47 мг/л, нийт эрдэжилт 1000 мг/л байхаас 2455.24 мг/л, хүнцэл (As) 10 мкг/л байхаас 17.2 мкг/л, селен (Se) 40 мкг/л байхаас 104 мкг/л, стронци (Sr) 2000 мкг/л байхаас

№	Сумын нэр	Сорьцын нэр	Ундны усны стандарт хангахгүй байгаа үзүүлэлтүүд
36			2763 мкг/л, уран (U) 30 мкг/л байхаас 78.8 мкг/л агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
		Худаг №16	Бичил амь судлалын шинжилгээгээр гэдэсний бүлгийн нян илэрсэн, цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 328 mS/m, нийт хатуулаг 7 мг-экв/л байхаас 8 мг-экв/л, натри (Na <sup>+</sup> ) 200 мг/л байхаас 573.6 мг/л, магни (Mg <sup>2+</sup> ) 30 мг/л байхаас 51.1 мг/л, хлор (Cl <sup>-</sup> ) 350 мг/л байхаас 653.3 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 2.31 мг/л, нийт эрдэжилт 1000 мг/л байхаас 2135.93 мг/л, хүнцэл (As) 10 мг/л байхаас 16.9 мг/л, селен (Se) 40 мкг/л байхаас 153 мг/л, стронци (Sr) 2000 мг/л байхаас 2360 мкг/л, уран (U) 30 мкг/л байхаас 70.1 мкг/л агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
		Тохижилтын худаг	Бичил амь судлалын шинжилгээгээр гэдэсний бүлгийн нян илэрсэн, цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 252 mS/m, натри (Na <sup>+</sup> ) 200 мг/л байхаас 474.1 мг/л, магни (Mg <sup>2+</sup> ) 30 мг/л байхаас 36.5 мг/л, хлор (Cl <sup>-</sup> ) 350 мг/л байхаас 444.8 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 2.31 мг/л, нийт эрдэжилт 1000 мг/л байхаас 1774.4 мг/л, хүнцэл (As) 10 мкг/л байхаас 13.7 мкг/л, селен (Se) 40 мкг/л байхаас 167 мкг/л, уран (U) 30 мкг/л байхаас 66.3 мкг/л агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
38		Замын-Үүд өртөөний 2-р байрны ус	Бичил амь судлалын шинжилгээгээр нийт нянгийн тоо стандартаас хэтэрсэн, гэдэсний бүлгийн нян илэрсэн, цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 530 mS/m, нийт хатуулаг 7 мг-экв/л байхаас 9.6 мг-экв/л, нийт эрдэжилт 1000 мг/л байхаас 3526.46 мг/л, натрийн (Na <sup>+</sup> ) ион 200 мг/л байхаас 1035.4 мг/л, магни (Mg <sup>2+</sup> ) ион 30 мг/л байхаас 63.23 мг/л, хлорын (Cl <sup>-</sup> ) ион 350 мг/л байхаас 1106.99 мг/л, сульфатын (SO <sub>4</sub> <sup>2-</sup> ) ион 500 мг/л байхаас 725.89 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 2.98 мг/л, хүнцэл (As) 10 байхаас 13.6 мкг/л, стронци 2000 мкг/л байхаас 2677 мкг/л, манган 100 мкг/л байхаас 129 мкг/л тус тус агуулагдаж байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.
39	Иххэт сум	Эх үүсвэрийн 8-р худаг	Биндэр (Be) 0.2 мкг/л байхаас 0.3 мкг/л, манган (Mn) 100 мкг/л 222 мкг/л, уран (U) 30 мкг/л байхаас 30.4 мкг/л агуулагдаж байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.
40		1-р ус түгээх байр	Биндэр (Be) 0.2 мкг/л байхаас 0.3 мкг/л, манган (Mn) 100 мкг/л 221 мкг/л, уран (U) 30 мкг/л байхаас 30.5 мкг/л агуулагдаж байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.
41	Мандах сум	Төхөм-1 худаг	Бичил амь судлалын шинжилгээгээр гэдэсний бүлгийн нян илэрсэн нь стандартад нийцэхгүй байна.
42		Төхөм-2 худаг	Бичил амь судлалын шинжилгээгээр гэдэсний бүлгийн нян, халуунд тэсвэртэй <i>E.coli</i> илэрсэн, нийт хатуулаг 7 мг-экв/л байхаас 7.4 мг-экв/л, кальци (Ca <sup>2+</sup> ) 100 мг/л байхаас 104.1 мг/л, нитрат (NO <sub>3</sub> <sup>-</sup> ) 50 мг/л байхаас 87.68 мг/л, хүнцэл (As) 10 мкг/л байхаас 15.1 мкг/л агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
43	Өргөн сум	Шанаган могойн худаг	Бичил амь судлалын шинжилгээгээр нийт нянгийн тоо стандартаас давсан, гэдэсний бүлгийн нян илэрсэн, цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 252 mS/m, натри (Na <sup>+</sup> ) 200 мг/л байхаас 541.5 мг/л, сульфат (SO <sub>4</sub> <sup>2-</sup> ) 500 мг/л байхаас 635.4 мг/л, нийт эрдэжилт 1000 мг/л байхаас 1864.7 мг/л, хүнцэл (As) 10 мкг/л байхаас 60.8 мкг/л тус тус агуулагдаж байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.

№	Сумын нэр	Сорьцын нэр	Ундны усны стандарт хангахгүй байгаа үзүүлэлтүүд
44		Ухаалаг худаг №2	Бичил амь судлалын шинжилгээгээр нийт нянгийн тоо стандартаас давсан, гэдэсний бүлгийн нян илэрсэн, цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 245 mS/m, натри (Na <sup>+</sup> ) 200 мг/л байхаас 518.2 мг/л, сульфат (SO <sub>4</sub> <sup>2-</sup> ) 500 мг/л байхаас 634.5 мг/л, нийт эрдэсжилт 1000 мг/л байхаас 1781.5 мг/л, хүнцэл (As) 10 мкг/л байхаас 59.6 мкг/л тус тус агуулагдаж байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна
45	Сайхандулаан сум	Өлзийт-1 худаг	Магнийн ион (Mg <sup>2+</sup> ) 30 мг/л байхаас 32.83 мг/л агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
46		Өлзийт-2 худаг	Магнийн ион (Mg <sup>2+</sup> ) 30 мг/л байхаас 38.91 мг/л, нитрат (NO <sub>3</sub> <sup>-</sup> ) 50 мг/л байхаас 65.77 мг/л агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
47	Улаанбадрах сум	Цагаан худаг	Бичил амь судлалын шинжилгээгээр гэдэсний бүлгийн нян илэрсэн, цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 102 mS/m, нитрат (NO <sub>3</sub> <sup>-</sup> ) 50 мг/л байхаас 62.07 мг/л, (U) 30 мкг/л байхаас 38.7 мкг/л, ( <sup>222</sup> Rn) 100 Бк/л байхаас 107 Бк/л агуулагдаж байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна
48		Болор-2 худаг	Бичил амь судлалын шинжилгээгээр нийт нянгийн тоо стандартаас давсан, гэдэсний бүлгийн нян илэрсэн, цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 106 mS/m, нитрат (NO <sub>3</sub> <sup>-</sup> ) 50 мг/л байхаас 64.2 мг/л, (U) 30 мкг/л байхаас 30.4 мкг/л, 0.7-1.5 мг/л байхаас 1.83 мг/л тус тус агуулагдаж байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна
49	Хатанбулаг сум	Хилийн цэргийн 0168-р ангийн худаг	Бичил амь судлалын шинжилгээгээр гэдэсний бүлгийн нян илэрсэн, Фтор (F <sup>-</sup> ) 0.7-1.5 мг/л байхаас 3.07 мг/л, хүнцэл (As) 10 мкг/л байхаас 12.8 мкг/л байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.
50		Хилийн цэргийн 0168-р ангийн туслах аж ахуйн худаг	Бичил амь судлалын шинжилгээгээр гэдэсний бүлгийн нян илэрсэн, цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 234 mS/m, нийт хатуулаг 7 мг-экв/л байхаас 7.3 мг-экв/л, натри (Na <sup>+</sup> ) 200 мг/л байхаас 381.59 мг/л, магни (Mg <sup>2+</sup> ) 30 мг/л байхаас 40.13 мг/л, хлор (Cl <sup>-</sup> ) 350 мг/л байхаас 465.66 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 2.77 мг/л, нийт эрдэсжилт 1000 мг/л байхаас 1539.52 мг/л, стронци (Sr) 2000 мкг/л байхаас 2055 мкг/л, уран (U) 30 мкг/л байхаас 39.5 мкг/л агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
51		Гүний худаг-2	Цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 116.7 mS/m, натри (Na <sup>+</sup> ) 200 мг/л байхаас 200.27 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 3.89 мг/л байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.
52		Гүний худаг-1	Цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 116.7 mS/m, натри (Na <sup>+</sup> ) 200 мг/л байхаас 200.27 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 3.89 мг/л байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.
53		Гүний худаг-1 ийн шүүсний дараах ус	Нийт нянгийн тоо стандартаас хэтэрсэн, гэдэсний бүлгийн нян, халуунд тэсвэртэй <i>E.coli</i> илэрсэн, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 0.31 мг/л байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.
54		Ханги боомтын худаг	Бичил амь судлалын шинжилгээгээр гэдэсний бүлгийн нян илэрсэн, цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 105 mS/m, магни (Mg <sup>2+</sup> ) 30 мг/л байхаас 43.78 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 0.04 мг/л байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.
55		Баян-Овоогийн худаг	Гэдэсний бүлгийн нян илэрсэн нь стандартад нийцэхгүй байна.
56		Хөвсгөл сум	Гэрлийн шандын худаг

№	Сумын нэр	Сорьцын нэр	Ундны усны стандарт хангахгүй байгаа үзүүлэлтүүд
			фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 2.81 мг/л, нийт эрдэсжилт 1000 мг/л байхаас 1387.61 мг/л, уран (U) 30 мг/л байхаас 40 мг/л агуулагдаж байгаа нь стандартад нийцэхгүй байна.
57		Гэрлийн шандын худгийн шүүсний дараах ус	Нийт нянгийн тоо стандартаас хэтэрсэн, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 1.65 мг/л байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.
58	Эрдэнэ сум	Бүхэл/18-ийн худаг	Цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 100.4 mS/m, нитрат 50 мг/л байхаас 54.28 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 3.89 мг/л, хүнцэл (As) 10 байхаас 11.2 мкг/л агуулагдаж байгаа нь стандарт шаардлага хангахгүй байна.
59		Улаан-Уул өртөө УТБ-1	Нитрат 50 мг/л байхаас 54.19 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 3.38 мг/л, хүнцэл (As) 10 байхаас 11.4 мкг/л тус тус агуулагдаж байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.
60		Улаан-Уул өртөө УТБ-2	Цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 102 mS/m, нитрат 50 мг/л байхаас 55.42 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 2.71 мг/л, хүнцэл (As) 10 байхаас 11.2 мкг/л тус тус агуулагдаж байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна.
61		Улаан-Уул өртөө УТБ-3	Цахилгаан дамжуулах чанар 100 mS/m байхаас 101.4 mS/m, нитрат 50 мг/л байхаас 55.81 мг/л, фторын ион 0.7-1.5 мг/л байхаас 2.74 мг/л, хүнцэл (As) 10 байхаас 11.4 мкг/л агуулагдаж байгаа нь стандарт шаардлага хангахгүй байна.

## 5. СУДАЛГААНЫ ҮР ДҮНД ТУЛГУУРЛАН ТООЦСОН АЮУЛГҮЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ УСААР ХАНГАГДАЖ БАЙГАА ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Монгол Улсын Их Хурлын 2020.05.13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталж, Хүнд ээлтэй амьдрах орчныг бүрдүүлэхтэй холбоотой зорилт 2.5-д Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлэхээр тусгасан. Энэхүү урт хугацааны бодлогын хүрээнд 2030 он гэхэд баталгаат ундны ус хангамжийн үйлчилгээ хүртэж байгаа хүн амын эзлэх хувийг 87 хувьд хүргэхээр зорилт тавин ажиллаж байна.

Энэхүү түвшинг бодит байдалд ойртуулах үүднээс төсөлд хамрагдсан усны сорьцуудын шинжилгээний үр дүн, судалгааны багийн газар дээрээс нь цуглуулсан анхдагч мэдээллүүдийг ашигласан болно. Түүнчлэн Монгол улсын хүн амын 2021 оны статистикийн мэдээ, Үндэсний статистикийн хорооноос боловсруулан гаргасан “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018”-г ашиглалаа.

Тус шалгуурыг тогтоохын тулд “Шаардлага хангасан болон сайжруулсан эх үүсвэр”, “Шаардлага хангаагүй эх үүсвэр”, “Аюулгүй зохион байгуулагдсан” гэсэн ойлголтуудыг тодорхойлох шаардлагатай болно.

**Шаардлага хангасан болон сайжруулсан** гэдэгт төвлөрсөн шугамд холбогдсон орон сууцны айл өрхөөс гадна төвлөрсөн шугамд холбогдсон УТБ, гүний худгаар үйлдчлүүлдэг, ундны ус нь хангалттай, усны суурь үйлчилгээг хүртэж байгаа буюу ус авахдаа 30 хүртэлх минутын хугацаа зарцуулдаг айл өрхийг авч үзсэн.

**Шаардлага хангаагүй** гэдэгт судалгаагаар гадаргын урсац орохоос хамгаалагдаагүй усны эх үүсвэрээс хэрэглэж байгаа, хөрсний ус хэрэглэдэг айл өрхийг авч үзсэн болно.


**Аюулгүй зохион байгуулагдсан** гэдэгт эрүүл ахуйн дэглэмийг мөрдүүлэн, хашаа хаалтаар хамгаалагдсан, тогтмол шинжилгээ хийдэг бөгөөд шинжилгээгээр ундны усны стандартын шаардлагад нийцсэн, гэдэсний савханцар буюу *E. coli* илрээгүй эх үүсвэрээс ус хараглаж байгааг авч үзлээ. Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо судалгаанд хамрагдсан худгуудын усны шинжилгээний үр дүн болон бусад хамаарах үзүүлэлтийг хамруулав.

“Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018” судалгаагаар ундны усны аюулгүй байдал, хүртээмжийн талаарх гол үзүүлэлтүүдийг хот, суурин газрын төвлөрсөн бус эх үүсвэртэй айл өрхийн хэмжээнд гаргаж тооцсон байна.

Үндэсний Статистикийн Хорооны гаргасан сайжруулсан эх үүсвэрээс “Ус хэрэгтэй үед ундны ус хангалттай хэмжээнд байсан” гэдэг үзүүлэлт нь Улаанбаатар хотод 80.7%, аймгийн төвд 90.4%, сумын төвд 93.7% гэсэн үзүүлэлт байна.

“Аюулгүй зохион байгуулагдсан усны эх үүсвэрээс ус хэрэглэж байгаа хүн амын эзлэх хувь” гэсэн үзүүлэлтийг 2021 оны статистикийн мэдээ, судалгааны дүн зэрэгт тулгуурлан тооцож Хүснэгт 269-д харуулсан болно.





Зураг 56. Аюулгүй зохион байгуулагдсан усаар хангагдсан хүн амын эзлэх хувь

Судалгааны баг Дорноговь аймгийн ундны усны чанар, аюулгүй байдлын судалгаанд төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон болон ус түгээх байрны хэрэглэгчийн тоог ашиглаж, сумдын сайжруулсан эх үүсвэрээс хангагдаж буй хүн амын тоог тодорхойллоо.

Хүснэгт 269-өөс харахад аюулгүй зохион байгуулагдсан усны эх үүсвэрээс ус хэрэглэж байгаа хүн амын эзлэх хувь нь Дорноговь аймгийн хэмжээнд дунджаар 73.2 % -тай гарсан байна.

Хүснэгт 269. Дорноговь аймгийн аюулгүй зохион байгуулагдсан усны эх үүсвэрээс хангагдаж буй хүн амын хувь

№	Сум	Хүн амын тоо	Үүнээс		Шаардлага хангасан эх үүсвэрээс хэрэглэж байгаа				Шаардлага хангаагүй эх үүсвэрээс хэрэглэж байгаа		Судалгаагаар үндэний усны стандарт хангаагүй үс хэрэглэж байгаа		Аюулгүй, хүртээмжтэй усаар хангагдсан хүн амын тоо		Аюулгүй, хүртээмжтэй усаар хангагдсан хүн амын эзлэх хувь %	Усны үнэ, (төгл эсвэл төг/сар)
			Сумын төв	Хөдөө	Төвлөрсөн шугамд холбогдсон	УТ-аас усаа авдаг	Хашандаа худалтай	Бүгд	Үүнээс хангалттай үс хэмжээний үс	Шинжилгээнд хамрагдаагүй эсвэл хөрөнгий үс хэрэглэдэг	Судалгаагаар үндэний усны стандарт хангаагүй үс хэрэглэж байгаа	Сумын төв, суурин газрын	Хөдөөгийн	Аюулгүй зохион байгуулагдсан усаар хангагдаагүй		
1	Сайншанд	27,405	27,405	-	-	27,405	-	27,405	24,774	-	1,700	2,631	-	24,774	90.4%	2.0
2	Айраг	3,598	2,178	1,420	-	2,178	-	2,178	2,041	1,420	1,026	137	1,420	2,041	56.7%	3.0
3	Алтанширээ	1,533	558	975	-	558	-	558	523	975	-	35	975	523	34.1%	2.0
4	Даланжаргалан	2,983	1,600	1,383	-	1,600	-	1,600	1,499	1,383	272	101	1,383	1,499	50.3%	2.0
5	Дэлгэрэх	1,918	672	1,246	-	672	-	672	630	1,246	406	42	1,246	630	32.8%	2.0
6	Замын-Үүд	18,995	18,995	-	-	18,995	-	18,995	17,798	-	34	1,197	-	17,798	93.7%	2.0
7	Иххэт	2,087	861	1,226	-	861	-	861	807	1,226	544	54	1,226	807	38.7%	2.0
8	Мандах	1,550	292	1,258	-	292	-	292	274	1,258	114	18	1,258	274	17.7%	2.0
9	Өргөн	2,155	1,132	1,023	-	1,132	-	1,132	1,061	1,023	-	71	1,023	1,061	49.2%	2.0
10	Сайхандулаан	1,411	356	1,055	-	356	-	356	334	1,055	-	22	1,055	334	23.6%	2.0
11	Улаанбадрах	1,519	311	1,208	-	311	-	311	291	1,208	-	20	1,208	291	19.2%	2.0
12	Хатанбулаг	3,007	928	2,079	-	928	-	928	870	2,079	408	58	2,079	870	28.9%	2.0
13	Хөвсгөл	1,534	367	1,167	-	367	-	367	344	1,167	476	23	1,167	344	22.4%	2.0
14	Эрдэнэ	2,418	1,671	747	-	1,671	-	1,671	1,566	747	1,360	105	747	1,566	64.8%	2.0
НИЙТ		72,113				57,326		57,326	52,810	14,787	6,340	4,516	14,787	52,810	73.2%	

## 6. ЗӨВЛӨМЖ

### 5.1. Бохирдлын эх үүсвэр, тэдгээрийг бууруулах, цэвэрлэх арга

Унд, ахуйд хэрэглэгдэх усыг стандартын шаардлага хангахуйц чанарыг сайжруулах нь эдийн засаг, нийгэм, хүний эрүүл мэндэд чухал ач холбогдолтой. Усны чанарыг сайжруулах, зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлттэй элемент, бохирдол болон бусад хольцыг цэвэрлэх, усыг боловсруулах олон аргууд байдаг. Усны бохирдлыг хангалттай хэмжээгээр багасгах, эрүүл мэндийг хамгаалахын тулд олон талт аргуудыг ашиглах шаардлагатай. Ус цэвэрлэхэд механик, физик-химийн, химийн, дулааны гэх мэт олон аргуудыг хэрэглэж байна. Эдгээр аргуудад тунгаах, шүүх, зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх, саармагжуулах, хийг зайлуулах зэрэг аргууд орно. Усны чанарыг сайжруулах, усыг цэвэрлэх аргууд нь усны найрлага, шинж чанар, бохирдуулагч бодис зэргээс хамаарч боловсруулах технологи, тоног төхөөрөмж, хэрэглэх аргууд зэрэг нь өөр өөр байдаг.

Усны чанарыг сайжруулах, бохирдлыг бууруулахын тулд тухайн усны чанарын үзүүлэлт, бохирдуулагч элементийн хэмжээг тодорхойлох нь чухал байдаг. Тиймээс ундны усны зарим бохирдол, түүний эх үүсвэр болон бохирдлыг бууруулах аргуудын талаар дараах байдлаар тодорхойлно.

**Хатуулаг:** Хүн амын унд, ахуйд хэрэглэж байгаа усны чанарын чухал нэг үзүүлэлт нь усны хатуулаг юм. Усны хатуулаг гэдэг нь түүний найрлага дахь кальци, магнийн давсны хэмжээгээр тодорхойлогддог. Усны хатуулгийг түр зуурын болон байнгын гэж ангилдаг бөгөөд усанд агуулагдаж байгаа бикарбонат, кальци, магнийн хэмжээгээр карбонатын хатуулаг тодорхойлогддог бол усыг буцалгахад магни, кальцийн бикарбонат задран карбонатын хатуулаггүй болдог. Иймд карбонатын хатуулгыг түр зуурын буюу устгагдах хатуулаг гэж нэрлэдэг.

Усны хатуулгийн үндсэн эх үүсвэр нь тунамал чулуулгаас ууссан олон валенттай металл ионууд байдаг. Кальци болон магни нь ихэнх тунамал чулуулагт байдаг бөгөөд хамгийн түгээмэл эх үүсвэр нь шохойн чулуу болон доломит байдаг. Тиймээс газрын доорх ус нь гадаргын уснаас илүү хатуулагтай байдаг.

Байнгын хатуулаг нь ихэвчлэн усан дахь магни, кальцийн сульфат, хлоридоос хамаарна. Ундны усны стандартад зөвшөөрөгдөх дээд хэмжээг кальци 100 мг/л-ээс ихгүй, магни 30 мг/л-ээс ихгүй, усны нийт хатуулгийг 7 мг-экв/л гэж тус тус заасан байдаг. Харин үйлдвэрлэл, технологийн хэрэглээнд ашиглах усны хатуулаг түүнээс бага байх шаардлагатай байдаг. Тиймээс унданд хэрэглэж байгаа усны хатуулаг, кальци, магни өндөр байх нь хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Хүн амыг ундны усны чанарын шаардлага хангасан хатуулагтай усаар хангахын тулд хатуулгийг бууруулах, зөөлрүүлэх технологийг ашиглах шаардлагатай.


**Хатуулаг бууруулах:** Усан дахь хатуулгийг бууруулж, зөөлрүүлэхийн тулд ион солилцооны давирхай, урвуу осмос буюу электродиализ бүхий шүүлтүүр ашигладаг. Усны хатуулгийг бууруулж, зөөлрүүлэх аргыг сонгохдоо усны чанар болон түүнийг цэвэрлэх шаардлагатай түвшин, хэрэглэх нөхцөл зэргийг харгалзана.

**Манган:** Манган нь ундны усны байгалийн гаралтай химийн үзүүлэлтүүдийн нэг бөгөөд Монгол Улсад мөрдөгдөж буй ундны усны стандартад зөвшөөрөгдөх дээд хэмжээг 0.1 мг/л-ээс ихгүй гэж заасан байдаг.

Усан дахь манганы агуулга уст давхаргын литологи, геохимийн орчин, гүний усны урсгалын зам болон орших хугацаа зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Манган (Mn) нь pH 4-7-той ихэнх усанд зонхилдог боловч илүү өндөр исэлдүүлсэн хэлбэрүүд pH-ийн өндөр агууламжтай эсвэл микробын исэлдэлтийн үр дүнд үүсч болно. Хүчиллэг, исэлдэн ангижрах потенциал багатай гүний болон гадаргын усан дахь манганы агуулга өндөр байдаг. Усан дахь манганы ердийн хэмжээ нь 1-200 мкг/л байдаг бөгөөд тэдгээр нь ууссан Mn (II) эсвэл манганы ислийн жижиг хэсгүүд, hydroxides, болон карбонат хэлбэрт оршдог.

Ундны усан дахь манганы өндөр агуулга нь гоо сайхан болон эрүүл мэндийн асуудлыг үүсгэдэг. Ууссан манган (II) нь ус түгээлтийн шугамд наалдцыг үүсгэн хуримтлалыг бий болгодог.

**Манганы агуулгыг бууруулах, цэвэрлэх:** Гүний усан дахь манган нь ихэвчлэн ууссан нэгдэл хэлбэрээр байдаг бөгөөд түүнийг исэлдүүлэн уусдаггүй манганы оксид хэлбэрт шилжүүлэн катализаторын шүүлтүүр, калийн перманганатыг ашиглан исэлдүүлж шүүх, эсвэл рН-ийн өндөр агууламжтай коагулянт хийж шүүнэ.



Зураг 57. Усан дахь манган (Mn)-ыг цэвэрлэх бүдүүвч.

Ундны усан дахь манганы концентрацийг бууруулахад нийтлэг аргуудыг ашигладаг бөгөөд 0.05 мг/л -т хүрэхийн тулд исэлдүүлэх болон шүүж бууруулдаг. Манганыг маш тогтвортой хэлбэрт шилжүүлэн органик бодисуудтай нэгтгэж болох бөгөөд энэ тохиолдолд ердийн цэвэрлэгээний арга болох калийн перманганат болон хлороор исэлдүүлэн коагуляцид оруулан шүүнэ.

**Нитрат:** Нитрат нь усан дахь бохирдлыг илэрхийлдэг үзүүлэлтүүдийн нэг бөгөөд усан дахь ионыг тодорхойлсноор хөрсний үе давхаргаар шүүрэх үедээ ус хир их зэрэг эрдэсжсэн болохыг тодорхойлон үнэлдэг. Нитратын бохирдол нь гүний усны бэрхшээлүүдийн нэг бөгөөд мал аж ахуйн байгууламж, бохир ус зайлуулах систем, бордоо, тариалангийн талбай болон байгалийн гаралтай азотын эх үүсвэрээс үүсдэг. Нитрат нь уусдаг, сөрөг цэнэгтэй, өндөр хөдөлгөөнт чадвартай бөгөөд газрын доорх усанд хэдэн арван жилээр хадгалагддаг. Нитратын бохирдлын янз бүрийн эх үүсвэрийг тодорхойлох болон системийн динамикийг ойлгох нь гүний усны чанарын асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Монгол Улсын ундны усны стандартад нитратын зөвшөөрөгдөх дээд хэмжээг агуулгыг 50 мг/л -ээс ихгүй байхаар заасан байна. Нитратын өндөр агуулгатай усыг хэрэглэснээр хүнд сөрөг нөлөө үзүүлдэг ба метемоглобинемийн эрсдэл үүсгэж болзошгүй юм. Тиймээс унд, ахуйд хэрэглэгдэх усны нитратын бохирдлыг цэвэрлэх аргыг технологийг ашиглах нь зүйтэй юм.

**Нитратыг бохирдлыг цэвэрлэх, бууруулах:** Нитратыг уснаас ион солилцоо, урвуу осмос, электродиализ, биологийн аргаар нитратгүйжүүлэх болон мембран зэрэг аргаар цэвэрлэж болох бөгөөд бүх процессууд нь 10-13 мг/л-ээс доош агуулгатай болгон бууруулдаг. Эдгээр аргуудаас ион солилцоо болон мембран процесс нь жижиг усан хангамжийн хувьд илүү тохиромжтой байдаг. Ион солилцооны процесст нитрат ионыг хлорид эсвэл бикарбонат болгон солилцдог шүлтлэг анион солилцооны давирхай агуулсан давирхайгаар нэвтрүүлэн усан дахь нитратыг цэвэрлэдэг. Нитратыг солилцсон давирхайг натрийн хлорид болон натрийн бикарбонатын уусмалыг ашиглан нөхөн сэргээдэг.

**Төмөр:** Төмөр нь дэлхийн царцдас дахь түгээмэл тохиолддог металлуудын нэг юм. Төмөр нь усанд  $Fe^{2+}$ ,  $Fe^{3+}$ , төмрийн бактер, органик төмөр гэсэн 4 хэлбэрт байдаг.  $Fe^{2+}$  нь усанд ууссан хэлбэрт байх бөгөөд агаарт исэлдэж улаан хүрэн өнгөтэй жижиг хэсгүүд үүсэж эхэлдэг. Энэ нь  $Fe^{3+}$  төмөр буюу усанд уусдаггүй төмрийн тунадас үүсгэдэг. Харин төмрийн бактери нь эмгэг төрүүлэгч биш бөгөөд хөрс, гүний болон гадаргын усанд байдаг. Төмрийн бактер нь шугам хоолой, сантехникийн хэрэгсэл зэрэг усны системийн металл хэсгүүдэд ургадаг. Төмрийн бактери нь ихэвчлэн усанд ууссан эсвэл нялцгай хэлбэрээр илэрдэг бөгөөд хүрэн, улаан, цагаан өнгөтэй байдаг. Органик төмөр нь байгалийн янз бүрийн органик материалуудтай холилдож, органик нэгдэл хэлбэрээр оршдог. Энэ хэлбэрийн төмөр нь гүехэн худаг, гадаргын ус зэрэгт тохиолдох бөгөөд, ихэвчлэн шар эсвэл хүрэн өнгөтэй байдаг.

**Төмрийн ионыг бууруулах, цэвэрлэх:** Усан дахь төмрийн ионы агуулгыг бууруулахдаа дараах аргуудаас аль тохирохыг нь ашиглана.

- Ус зөөлрүүлэгч-Ион солилцоо
- Агааржуулалт хийж шүүх
- Шингээх исэлдүүлэх шүүлтүүр (greensand)
- Исэлдүүлэх болон шүүлтүүрээр шүүх (хлоржуулсны дараа шүүх)
- Урвуу осмос зэрэг аргуудыг ашигладаг.

Ус зөөлрүүлэгч-Ион солилцоо: Энэ процесс нь усан дахь хатуулаг болон  $Ca^{2+}$ ,  $Mg^{2+}$  зэрэг катионуудыг бууруулахтай ижил зарчмаар явагдана. Төмрийн бага агуулгатай усанд тохиромжтой бөгөөд төмрийн хуримтлал үүсэхээс сэргийлж ус зөөлрүүлэгч төхөөрөмжийг байнга угааж төмрийн давсыг зайлуулж байх шаардлагатай. Ус зөөлрүүлэгч дамжлагад орохоос өмнө хлоржуулж, дараа нь шүүнэ урьдчилан шүүлтүүрээр төмөр зайлуулах шаардлагатай.

Агааржуулалт хийж шүүх: Усанд агуулагдах төмрийн хэмжээ 10 мг/л-ээс их байх үед энэ аргыг хэрэглэх нь тохиромжтой. Энэ арга нь их хэмжээний хүчилтөрөгчөөр усыг үлээлгэж төмрийг уусдаггүй хэлбэрт шилжүүлж дараа нь шүүлтүүрээр шүүнэ. Энэ арга нь органик төмөр болон төмрийн бактериудад үр дүн муутай байдаг ба шүүлтүүрийг бөглөрөд хүргэдэг байна.

Шингээх исэлдүүлэх шүүлтүүр: Энэ аргыг төмрийн агуулга 10 мг/л хүртэлх агуулгатай усанд ашиглахад тохиромжтой. Ногоон элс, антрацит элс, байгалийн болон синтетик цеолит зэрэг холимог болон даралтат шүүлтүүрийг ашигладаг. Эдгээр шүүгч материалууд нь төмрийн агуулгыг сайн бууруулах чадвартай байдаг байна. Ус ногоон элс шүүлтүүрээр дамжин өнгөрөхөд уусдаг төмөр нь шүүлтүүрт шүүгдэж уусдаггүй төмөрт шилждэг байна. Шүүлтүүрт тунаж үлдсэн төмрийг байнга цэвэрлэж, тунадасыг зайлуулж байх шаардлагатай бөгөөд цэвэрлэхдээ калийн пермангантын уусмалыг хэрэглэх нь тохиромжтой байдаг байна. Калийн перманганат нь хүчтэй исэлдүүлэгч бодис бөгөөд усан дахь төмрийн хурдан исэлдүүлдэг байна. Төмөр, манган агуулсан усыг цэвэршүүлэхэд "ногоон элсэн" шүүлтүүрийн гол идэвхтэй бодис бол глауконит юм. Глауконит нь төмөр агуулсан, ион солилцооны шинж чанартай шаварлаг эрдэс юм.


Исэлдүүлж шүүх: Энэ арга нь усан дахь төмрийн агуулга өндөр үед (10 мг/л-ээс их) ашиглахад тохиромжтой. Төмрийг бууруулах энэ арга нь үндсэн 2 хэсэгтэй байна. 1-р хэсэгт хлор болон бусад хүчтэй исэлдүүлэгч бодисыг ашиглан уснаас төмрийн тунадас үүсгэдэг. 2-р хэсэгт үүссэн төмрийн тунадасыг элс зэрэг материалаар дүүргэсэн шүүлтүүрээр шүүнэ. Шүүлтүүрт үлдсэн төмрийн тунадасыг сайтар угааж цэвэрлэж байх нь шүүлтүүрийн ажиллагаа болон хэрэглээнд сайнаар нөлөөлдөг. Хлоржуулах системийг ашиглах нь усыг ариутгахаас гадна төмөр болон манганы бактерийг устгадаг байна. Энэ нь төмрийн бактерийг устгаснаар элсэн шүүлтүүрт үүсч болзошгүй бөглөрөлийг арилгадаг.

**Уран болон Радон:** Ус нь байгалийн гаралтай цацраг идэвхт элементүүдийг агуулж байдаг ба тэдгээрийн концентрацийн агуулга нь усны гарал үүслээс хамаардаг. Ундны усны усан хангамжид ихээхэн хамааралтай цацраг идэвхт элемент бол радон болон уран юм. Радон нь амархан задардаг, дэгдэмхий учраас ихэнхдээ хий болон уснаас ялгардаг. Хүчилтөрөгчийн дутагдалтай орчинд радоны задрал муу явагддаг байна.

**Уран:** Байгалийн гаралтай цацраг идэвхт элемент болох уран (U) нь задралын гинжин хэлхээгээр дамжуулан олон тооны цацраг идэвхт элементүүдийг бий болгодог. Уран нь байгальд +2, +3, +4, +5, +6 гэсэн валентын төлөвт байдаг бөгөөд байгальд ихэвчлэн  $UO_2^{2+}$  хэлбэрээр ихэвчлэн тохиолддог. Анхдагч эрдэс уранит ( $UO_2$ ) нь уусдаггүй боловч ус-чулуулгийн харилцан үйлчлэлээр илүү уусдаг  $UO_2^{2+}$  ион шилждэг. Мөн байгалийн гаралтай уран нь гурван төрлийн цацраг идэвхт изотоптой ( $^{234}U$ ,  $^{235}U$ ,  $^{238}U$ ) бөгөөд альфа болон гамма цацаргалтаар задардаг. Гүний усан дахь ураны агуулга нь тухайн газар нутгийн хөрс чулуулаг, литологи, геологийн нөхцөл болон усны pH, исэлдэн ангижрах потенциал, ууссан хүчилтөрөгч зэргээс ихээхэн хамаардаг бөгөөд хөрс, чулуулагт ураны агуулга их байвал усан дахь агуулга ихсэх боломжтой. Монгол Улсын ундны усны стандартад ураны агуулгыг 0.03 мг/л-ээс хэтрэхгүй байхаар заасан байдаг. Тиймээс унданд хэрэглэж буй усан дахь ураны өндөр агуулгыг бууруулах, түүнийг цэвэрлэх технологийг ашиглах хэрэгтэй.

**Ураны агуулгыг бууруулах, цэвэрлэх:** Ундны усан дахь ураны агуулгыг идэвхжүүлсэн хөнгөн цагааны исэл, анион солилцоо, нэрэх процесс, урвуу осмос зэрэг аргуудаар бууруулж болно. Уснаас ураныг цэвэрлэх нь ховор тохиолддог бөгөөд ион солилцоо, урвуу осмосын аргууд тохиромжтой юм. Ион солилцооны давирхай нь ураныг цэвэрлэх үр дүнтэй системийг бий болгодог.

**Радон:** Радон ( $^{222}Rn$ ) нь байгалийн гаралтай цорын ганц цацраг идэвхт хий бөгөөд уран агуулсан хөрс, чулуулаг, усан дахь ураны задралаас үүсдэг. Радон нь радигийн задралаас үүсдэг ба радон, ради нь уран ( $^{238}U$ ) задралын бүтээгдэхүүн юм. Ундны усанд радоныг цацрагийн идэвхт элементүүдийн аюулгүй үзүүлэлтийг хянаж байх үүднээс тодорхойлдог. Гүний усан дахь радоны хэмжээ гадаргын усан дахь радоны хэмжээнээс харьцангуй өндөр байдаг. Газрын доорх усны радоны өөрчлөлтөөр газар хөдлөлтийн идэвхтэй бүс нутагт газар хөдлөлтийг урьдчилан мэдэх бололцоотой ба ус хуримтлагдсан хугацаа, газрын доорх усны солилцоо зэргийг тодорхойлох боломжтой байдаг. Монгол Улсад мөрдөгдөж буй ундны усны стандартад радоны агуулгыг 100 Бк/л -ээс хэтрэхгүй байхаар заасан байдаг. Тиймээс унданд хэрэглэж буй усанд бууруулах, цэвэрлэх нь хүн амыг цацрагийн аюулаас хамгаалах чухал ач холбогдолтой .



Зураг 58. Ураны задрал

**Радоны агуулгыг бууруулах, цэвэрлэх:** Радоныг уснаас цэвэрлэх гурван үндсэн цэвэрлэгээний арга байдаг бөгөөд тэдгээрт хадгалалт, идэвхжүүлсэн нүүрсний нунтаг, хүчилтөрөгчжүүлэх зэрэг юм. Радоны атомын хэмжээ их байгаа тохиолдолд урвуу осмос, нанофилтрацийн аргаар арилгаж болно. Радон ( $^{222}\text{Rn}$ ) нь 3.82 хоногийн хагас задралын хугацаатай байдаг тул түүний агуулгыг бууруулахын тулд ус хураах санд хадгалж бууруулах боломжтой юм. Мөн идэвхжүүлсэн нүүрсний нунтгийг ашиглан радоныг 95% бууруулах боломжтой бөгөөд амт, өнгө, үнэр, синтетик органик химийн бодисыг арилгахад түгээмэл хэрэглэгддэг. Энэ нь шингээх чадвар дээр үндэслэгддэг бөгөөд идэвхжүүлсэн нүүрсний сүвэрхэг бүтэц нь түүний үр нөлөөг харуулдаг. Мөн хүчилтөрөгчжүүлэх нь радоныг зайлуулах хамгийн тохиромжтой цэвэрлэгээний арга бөгөөд радоныг гадны агаарт хялбархан нэвтрүүлэх боломжийг олгодог бөгөөд ингэснээр цацрагийн түвшин нэмэгдэхгүйгээс гадна хог хаягдал гардаггүй байна.

**Стронци:** Байгалийн стронцийг ундны уснаас зайлуулах судалгааны баримт материал хязгаарлагдмал байдаг ба стронций нь кальци болон баритай ижил физик, химийн шинж чанартай. Стронцийг адсорбци (манганы исэл) болон урвуу осмосын аргуудыг ашиглан бууруулах нь үр дүнтэй байдаг.

**Фтор:** Фтор нь олон төрлийн усанд илэрч болох боловч газрын доорх усанд илүү өндөр агуулгатай байдаг. Энэ нь тухайн газар нутгийн чулуулгийн төрлөөс хамааран өөр өөр байдаг. Усан дахь фторын агуулгыг эсрэг осмос, нано шүүлтүүр, кальци суурьтай эрдэс, хөнгөнцагааны оксид суурьтай шингээгч материал зэргийг ашиглан бууруулдаг байна. Фтор бууруулахад өргөн хэрэглэгддэг аргуудын нэг идэвхжүүлсэн хөнгөн цагааны оксид ( $\text{Al}_2\text{O}_3$ ) юм. Идэвхжүүлсэн хөнгөн цагааны оксид нь усны орчин рН 9.5-аас бага үед анионыг шингээх чадвартай, рН 9.5-аас их үед катионыг шингээх чадвартай байдаг. Усан дахь фторын агуулгыг бууруулах төхөөрөмж нь цэвэршүүлэх усны хэмжээ, фторын агуулга зэргээс ихээхэн хамаардаг.

**Хүнцэл:** Байгальд хүнцэл ихэвчлэн сульфат хэлбэрээр оршдог бөгөөд ус, хөрсөнд өндөр агуулгатай үед хүний тархи болон бие организмд бүхэлд нь сөргөөр нөлөөлдөг байна. Усан дахь хүнцлийг бууруулахад шингээх, тунадасжуулан шүүх, ион солилцоо, мембран шүүлтүүр гэсэн үндсэн 3 аргыг ашигладаг байна.

## 5.2. Усны чанарыг сайжруулах аргууд

**Коагуляци болон флокуляцийн** аргаар уснаас өнгө, булингар, замаг болон бусад бичил биетнийг устгахад ашигладаг. Усанд химийн коагулянт нэмэх нь тунадас, бөөгнөрөл үүсэх шалтгаан болдог. Тохиромжтой нөхцөлд төмөр болон хөнгөн цагааныг арилгаж болно. Тунадас, бөөгнөрөл нь тунадасжуулалт болон шүүлтүүрээр цэвэрлэгдсэн уснаас салдаг. Мөн тунгаах аргаар суспенздэгдсэн хатуу бодис болон булингарыг бууруулж болно.

**Хийжүүлэлт:** Дэгдэмхий органик нэгдэл, нүүрстөрөгчийн давхар исэл, халдваргүйжүүлэлтийн завсрын бүтээгдэхүүн, зарим амт болон үнэр үүсгэдэг нэгдэл, радон зэргийг хийжүүлэн цэвэрлэдэг. Энэ процесс нь хүчилтөрөгчийг ус руу дамжуулан дэгдэмхий нэгдлүүд болон хийнүүдийг арилгах зорилготой байдаг. Хүчилтөрөгчийн шилжүүлэлтийг нарийн тоног төхөөрөмжийн шаардлагагүйгээр энгийн аргаар агаарыг усруу оруулдаг. Мөн агааржуулах аргыг төмөр болон манганыг тунадасжуулах, исэлдүүлэхэд ашигладаг байна.


**Мембран процесс:** Ус цэвэрлэхэд хамгийн өргөн хэрэглэгддэг ач холбогдол бүхий мембран процессуудад урвуу осмос, хэт ягаан туяа, микро болон нано шүүлтүүрүүд ордог. Эдгээр ихэнхдээ процессуудыг үйлдвэрлэл болон эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ус үйлдвэрлэхэд ашигладаг байсан бол одоо ундны усыг цэвэршүүлэхэд ашиглаж байна. Мембран процесс нь эмгэг төрүүлэгч нян, Cryptosporidium, Giardia, вирус, бактер зэргийг устгах боломжтой.

**Микро шүүлтүүр** нь 0.05 мкм-ээс их хэмжээтэй жижиг хэсгүүд нэвчих чадвартай байдаг бөгөөд ихэнх бактер болон амебоидыг устгадаг. Ус цэвэршүүлэх процесст коагуляци болон идэвхжүүлсэн нүүрсний нунтагтай хослуулан вирус, бактер, ууссан органик нүүрстөрөгчийг арилгахад ашигладаг. Мембран микро шүүлтүүр нь ихэвчлэн 0.01-12 мкм нүх сүвэрхэг хэмжээтэй бөгөөд олон шатлал бүхий ус цэвэршүүлэх системд урьдчилан цэвэрлэгээ болгон ашигладаг.

**Ультра мембран** нь эсрэг осмосын зарчимтай ижил боловч мембран нь илүү том нүх сүвэрхэг байдаг бөгөөд ихэвчлэн 0.002-0.03 микрометр хэмжээтэй, бага даралтад ажилладаг. Ультра мембран нь 800-аас дээш молекул жинтэй органик молекулыг хүлээн авдаггүй бөгөөд 5 бараас бага даралтад ажилладаг .

**Нано шүүлтүүр** нь хэт ягаан туяаны мембран болон урвуу осмосын шинж чанар бүхий мембраныг ашигладаг. Нано шүүлтүүр нь натри болон кали зэрэг нэг валенттай ионыг нэвтрүүлдэг бол кальци, магни зэрэг хоёр валенттай ионууд болон 200-аас дээш молекул жинтэй органик молекулуудыг нэвтрүүлдэггүй. Нано шүүлтүүр нь өнгө болон органик нэгдлүүдийг арилгахад илүү үр дүнтэй бөгөөд ажлын даралт нь ихэнхдээ 5 бар байдаг.

**Урвуу осмос (RO)** нь хагас нэвчих шинж чанар бүхий мембраныг ашиглан ус цэвэршүүлэх технологи юм. Энэхүү мембран технологи нь яг шүүлтүүрийн арга биш бөгөөд урвуу осмос дээр термодинамик параметр болох химийн потенциалгаар нэгтгэх шинж чанартай осмос даралтыг ашигладаг. Хагас нэвчүүлдэг мембранаар дамжих осмос нь олон төрлийн молекул, ионуудыг уснаас зайлуулж, усыг цэвэршүүлдэг. Урвуу осмос нь усны бохирдолд байгаа металлын ион, хар тугалга, хүнцэл, фтор, радиум, сульфат, кальци, магни, кали, хром, зэс, нитрат, фтор, фосфор гэх мэт ионууд болон вирусуудыг цэвэрлэдэг байна. Урвуу осмос мембраны сүвэрхэг бүтэц нь маш нарийн бөгөөд нийт ууссан бодис, нэгдэл, бактери болон вирус зэрэг бохирдлыг 99% хүртэлх уснаас цэвэрлэдэг.



Зураг 59. Мембран шүүлтүүрийн харьцуулалт


**Идэвхжүүлсэн нүүрсэн шүүлтүүр:** Идэвхжүүлсэн нүүрс нь шингээх аргаар усан дахь бохирдуулагч бодисыг устгана. Идэвхжүүлсэн нүүрсний шингээх чадварт нүүрстөрөгчийн хэмжээ, төрөл, бохирдуулагч бодисын шинж чанар, агуулга, усны ерөнхий чанар болон төхөөрөмжид баригдах хугацаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Идэвхжүүлсэн нүүрсэн шүүлтүүр нь уснаас суспензлэгдсэн бодис, хлоржуулалтаас үүссэн завсрын бүтээгдэхүүн, пестицид, трихлорметан, усанд үүссэн булингар, амт, үнэр, зарим металл зэргийг арилгадаг.

**Халдваргүйжүүлэх:** Усан дахь эмгэг төрүүлэгч бичил биетнийг устгах, тэдгээрийг идэвхгүйжүүлэх зорилгоор халдваргүйжүүлэлтийг хийдэг. Гүний усанд микробиологийн




идэвх бага байдаг ба нүх сүв, ан цав зэрэг геологийн шинж чанар болон худгийн байгууламж, хамгаалалт зэрэг замаар гүний ус бохирдож болно. Халдваргүйжүүлэх олон арга байдаг бөгөөд хлороор халдваргүйжүүлэх арга нь томоохон хэмжээний усан хангамжийн системд өргөн хэрэглэгддэг бол хэт ягаан туяаны халдваргүйжүүлэлтийн арга нь жижиг усан хангамжийн системд илүү түгээмэл ашиглагддаг байна. Харилцан адилгүй бичил биетнүүдийг халдваргүйжүүлэх бодисууд нь өөр өөр байдаг ба тухайн бичил биетнийг халдваргүйжүүлэх нь халдваргүйжүүлэгч бодисын концентраци, барих хугацаа, тухайн бодисын хэрэгцээ, усны орчин, температур зэргээс хамаардаг.

**Хлороор халдваргүйжүүлэх:** Хлор нь цэвэр хлорын хий, натрийн гипохлорит эсвэл кальцийн гипохлорит хэлбэрээр усанд уусч гипохлорын хүчил (HOCl) ба гипохлоридын ион (OCl<sup>-</sup>) үүсгэдэг. Жишээлбэл, хлорын хий нь усанд хурдан уусч, анхандаа гипохлор ба давсны хүчил үүсгэдэг. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг халдваргүйжүүлэгч бодис хлор (Cl<sub>2</sub>)-ыг хэрэглэх үед усанд дараах урвал явагддаг.



Сул хүчил болох гипохлорын хүчил нь устөрөгчийн ион (H<sup>+</sup>) ба гипохлоридын ион (OCl<sup>-</sup>)-д задардаг:



Усан орчинд үүссэн HOCl болон OCl<sup>-</sup> -ийн аль аль нь халдваргүйжүүлэлтийн үүргийг гүйцэтгэдэг. Хлороор халдваргүйжүүлэхэд усанд түүний завсрын бүтээгдэхүүнүүд үлдэх боломжтой байдаг тул чанарт байнга хяналт тавьж байх хэрэгтэй.

**Хэт ягаан туяаны цацаргалтаар халдваргүйжүүлэх:** Энэ нь жижиг хэмжээний түгээлтийн системтэй, хадгалах хугацаа богино усан хангамжид тохиромжтой. Хэт ягаан туяаны ариутгалд усны чанар болон урсгалын хурд ихээхэн нөлөөлдөг. Халдваргүйжүүлэх ус нь өнгө, булингар багатай, сайн чанарын ус байх шаардлагатай. Хэт ягаан туяаг үүсгэхэд тусгай чийдэн ашигладаг бөгөөд зэвэрдэггүй ган болон хуванцраар хийсэн урвалжийн хэсэгт байрлуулдаг. Ихэвчлэн 254 нм долгионы урт үүсгэдэг мөнгөн усны чийдэнг ашигладаг. Хэт ягаан туяагаар халдваргүйжүүлэлтийг хийсний дараа үлдэгдэл завсрын бүтээгдэхүүн үүсдэггүй. Монохроматик хэт ягаан туяаны системүүд 254 нм хурдтай ажилладаг бол полихромат хэт ягаан туяаны системүүд нь өргөн хүрээний гермицидийн долгионы уртыг ашигладаг. Хэт ягаан туяаны цацаргалтаар халдваргүйжүүлэхэд үлдэгдэл завсрын бүтээгдэхүүн үүсдэггүй.


**Ион солилцооны арга:** Ионы солилцоо гэдэг нь хоёр электролит хооронд эсвэл электролитийн уусмал болон комплекс хооронд ион солилцох процесс юм. Ион солилцоо нь усан дахь ионуудын бохирдлыг бууруулах, цэвэршүүлэх, өндөр эрдэсжилттэй усыг цэнгэгжүүлэх, хатуулаг ихтэй усыг зөөлрүүлэхэд түгээмэл хэрэглэгддэг арга юм. Цеолит, тусгай ион солилцогч материалаар хийгдсэн ион солилцогч давирхай гэх мэт материалаар хийгдсэн ион солилцогчоор усан дахь илүүдэл ион болон эрдэсжилт, хатуулаг ихтэй усыг нэвтрүүлэн усны чанарыг сайжруулдаг. Ион солилцооны арга нь усыг зөөлрүүлэх физик-химийн аргад ордог бөгөөд эерэг цэнэгтэй ионуудыг солилцдог катион солилцогч болон сөрөг цэнэгтэй ионуудыг солилцдог анион солилцогч гэж ангилдаг. Ионит гэж нэрлэгддэг тусгай төрлийн бодис нь өөрийн найрлагад орсон катион анионы аль нэгийг усанд ууссан зарим бодисын катион, анионоор солилцсоноор усыг зөөлрүүлж, бохирдлыг бууруулдаг.

Ион солилцооны давирхайнууд нь ихэвчлэн сонгомол байдаг бөгөөд хүчиллэг болон шүлтлэг функционал бүлгийг агуулсан уусдаггүй полимер юм. Ион солилцогч полимер нэгдлүүдийг катион болон анион солилцооны давирхай гэж ангилдаг.

**Катион солилцооны давирхай:** Катион солилцооны давирхай нь ковалент холбоогоор холбогдсон сөрөг цэнэг бүхий функционал бүлэгтэй бөгөөд тэдгээр нь эерэг цэнэг бүхий ионуудыг солилцдог. Катионы ион солилцооны давирхайг стирол, дивинил

бензол болон сульфоны хүчлийн ко-полимержүүлэлтээр гарган авдаг бөгөөд сульфоны хүчлийн бүлгийг бензолын цагираг дээр (-SO<sub>3</sub>H) нийлэгжүүлдэг.

Катион солилцооны процессын механизмыг дараах урвалаар илэрхийлж болно.




R - ион солилцогч; A<sup>-</sup> - эерэг цэнэгтэй металл ион

Катион солилцооны функциональ бүлгүүд нь иончлогдсон үед ион солилцол явагддаг бөгөөд хүчиллэг болон сул хүчлийн төрөлд ангилдаг.

**Хүчиллэг катион солилцооны давирхай:** Энэ төрлийн давирхайнууд нь ихэнхдээ хүчиллэг шинж чанарыг үзүүлдэг бөгөөд сульфоны хүчлийн бүлгийн R-SO<sub>3</sub>H болон R-SO<sub>3</sub>Na-ийн аль алинд илүү өндөр ионждог. Ион солилцооны үр дүнд металлын давсыг хүчилд хувиргадаг. Хүчтэй хүчлийн давирхайн Na болон H нь усан орчны pH-ийн бүх мужид ион солилцол өндөр байдаг. Тиймээс хүчиллэг ион солилцлын давирхай нь уусмалын pH-аас үл хамааран ион солилцох чадвартай.

**Сул хүчиллэг катион солилцооны давирхай:** Ихэнх сул хүчлийн ион солилцогч нь карбоксил бүлэгтэй (-COOH) ба сул хүчлийн давсны катионуудыг устөрөгч ионоор солилцдог. Сул хүчиллэг ион солилцооны давирхай нь уусмалын pH-аас ихээхэн хамаарах бөгөөд pH нь 6-аас бага үед ашиглахад тохиромжгүй байдаг.

**Анион солилцооны давирхай:** Анион солилцооны давирхай нь эерэг цэнэг бүхий функционал бүлэгтэй бөгөөд тэдгээр нь сөрөг цэнэг бүхий ионуудыг солилцдог. Анион солилцооны давирхайг стирол-дивинилбензолын ко-полимержүүлэлтийн бензолын цагаригийг хлорметилалтжуулах замаар гарган авдаг. Анион солилцооны давирхайг ашиглах үед дараах урвал явагддаг.



B<sup>-</sup> ба Y<sup>-</sup> - анионууд болон сөрөг цэнэгтэй металл ионы комплексууд

Анион солилцооны давирхайг шүлтлэг болон сул шүлтлэг гэж ангилдаг.

**Шүлтлэг анион солилцооны давирхай:** Энэ төрлийн давирхайнууд нь ионжих чадвар өндөр бөгөөд хүчлүүдийн анионуудыг гидроксил ионоор солилцох чадвартай байдаг. Шүлтлэг анион солилцооны давирхай нь pH-ийн бүх мужид ион солилцдог бөгөөд усыг ионжуулах зорилгоор ихэнхдээ ашигладаг. Давирхайг ашигласны дараа нөхөн сэргээхдээ натрийн гидроксидын уусмалыг хэрэглэнэ.

**Сул шүлтлэг анион солилцооны давирхай:** Энэ төрлийн давирхай нь сул хүчлийн давирхайтай адилаар уусмалын pH-аас ихээхэн хамаардаг. pH нь 7-оос дээш үед ион солилцох чадвар буурдаг байна. Усыг ион солилцооны давирхай дундуур шүүж цэвэршүүлэх, зөөлрүүлэх бөгөөд усыг цэвэрлэх явцад чанар нь суларсан ион солилцогчийг дахин сэргээх шаардлагатай. Ион солилцогчийн сэргээх нь сийрэгжүүлэх, нөхөн сэргээх химийн бодисыг нэвтрүүлэх, зайлах гэсэн гурван шат дамжлагаар явагддаг.

**Сийрэгжүүлэх:** Энэ нь ердийн урсгалыг буцаан ион солилцогчийг сийрэгжүүлэх үйл явц бөгөөд олон төрлийн ууссан бодисыг угааж гадагшлуулах процесс юм. Энэ нь ион солилцогчийг нөхөн сэргээхээс өмнө хийгддэг.

**Сэргээх:** Ион солилцогчийг сэргээх үед катион солилцогч хамгийн багадаа 50%, анион солилцогч хамгийн багадаа 75% сэргээгдэх боломжтой байдаг. Ион солилцогч хэр сайн сэргээгдэх нь угаах усны температур, урсгалын хурд, ионы солилцогчийн нягтаршил зэргээс хамаарна. Ионы солилцогчийн багтаамж нь ашигласан нөхөн сэргээгч химийн бодисын хэмжээ, концентраци, солилцогчтой холбогдох хугацаа зэргээс хамаарч өөр өөр байдаг. Ион солилцогчийг сэргээхдээ ихэвчлэн давсны уусмалыг ашигладаг ба нөхөн сэргээлтийн цэвэрлэлтээс үүссэн хаягдал усыг бохирын системд нийлүүлэн хаядаг.

**Угаах, зайлах:** Нөхөн сэргээх үе шатанд ион солилцогчид илүүдэл сэргээгч уусмалын үлдэгдэл үлдэж болох бөгөөд түүнийг угааж зайлуулах хэрэгтэй. Ихэнхдээ нөхөн

сэргээх уусмалыг хэрэглэсний дараа ион солилцогчийг бага хурдтайгаар зайлж, үлдэгдэл уусмалыг арилгахын тулд илүү хурдтайгаар зайлж угаана.

### **5.3. Ус хадгалах савны хэрэглээ.**

Гэр хорооллын иргэд ус хадгалах сав сонгохдоо аль болох хуванцар савнаас татгалзах, хуванцар савны олон улсын тэмдэглэгээний дагуу хүнсний зориулалттай сав, зэвэрдэггүй хөнгөн цагаан сав, нержин хийцтэй сав зэрэг удаан ашиглагдах, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй сав сонгохыг тус тус зөвлөж байна.

Манай улсад зориулалтын бус хуванцар сав нь олдоц ихтэй, үнэ хямд байдгаас айл өрхүүд ундны ус, сүү, айраг зэрэг хүнсний шингэн бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэхэд өргөнөөр хэрэглэж байна. Хүнсний зориулалтын бус хуванцар саванд хонуулсан усны найрлагад төмөр 2 дахин, нитрит 11 дахин, аммиак 48 дахин их агуулагддаг байна. Хуванцар саванд хонуулсан сүүнд хар тугалгын агууламж стандартад зааснаас 3-4 дахин, айрганд 4.4 дахин их бөгөөд худалдааны захуудад худалдаалж буй хуванцар савны 44.9 хувь нь хуучин сав байгааг Эрүүл мэндийн яам анхааруулж байна.

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс хийсэн судалгаагаар хуванцар саванд хадгалсан усан дахь хар тугалга ДЭМБ-ын зөвлөмж хэмжээ болон Монгол Улсад мөрдөж байгаа стандартад заасан ЗДА-аас 60-800, формальдегид 1800-6900 дахин их байгааг тус тус тогтоожээ.

Хар тугалга нь хорт хавдрын эсийг идэвхжүүлж, оюун ухааны чадамжийг бууруулан, хоолны дуршил муутгаж, хоол боловсруулах эрхтэн системийн эмгэг үүсгэн, хүүхдийн өсөлт, хөгжлийг сааруулах аюултай. Формальдегид нь хоёрдугаар зэргийн аюултайд тооцогдох хортой шинж чанартай бодис бөгөөд гоо сайхан, хумс бэхжүүлэх бүтээгдэхүүн болон ариутгал, цэвэрлэгээний бодисын бүрэлдэхүүнд ордог, арьс салст болон амьсгалын замыг цочроох, арьсан дээр тууралт үүсэх эрсдэлтэй юм. Мөн поликарбонат агуулсан хуванцарт биспонел А бодис агуулагддаг бөгөөд энэ нь хүний биеийн гормон ялгаруулах үйл ажиллагаанд хор хөнөөл учруулдаг байна. Иймд хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, зориулалтын бус савны хор холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах, хүнсний зориулалтын бус савыг ахуйн зориулалтаар ашиглахгүй байхыг зөвлөж байна. Тиймээс хуванцар савны олон улсын тэмдэг, тэмдэглэгээний талаар зохих мэдлэгтэй байх нь чухал.

